



БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ



Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль (MSUA)
Монгол улсын Өвөрхангай аймаг
Японы Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны
Олон улсын судалгааны төв (JIRCAS)

2010 он

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨМЖ

(Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн судалгааны үр дүнд үндэслэв)

**Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль (MSUA)**

**Монгол улсын Өвөрхангай аймаг
Японы Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны
Олон улсын судалгааны төв (JIRCAS)**

2010 он

Гарчиг

Нэгдүгээр бүлэг

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмж

- 1.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмжийг боловсруулах нэхцэл байдал, үндэслэл
 - 1.1.1 Монгол орны мал аж ахуйн салбарт тулгамдаж буй зарим асуудлууд
 - 1.1.2 Бэлчээрийн мал аж ахуйн салбарт төрөөс баримталж буй бодлогуудын уялдаж буй байдал
 - 1.1.3 Бэлчээрийн газрын ашиглалтыг зохицуулж буй хууль эрх зүйн орчин
- 1.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийн зорилго
 - 1.2.1 Зорилго
 - 1.2.2 Зөвлөмжийн онцлог
- 1.3 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмжийн хамрах хүрээ
 - 1.3.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмжийн загвар
 - 1.3.2 Үйл ажиллагаа
- 1.4 Зөвлөмжийн ач холбогдол
- 1.5 Зөвлөмжийн бүтэц

Хоёрдугаар бүлэг

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах

- 2.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах үндсэн зарчим
- 2.2 Бодит байдлыг судлах
 - 2.2.1 Үндсэн баримт материалын судалгаа
 - 2.2.2 Бэрхшээлтэй асуудлыг тодруулж, дүн шинжилгээ хийх
- 2.3 Бие даасан үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх
 - 2.3.1 Бие даасан байдлыг дэмжих шаардлага
 - 2.3.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогчид ялангуяа малчид, орон нутгийн захиргааны бие даасан байдлыг дэмжих
- 2.4 Бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах
 - 2.4.1 Бүлэг болгон зохион байгуулахын ач холбогдол
 - 2.4.2 Бүлгийн зохион байгуулалтын зарчим
- 2.5 Чадавхийг бэхжүүлэх (CD)
 - 2.5.1 Малчдын чадавхийг бэхжүүлэх
 - 2.5.2 Засаг захиргааны ажилтны чадавхийг бэхжүүлэх

- 2.6 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах
 - 2.6.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах
үе шат
 - 2.6.2 Орон нутгийн захиргааны үүрэг
- 2.7 Хэрэгжүүлэх дараалал
 - 2.7.1 Ургамалшилтын судалгаанд үндэслэн малын тоо толгойд тохируулан бэлчээрийг хуваарилах
 - 2.7.2 Тухайн бэлчээрийг ашиглах малын зохистой тоо толгойг тодорхойлох
 - 2.7.3 Бэлчээр сэлгэн нүүдэллэх төлөвлөгөө гаргах
 - 2.7.4 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж холбогдох засаг захиргааны удирдлагуудтай зөвшилцөх

Гуравдугаар бүлэг

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт

- 3.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбоотой тогтоол, шийдвэр
- 3.2 Талууд хоорондын гэрээ болон төлөвлөгөөт нүүдлийн хэрэгжилт
- 3.3 Төлөвлөгөөний дагуу нүүх нүүдлийн хэрэгжилт

Дөрөвдүгээр бүлэг

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хяналт үнэлгээ

- 4.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааны үр дүнг харуулах хяналт шинжилгээ
- 4.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд хийх хяналт, үнэлгээ
- 4.3 Үнэлгээ хийх

Өмнөх үг

Японы Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны Олон улсын судалгааны төв (JIRCAS) нь Монгол улсад шар шороон шуурганы эх үүсвэртэй тэмцэх арга хэмжээний хүрээнд тухайн газар нутагт тохирсон усны нөөцийн ашиглалт болон ургамлын нөхөн сэргээлтийн үр дүнтэй арга технологийг буй болгохын зэрэгцээ орон нутгийн захиргааны мэргэжилтэн болон малчдын бэлчээр ашиглалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах чадварыг дээшлүүлэх зорилгоор малчдын оролцоогоор бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах (Шар шороон шуурганы эх үүсвэртэй тэмцэх арга хэмжээ)" судалгааг хэрэгжүүлж байна.

Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш малчин өрхийн тоо, малын тоо толгой ихээр өссөн. Ялангуяа ноолуураас шалтгаалж ямааны тоо толгойг ихээр өсгөснөөс мал сүргийн бүтцэд гэнэтийн өөрчлөлт гарсан. Түүнчлэн бэлчээр дэх ашиглах боломжтой худгийн тэнцвэргүй байдал болон малчид хот суурин газар болон төв замд ойр төвлөрөх болсон зэрэг шалтгаанаар орон нутгийн бэлчээр талхлагдах байдал үүсч байна. Эдгээр нь бэлчээрийн ургамлын чанар муудан ургамлын төрөл зүйлийн тэнцвэрт байдал алдагдах зэрэг ургамлын доройтол бий болж, шар шороон шуурга дэгдэх гол шалтгаан болж байна.

Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд малчдын биеэ даасан тогтвортой мал аж ахуй эрхлэх үйл ажиллагаагаар дамжуулан ургамлын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх болон малчдын тогтвортой амьжирагааг хангахад чиглэгдсэн цогц бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Тус судалгаа нь Өвөрхангай аймагт 2005 оноос эхлэн тухайн нутгийн захиргааны албан хаагчид болон малчдын байгалийн нөөц баялагтай холбоотой мэдлэг чадавхийг дээшлүүлэхийг зорьж, шар шороон шуурганы эх үүсвэртэй тэмцэх арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхийн тулд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж ирсэн.

Тус зөвлөмж нь энэхүү 5 жилийн судалгааны үр дүнг нэгтгэж, орон нутгийн захиргааны ажилчид болон малчид хамтран бэлчээр ашиглах төлөвлөгөөг боловсруулах дараалал, хэрэгжүүлэх аргачлалыг нэгтгэн гаргасан зүйл бөгөөд Монгол улсын мал аж ахуйн тогтвортой хөгжил болон байгаль орчныг хамгаалах зорилгоор холбогдох хүмүүс байгууллага авч ашиглана гэдэгт найдаж байна. Зөвлөмжийг Монгол улсын ХХААХҮЯам, ЗТБХТЯам, ХААИС, МААЭШХ зэрэг байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдийн ажлын хэсгийн баг хянан тохиолдуулсан бөгөөд улмаар МААЭШХүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан болно.

Энэхүү зөвлөмжийг боловсруулахад дотоод гадаадын олон

байгууллага, хүмүүс туслалцаа үзүүлсэн ба ялангуяа Япон улсын хөдөө аж ахуй, ой, усны яам, Монгол дахь Японы элчин сайдын яам, Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Монгол дахь салбар, Монгол улсын Хөдөө аж ахуйн их сургууль, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Зам тээвэр, барилга хот төлөвлөлтийн яам, Өвөрхангай аймаг, Өвөрхангай аймгийн Тарагт болон Баруун Баян-Улаан сум, мөн судалгааг хэрэгжүүлэхэд үнэтэй заавар зөвлөгөө өгсөн Япон дахь удирдах зөвлөл түүнчлэн судалгааг хэрэгжүүлсэн орон нутгийн малчдад гүн талархал илэрхийлье.

**Японы Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны Олон улсын судалгааны төв
Орон нутаг хөгжлийн судалгааны хэлтэс Ота Такэши**

2010 оны 3 дугаар сар

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмж

Орон нутгийн захиргаа нь малчидтай хамтран бэлчээр ашиглалтыг зохистой болгоход чиглэсэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулна. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмж боловсруулах арга барил, хэрэгжүүлэх зарчмыг бэлчээр ашиглалтын зөвлөмжид тусгана.

Ийнхүү тусгахдаа боловсруулах болсон үндэслэл, түүний зорилгыг тодорхой заах шаардлагатай.

Мөн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмжийн хамрах хүрээ, ач холбогдол, бүтцийн талаар тайлбарлана.

Агуулга

- Бэлчээр ашиглалтын зөвлөмжийг боловсруулах үндэслэл
- Бэлчээр ашиглалтын зөвлөмжийн зорилго
- Бэлчээр ашиглалтын зөвлөмжийн хамрах хүрээ, ач холбогдол

1.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмжийг боловсруулах нөхцөл байдал, үндэслэл

1.1.1 Монгол орны мал аж ахуйн салбарт тулгамдаж буй зарим асуудлууд

Монгол улс 1990 оны эхээр зах зээлийн эдийн засагт шилжиж нийгэмд гэнэтийн өөрчлөлт гарснаар мал аж ахуйн салбарт дараах нөхцөлүүд бий болсон:

1. Бүс, орон нутгийн хэмжээнд малажахуй эрхлэлтийн менежментийн чадавхи муудсан,
2. Ашиглаж болох бэлчээрийн худгийн тоо цөөрсөн,
3. Малын тоо толгойн өсөлт (ялангуяа ямааны тоо),
4. Шинэ малчин өрх, мал бүхий иргэдийн тоо өссөнөөр мал аж ахуй эрхлэх талаар туршлага хомс малчид олширсон,
5. Бэлчээрийн мал аж ахуйг тойрсон үйлдвэрлэлийн орчин ихээхэн өөрчлөгдсөн.

Мөн 1999, 2000 оны зуднаас болж малын тоо толгой маш их хорогдсон бөгөөд түүнээс хойш хоньтой харьцуулахад ямааны тоо толгой эрс өсч, улсын хэмжээнд ямааны тоо толгой хонины тоо толгойноос давснаар таван хошуу малын сүргийн бүтцэд гэнэтийн өөрчлөлт гарсан. Малын тоо ихээр өсч бэлчээр талхлагдаж эхэлснээс гадна өвсний гарц сайтай, худаг устай бэлчээрт нэг дор мал ихээр төвлөрснөөр шар шороон шуурганы дэгдэлтийг барьж байсан өвс ургамлын ургац доройтоож халцгай газрын эзлэх хувь их болсон нь шар шороон шуурга бий болох нэг гол шалтгаан болж байна.

Шар шороон шуурга нь Хятад болон Монгол улсын нутаг дэвсгэрээс

нэлээдгүй хэмжээгээр дэгддэг бөгөөд энэ нь газрын гадаргийн өнгө хүчтэй салхинд туугдан агаар мандалд хөөрч баруун зүгийн салхинд туугдан Зүүн Ази болон Зүүн хойд Азийн зарим газар нутагт хүрч улмаар цаашлан Япон болон Солонгосын хойгт хүрч байна. Сүүлийн жилүүдэд шар шороон шуурганы дэгдэх давтамж, хамрах хүрээ ихэсч байгаа бөгөөд үүнтэй уялдан зам тээвэр болон хүний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө урд урьдынхаасаа ихэссэн байна. Шар шороон шуурганы хор нөлөө нь зөвхөн Хятад, Монгол, Япон, Солонгос зэрэг улс орнуудад төдийгүй бус нутаг улмаар дэлхий нийтийн асуудал болж бидний нэн тэргүүнд анхаарах асуудлуудын нэг болоод байна.

1.1.2 Бэлчээрийн мал аж ахуйн салбарт төрөөс баримталж буй бодлогуудын уялдаж буй байдал

Монгол Улсын Их хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах 2003-2008, 2009-2015 онд тус тус баримтлах 2 үе шаттай бодлогод дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан.

Үүнд:

1. Бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон эрчимжүүлж, үйлдвэрлэлийн үр ашигтай, найдвартай тогтолцоог бүрдүүлэх
2. Бүсийн тулгуур төвүүд болон тариалангийн бус нутагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх
3. Инженерийн болон энгийн уурхайн худаг, уст цэгийг нэмэгдүүлэх, эзэмшил, ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ усны нөөцийн бусад эх үүсвэрийг зохистой ашиглах замаар хүн ам, малын усан хангамжийг нэмэгдүүлэх
4. Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж даацыг нэмэгдүүлэх, үлийн цагаан оготонотой механик болон биологийн агаар тэмцэх ажлыг өргөжүүлэх

1.1.3 Бэлчээрийн газар ашиглалтыг зохицуулж буй хууль эрх зүйн орчин

Монгол орны нийт газар нутгийн 80 хувийг бэлчээрийн бус нутаг эзэлдэг ба мал аж ахуйн салбарын бодлогыг хэрэгжүүлэхдээ газар ашиглалтын бодлоготой сайтар уялдуулах шаардлагатай. Монгол улсын бэлчээрийн газар ашиглалтын өнөөгийн нөхцөл байдал нь “Үндсэн хууль”, “Иргэний хууль”, “Газрын тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, Засгийн газрын тогтоол шийдвэрүүд, Газрын харилцаа геодези зураг зүйн газраас баталсан “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” зэрэг эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулагдаж байна.

Цаашид бэлчээрийн газрын ашиглалтыг боловсронгуй болгох чиглэлээр Хүнс, хөдөө ажахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Бэлчээрийн

тухай” хуулийг боловсруулан Монгол улсын Засгийн газарт өргөн бариад байна.

1.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах зөвлөмжийн зорилго

1.2.1 Зорилго

Бэлчээрийн зүй зохистой ашиглалт, хамгаалалтыг зөвхөн хуулиар зохицуулах нь бэрхшээлтэй юм. Өөрөөр хэлбэл бэлчээр ашиглаж буй малчид бэлчээрийг тогтвортой урт хугацаанд зөв зохистой ашиглахын ач холбогдлыг ойлгож ухамсарласнаар хууль эрх зүйн тогтолцоо хэрэгжих боломжтой юм.

Мөн монголын уламжлалт нүүдлийн соёл иргэншлийг хадгалан малчдын мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл, амьдралын чадавхийг дээшлүүлэхийн тулд одоо мөрдөгдөж буй “Газрын тухай” хууль болон шинээр боловсруулагдан хэлэлцэгдэж буй “Бэлчээрийн тухай хууль”-ийн төслийн хүрээнд иргэдийн оролцоотойгоор тухайн орон нутгийн онцлогт тохирсон бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж ашиглах нь үр дүнтэй юм.

Энэхүү зөвлөмж нь бэлчээрийг хамгаалах болон түүнийг тогтвортой урт хугацаанд ашиглах, бэлчээрийн мал аж ахуй эрхлэлтийн таатай орчинг бүрдүүлэх зорилготой бөгөөд малчид өөрсдөө болон тухайн орон нутгийн албан хаагчидтай хамтран бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах болон түүнийгээ хэрэгжүүлэх арга барилд суралцах, тэдний чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн болно.

Тухайнаймаг, ороннүүгийн ИТХ-аарсумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх бөгөөд сум, багийн удирдлагууд нь малчдын бүлгийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.2.2 Зөвлөмжийн онцлог

Өнөөг хүртэл донор байгууллагууд бэлчээр ашиглалтын менежменттэй холбоотой нэлээд олон зөвлөмж, гарын авлагуудыг боловсруулсан байна.

Гэвч эдгээрт доорх дутагдал ажиглагдаж байна:

- Зарим зөвлөмж, эмхэтгэлийн агуулга нь монгол орныг нийтэд нь ерөнхийлөн хамруулсан тухайн бус нутгийн онцлог, ялгааг харгалзан үзээгүй тул орон нутагтаа шууд авч ашиглахад учир дутагдалтай.
- Бэлчээрийн зураг, зураглал зэрэг нь жил бүрийн өөрчлөлт онцлогийг тусган шинэчлэн ашиглахад бэрхшээлтэй байна.

Мөн тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ёстой малчид болон орон нутгийн албан хаагчдыг хамарсан сургалт хангалтгүй, үйл ажиллагаа урт хугацаанд тогтвортой үргэлжлэх боломжгүй, бэлчээр ашиглалтын зургийн боловсруулалтын арга зүй тодорхой бус, мөн хамтын

менежментийн тогтолцоо ойлгомжгүй байна.

Эдгээр асуудлыг голлон анхаарч Өвөрхангай аймгийн байгаль, газар зүй, эдийн засгийн нөхцөл байдлаараа ялгаатай Тарагт, Баруунбаян-Улаан сумдад малчид болон орон нутгийн албан хаагчдыг хамруулсан бодит судалгаа явуулж, хэрэгцээ үр дүнг сайтар судалсны үндсэн дээр бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний нэгдсэн зөвлөмж боловсруулсан юм.

Энэхүү зөвлөмж нь аймаг, сумын захиргааны байгууллага, холбогдох албан хаагчид, малчдын саналд тулгуурлаж, тухайн орон нутгийн бодит байдалд нийцүүлэн боловсруулагдснаараа онцлогтой.


1.3 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмжийн хамрах хүрээ

1.3.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмжийн загвар

Бэлчээр ашиглахтай холбоотой асуудлууд нь цаг агаарын тогтвортгуй байдал, малчид болон албан хаагчдын ур чадвар, бэлчээрийн уст цэгийн хүрэлцээ хангамж, мөн улс, аймгийн түвшний бэлчээрийн мал аж ахуйн бодлоготой шууд холбоотой.

Тиймээс энэхүү бэлчээр ашиглалтын зөвлөмжинд дурдсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй нийцэх зүйл, малчдын ухамсар, мэдлэг чадамжийг дээшлүүлэхэд анхаарч, малчид болон орон нутгийн засаг захиргаа сайтар нэгдэн ажиллаж шийдвэрлэж чаддаг байх, мөн бусад бодлогод нийцүүлж ажиллах нь хамгийн үр дүнтэй явдал юм.

Бэлчээр ашиглалттай холбоотой олон асуудлыг нэгтгэж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөөр шийдвэрлэх боломжтой асуудлууд мөн өөр түвшинд өөр арга хэмжээгээр зохицуулах шаардлагатай асуудлуудыг бүдүүвч 1-1- т үзүүлэв.




Зураг 1-1

1.3.2 Үйл ажиллагаа

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь “Судалгаа-Төлөвлөгөө, Хэрэгжилт, Хяналт-Үнэлгээ” гэсэн үндсэн бүтцээр хэрэгжих бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явцтай уялдуулж энэхүү зөвлөмжийг ашиглах шаардлагатай.

Тус зөвлөмжийг өмнө дурьдсанчлан Өвөрхангай аймгийн хоёр суманд хийсэн судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан ба бусад орон нутгийн хувьд өөрийн онцлогт нийцүүлэх шаардлагатай хэдий ч энэхүү бэлчээр ашиглалтын зөвлөмжийн өрөнхий агуулга нь бусад орон нутагт ч тохирох талтай гэж үзэж байна.

Үйл ажиллагааны харилцан хамаарал



Зураг 1-2

1.4 Зөвлөмжийн ач холбогдол

Энэхүү зөвлөмжийг Японы Хөдөө аж ахуйн Шинжлэх ухааны Олон улсын судалгааны Төвөөс Монгол улсын ХХААХҮЯ, ХААИС болон Өвөрхангай аймагтай хамтран 2005 оноос эхлэн Өвөрхангай аймгийн хоёр суманд хийсэн судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан болно. Малчид болон орон нутгийн захиргааны албан хаагчдын чадавхийг бэхжүүлж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх явцад олж авсан мэдлэг, алдаа оноогоо эргэн харж дүгнэн нэгтгэсэн нь практик ач холбогдолтой юм. Мөн багийн түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахад

чиглэсэн хэдий боловч тухайн сумын бүх багт хэрэгжүүлснээр сумын түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хэрэгжих гэсэн шатлалаар хамрах хүрээгээ улам өргөжүүлэх боломжтойгоороо ач холбогдолтой юм. Иймээс багийн түвшинд боловсруулсан төлөвлөгөөнд бусад багуудад ч тулгамдаад буй асуудлуудыг тусгах нь уг төлөвлөгөөний хамрах хүрээ өргөжин тэлэхэд чухал нөлөөтэй. Ийнхүү тус зөвлөмжийг хэрэгжүүлснээр орон нутгийн бэлчээр ашиглалт төлөвлөгөөтэйгээр явагдах бүрэн боломжтой болно.

1.5 Зөвлөмжийн бүтэц

Бэлчээр ашиглалтын зөвлөмжийн ерөнхий бүтцэд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах арга, түүний хэрэгжилт, мөн хяналт-үнэлгээ багтах юм.

Зөвлөмжийн бүтэц

Хүснэгт 1.1

Бүлэг	Агуулга
1-р бүлэг	<p>Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зөвлөмжийн тухай</p> <ul style="list-style-type: none"> • Зөвлөмжийг боловсруулах болсон үндэслэл • Зөвлөмжийн зорилго • Зөвлөмжийн хамрах хүрээ • Зөвлөмжийн ач холбогдол • Зөвлөмжийн бүтэц
2-р бүлэг	<p>Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах</p> <ul style="list-style-type: none"> • Бодит байдалд дүн шинжилгээ хийх, үндсэн судалгаа • Бие даасан үйл ажиллагааг дэмжихийн ач холбогдол, шаардлагатай тал • Бие даасан үйл ажиллагааг хөгжүүлж, бэхжүүлэх • Бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах • Үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах
3-р бүлэг	<p>Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт</p> <ul style="list-style-type: none"> • Холбогдох талууд хоорондын гэрээ болон бэлчээр сэлгэх нүүдлийн хэрэгжилт
4-р бүлэг	<p>Бэлчээр ашиглалтын хяналт- үнэлгээ</p> <ul style="list-style-type: none"> • Хяналт-Үнэлгээ
Холбогдох материал	Өвөрхангай аймагт хэрэгжүүлсэн “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл”-ийн жишээ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа юун түрүүнд тухайн газар нутгийн байгаль, цаг уур, нийгэм, эдийн засгийн бодит байдлыг судалж, тулгамдаад буй асуудлуудыг тодруулж авах арга хэмжээг төлөвлөнө.

Мөн төлөвлөгөөг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлж, бие даасан үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгох, төлөвлөгөөг голлон хэрэгжүүлэгчид болох малчид болон бусад оролцогчдын мэдлэг, чадавхийг дээшлүүлснээр төлөвлөгөөг шат дараалалтайгаар хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөөнд тусгах асуудлуудын нэг бол бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулж, бүлэг дотроо хэлэлцэн бэлчээрийг хуваарьтай сэлгэж ашиглах төлөвлөгөөг боловсруулна. Үүний тулд бэлчээр ашиглагчдын бүлэг, орон нутгийн захиргаа, захиргааны ажилтны үргийг тус бүрд нь нарийвчлан гаргаж, хэрэгжүүлнэ.

Агуулга

1. Улс, аймаг, сумын түвшинд нийгэм, эдийн засгийн нөхцөл, байгаль, орчны байдлаас үүдэн гарах асуудлуудыг нарийн судалж, шийдвэрлэх арга зам, авах арга хэмжээг шийдэх
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогчдын бие даасан байдал, авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмждэг үзүүлэх
3. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах үе шат болон арга замыг тодорхойлох

2.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах үндсэн зарчим


- 1) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх явц

Малчид, орон нутгийн засаг захиргааны албан хаагчид хамтран бэлчээр ашиглалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үүднээс төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-үнэлгээ хийх гэсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүхий л шатанд идэвх зүтгэл гарган оролцно. Бэлчээр ашиглагчдын бүлэг бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний төслөө боловсруулж, уг төслөө багийн иргэдийн нийтийн хурал улмаар сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийж үйл ажиллагаагаа нэгтгэн дүгнэдэг байх зарчмаар ажилана. Үүний тулд малчид, сум болон багийн захиргааны албан хаагчдын чадавхийг дээшлүүлэх ялангуяа малчдыг бэлчээр ашиглалтын менежментээ боловсруулах, түүний ач холбогдлыг ухамсарлан ойлгоход нь анхаарах шаардлагатай.

2) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хамрах хүрээ

Тусудирдамж нь сум, багийн түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад зориулагддаг. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах явцад тухайн бүс нутгийн байгаль цаг уур, газар зүйн онцлог, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан багийн түвшинд шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудлууд тохиолдох нь элбэг.

Иймд бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулнаар анхан шатнаас гарах саналд тулгуурлан илүү бодит байдалд нийцсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх боломжтой бөгөөд энэ нь төлөвлөгөө амжилттай, үр дүнтэй хэрэгжих бас нэгэн чухал хүчин зүйл болох юм.



Зураг 2 1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах бүдүүвч

2.2 Тухайн бодит байдлыг нарийн судлах

Малчид дөрвөн улирлын онцлогт тохируулан шим тэжээлтэй бэлчээр нутгийг бараадан нүүдэллэж малаа өсгөн үргүүлдэг уламжлалт арга ажиллагаатайн зэрэгцээ бэлчээрийн мал аж ахуй нь ургамлын гарц, байгаль цаг уурын нөхцөлөөс шууд хамааралтай байдаг. Зах зээлийн эдийн засагт шилжснээр мал аж ахуй эрхлэлтээс үүдэлтэй сөрөг үр дагаварууд бий болсон. Тухайлбал:

- Мал маллах арга туршлагагүй иргэд мал аж ахуй эрхлэх нь ихэсч, бэлчээр сэлгэх асуудлыг үл тоомсорлох болсон.
- Зарим малчид малынхаа тоог хэт өсгөж бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх болсон.
- Худаг, уст цэгийн эзэмшил, ашиглалт эзэнгүйдсэнээс ашиглах боломжгүй худгийн тоо олширсонтой холбоотойгоор бэлчээр ашиглалт хязгаарлагдмал болсон зэрэг бэлчээрийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх асуудлууд гарч ирсэн.

Иймээс бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахын тулд малчдын оролцоотойгоор бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах асуудал нэн тустай болох нь тодорхой болсон байна.

2.2.1 Үндсэн баримт материалын судалгаа

Юуны өмнөдээрх асуудлуудыг зөв зохистойгоор шийдвэрлэхийн тулд улс, аймаг, сум болоод багийн түвшний байгаль, цаг уур, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой үндсэн баримт материалын төлөвлөгөөг үнлэслэн шаардлагатай судалгаа, дун шинжилгээг хийх шаардлагатай. Энэхүү судалгааны материалд дараах зүйлүүд хамрагдана.

Хүснэгт 2.1

Судлах шаардлагатай тоо баримт

Гарчиг	Цуглуулах судалгааны материал
1. Байгаль орчны шинжилгээ судалгаа	Цаг уурын ажиглалт, газар нутаг, усны нөөцийн судалгаа
2. Нийгэм, эдийн засаг	Хүн ам, өрхийн тоо болон малын тоо толгой
3. Засаг захиргаа	Технологи • Нэвтрүүлэх систем
4. Газар ашиглалтын байдал	Газар ашиглалтын өнөөгийн байдал, газар ашиглалтын талаарх хууль эрх зүйн зохицуулалт
5. Бэлчээрийн тогтолцоо	Бэлчээр ашиглах арга барил, мал аж ахуйн үйлдвэрлэлийн систем, тэжээлийн үйлдвэрлэл

(1) Байгаль орчны шинжилгээ судалгаа

1) Цаг уурын ажиглалт

Өнгөрсөн 10 жилийн байгаль, цаг уурын ажиглалтын баримт материалыг цуглуулах. Үүнд: Хур тунадасны сар, улирал, жилийн болон олон жилийн дундаж хэмжээ, температурын сар бүрийн олон жилийн дундаж гэх мэт.

- 2) Газар зүйн нөхцөл байдал
Төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн газар нутгийн газарзүйн онцлогыг тодорхойлох.
- 3) Усны нөөц
Худаг, ус ашиглалтыг тодорхойлоход дараах баримт материалыг ашиглана.

Хүснэгт 2.2

	Агуулга	Цуглуулах судалгааны материал
1.	Усны нөөц	Ус судлалын ажиглалт, усны сав газар, худгийн тоо баримт (гол горхи, харз, нуур, цөөрөм, худгийн байршлын зураг, ашиглалт), усны чанар
2.	Худаг ашиглалт	Худгийн төрөл (инженерийн хийцтэй, энгийн уурхайн), ашиглалтын байдал, (нийтээр ашигладаг эсэх, усаар хангагдаж байгаа өрх, малын тоо)
3.	Усжуулах байгууламж	Усжуулах арга, усжуулах талбай, үр тариа, хадлангийн үйлдвэрлэлд ашиглаж буй хэмжээ г.м

Усны нөөц баялаг

Одоогийн байдал

- Жилийн нийт хур тунадасны 60-70 хувь нь зуны гурван сард ордог бол хунгарлах цасны хэмжээ нь уулархаг нутгийн зарим хэсгээр 15 см хүрдэгийг эс тооцвол ерөнхийдөө 5-10 см зузаан. Нийт хур тунадасны ихэнх хувь нь агаарт ууршиж, сарнидаг байна. Үүнээс харахад хур тунадас нь бүгд хөрсний болон гүний усны нөөцөд нөлөөлдөггүй нь харагдаж байна.
- Монгол орны усны хэрэглээг авч үзвэл хүн амын 60 орчим хувь нь гүний усыг ундандаа хэрэглэж байна
- Монгол орны голуудын урсгал жилийн 200 орчим өдөр хэвийн байдаг бол үлдсэн хоногуудад үл ялиг татардаг байна. Жижиг голуудын талаар судалгаа баримт байдаггүй.
- Гүний усны түвшнийг ажиглан судалгаа хийдэг тухайлсан байгууллага байдаггүй учраас урт хугацааны ажиглалтын үр дүн гэхээр материал олддоггүй. Зарим нэг цаг уурын станц усны түвшингийн судалгаа эхлүүлж байгаа.

Усны чанарт хийх судалгаа

Хүн амын ундын усанд хэрэглэх худгийн усыг шинжилж судлах бөгөөд доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн эрдэс бодис, элементүүдийг заасан хэмжээгээр агуулсан байх ёстой.

Үндны усны чанарын стандарт үзүүлэлт

Үзүүлэлт	Стандарт хэмжээ
Хүчиллэг	5.8-аас их / 8.6-аас бага
Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ (бага өтгөрүүлэгтэй) мг/л	10-аас бага
Химийн хүчилтөрөгчийн хэрэгцээ мг/л	
Хатуулаг мг/л	300-аас бага
Шүйт мг/л	0.2-оос бага
Нитрат мг/л	(2-20 хооронд)
Нитрат азот мг/л	10-аас бага
Нитрит мг/л	(0 хэмжээнд)
Азот мг/л	0.05-аас бага
Төмөр (бага өтгөрүүлэгтэй) мг/л	0.3-аас бага
Цайр мг/л	1.0-ээс бага
Зэс мг/л	1.0-ээс бага
Хлорид мг/л	200-аас бага
Үндэслэл: ДЭМБ-аас гаргасан стандарт	

(2) Нийгэм, эдийн засгийн судалгаа:

Хүн ам, өрх

Малчин өрх, хүн ам зүй, малын тоо толгой, хот айлын тоо, байршлын зураглалын судалгаа гаргах

(3) Засаг захиргааны байгууллагуудын талаарх судалгаа:

Засаг захиргааны одоогийн бүтэц

Технологи • Нэвтрүүлэх систем

Малчдад мал аж ахуйн технологийг таниулж, нэвтрүүлж буй байдал болон ХАА-н мэргэжилтнүүдийн хүрэлцээ, малчдад хүрч үйлчилж буй байдал зэргийг судална.

(4) Газар ашиглалтын өнөөгийн байдал

Газар ашиглалт

1) Орон нутгийн газар ашиглалтын төлөвлөгөөг судлах (Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө)

2) Хууль эрх зүй

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох хүмүүст нийтлэг ойлголт, холбогдох мэдээллийг олгох үүднээс газрын харилцаа, газар ашиглалтын тухай болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн тухай таниулж ойлгуулна. Мөн газар өмчлөх, ашиглах зэрэг хуулиар олгогдсон эрхүүд хэрхэн хэрэгждэг болохыг судална.

Хүснэгт 2.4**Бэлчээр ашиглалтыг зохицуулж буй хууль эрх зүйн актууд**

Агуулга	Хуулиуд
Газар ашиглалт	Газрын тухай хууль, Газар өмчлөх тухай хууль, Бусад хуулиуд дахь бэлчээрийн тухай заалтууд
Эрдэс, баялагтай холбогдсон	Ашигт малтмалын тухай хууль, Усны тухай хууль
Бусад	Зах зээл хуваарилах аргачлал

Газрын тухай хууль

Газрын тухай хуулинд газар эзэмших, түрээслэх, ашиглах эрхийн талаар зохицуулж өгсөн бол газар өмчлөлийн тухай хуулинд иргэнд гэр бүлийн хэрэгцээнд болон газар тариалан эрхлэх зориулалтаар тодорхой нөхцөл болзолтойгоор хувьчлахыг зөвшөөрсөн байдаг.

Сумын газар ашиглалтын төлөвлөгөөний одоогийн байдал

Газрын тухай хуулиар газар ашиглалтын төлөвлөгөөг жил бүр боловсруулан гаргаж байхыг аймаг болон сумдад үүрэг болгосон байдаг. ГХГЗЗ-н газраас батлан гаргасан Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал нь дэлгэрэнгүй, тодорхой бөгөөд бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд маш их ашиг тустай материал юм. Гэвч уг аргачлалын дагуу төлөвлөгөө боловсруулахдаа ургамалжлын судалгаа зэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй хийх шаардлагатайн дээр GPS-ийн хэмжилт хийх зэрэг нэлээн нарийн тодорхой технологи ч шаардлагатай. Өвөрхангай аймгийн З сум болох Тарагт, Баруун Баян-Улаан, Хайрхандулаан сумдад хийгдэж байгаа газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах бодит нөхцөл байдалд судалгаа хийв. Эндээс үзэхэд сумд газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа удирдах байгууллагаас батлан гаргасан аргачлалыг тэр бүр нийтэд нь мөрддөггүй байна. Энэ нь сумдын өнөөгийн нөхцөл байдал, сумын түвшинд тохирох технологи, тоног төхөөрөмж, программ хангамж дутмаг, мэргэжилтнүүдийн ур чадвар зохиц түвшинд хүрэхгүй байгаатай холбоотой юм. Газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулсан ч үр дүнтэй хэрэгжүүлэхгүйгээр түүний ач холбогдол тодорхой харагдаргүй нь ойлгомжтой. Иймд багийн түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө зохион хэрэгжүүлж, улсаас батлан гаргасан ГЗБ төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тухайн орон нутгийн засаг захиргааны холбогдох албан хаагчид ашиглах замаар илүү үр дүнтэй хэрэгжих боломжтой төлөвлөгөөг боловсруулахтай холбоотой саналыг дор дурьдав.

- (1) Багийн түвшин дэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд үндэслэх
Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг бүх багийн бэлчээр ашиглалтын (газар ашиглалтын төлөвлөгөө) төлөвлөгөөнд үндэслэн улмаар сайжруулан, баяжуулж нэгтгэх шаардлагатай.
- (2) Судалгаа (анкет) –ны агуулгыг нэгтгэх
Төлөвлөгөө боловсруулах шатанд малчин иргэдээс авсан асуулга буюу судалгааны агуулгаас хараад жил бүр эргэж харан, засан сайжруулах шаардлагагүй зүйл, заалт ч олон байх тал харагдаж байна. Тухайлбал агуулгын хувьд урт хугацааны турш тодорхой өөрчлөлт гарахгүй зүйл, заалтын хувьд “10 жилд нэг удаа”, эсвэл “Өөрчлөх үед нь дахин хэлэлцэх” гэж оруулж болох юм.
Жишээ нь: Аялал жуучлалын газар, хог ялгах цэг зэрэг
- (3) Хяналтын хүрээг тогтоох
“Хамгаалалтанд авах шаардлагатай газар”, “Хортон, мэрэгчид ихэссэн газар” гэхчлэн нэрлэгдсэн тодорхойгүй газар орчныг хамгаалах хил заагийг тогтоох ба ер нь тухайн бус нутгийг бүхэлд нь хамгаалах шаардлагатай.
Жишээ нь: Шинээр нээхээр хүсэлт гаргасан уурхайг төлөвлөгөөнд тэмдэглэн оруулна. Бусад хууль бусаар олборлож буй газруудыг тухайн нутгийн захиргаа болон иргэдийн саналд үндэслэн төлөвлөгөөнд тусгах эсэхийг шийдвэрлэнэ.
- (4) Хийгдсэн судалгаануудыг эх сурвалж болгон ашиглах
Тарагт төдийгүй бусад ихэнх сумдад Дэлхийн банкны төслөөр боловсруулсан бэлчээр ашиглалтын зургийг үзэж болох ч ашиглах боломж бага гэж хэлж болно.
Бэлчээр ашиглалтын зурагт уртраг өргөрөгийг тэмдэглэхээс илүү газар усны нэрийг аль болох олноор тэмдэглэх шаардлагатай. Зурагт ургамалжлын мэдээлэл оруулсан бөгөөд түүний хил хязгаар цэгүүд болон худаг зэргийг тэмдэглэж ч болно. Ургамалжлын тухай мэдээллийг оруулах тохиолдолд ихээхэн өөрчлөлттэй биомассыг тэмдэглэсэн ч бараг ашиглагдахгүй учраас ургамлын зөвхөн хэв шинжийг тэмдэглэж оруулах нь илүү үр ашигтай бөгөөд удаан ашиглагдах боломжтой.

(5) Бэлчээрийн систем

1) Мал аж ахуйн өнөөгийн нөхцөл байдлын тухай

Малажахуйэрхлэлтийн өнөөгийн бодит байдлыг судлахад хүснэгтэнд дурьдсан баримт материал, мэдээ мэдээлэл шаардлагатай.

**Мал аж ахуй эрхлэлтийн бодит байдлыг
судлахад шаардлагатай материал**

Агуулга	Цуглуулах материал
(a) Бэлчээрийн мал аж ахуйн товч мэдээлэл	Малчин өрхийн тооны өөрчлөлт, малын тоо толгой, сүргийн бүтэц, мал аж ахуйн төрөл, байршил, малын борлуулалт, малын гаралтай бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, нэг хүнд ногдох малын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ, малын өвчлөл
(b) Мал маллагаа	Мал маллагааны онцлог, өвөлжөө, хаваржаа, зуслан намаржааны байршил, тэжээл хангалтын байдал, малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртөг
(c) Тэжээлийн нөөц	Бэлчээрийн төрөл, ургац, нэг хот айл ашиглаж буй бэлчээрийн газрын хэмжээ, мал бэлчээрлүүлэхийг хориглосон газар, тэжээлийн төрөл, аж ахуйн талбай, өртөг

(a) Бэлчээрийн мал аж ахуйн товч мэдээлэл

Орон нутаг тус бүрээр малчин өрхийн тооны өөрчлөлт, борлуулах малын тоо толгойн өөрчлөлт, малын гаралтай бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, нэг хүнд ноогдох малын гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ, мөн малын гаралтай бүтээгдэхүүний зах зээл дэх эргэлтийн хэмжээг тодруулах, малын өвчлөл гарч байсан бус нутгийг тогтоох

(b) Мал маллагаа

Мал үржүүлэг, ашиг шим, тарга хүчний шалгуур үзүүлэлт зэргийг судалж, бэлчээр ашиглалт, хавар, зун, намар өвлийн улиралд бэлчээрээ сэлгэж ашигладаг талаар тодруулах

(c) Тэжээл үйлдвэрлэл

Малын тэжээлийн үйлдвэрлэл, хэрэглээ, нөөцийн талаар мэдээлэл цуглуулж дүгнэлт хийх

Бэлчээрийн ургамлын өөрчлөлт

Монголын өвс, ургамлын төрөл зүйл бэлчээрийн мал аж ахуйтай хамааралтай явж ирсэн. Өвсний өндөр нь 4 см, түүнээс тачир өвстэй тал газар өвс ургамлын төрөл бага байдаг гэж үздэг. Үхрийн идэх өвсний өндөр 5 см орчим байдаг бол ямааных 3 см. Ямаа нь бэлчээрийг сүйтгэхэд ихээхэн нөлөө үзүүлдэг байна.

Зорилт

Монгол улсын мал аж ахуйн салбарын зорилтын талаар 2003 онд Улсын Их Хурлаас батлан гаргасан “Засгийн газраас хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх бодлого” (2003-2015 он) (Засгийн газрын тогтоол №. 29/2003) –д тусгасан байдаг.

2.2.2 Бэрхшээлтэй асуудлыг тодруулж, дүн шинжилгээ хийх

Бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг тогтоно.

Орон нутгийн (аймаг, сум, баг) удирдлагад хандах, малчдыг оролцуулсан уулзалт санал асуулга зохион байгуулах тухайн газарт явуулсан нарийвчилсан судалгаанд тулгуурлан бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлно.

Хүснэгт 2 6

Бэрхшээлийг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг нэгтгэх жишээ

№	Агуулга	Төрөл	Бэрхшээл	Арга хэмжээ
Байгалийн нөхцөл	Байгаль орчин	<ul style="list-style-type: none"> Байгаль орчин Цаг уур Газрын гадаргуу Хөрс Усны нөөц 	<ul style="list-style-type: none"> Өмнөд хэсгээрээ ургамлын бүрхэц тааруу Улаараа бараг модгүй Хойд хэсгээрээ усгүй 	<ul style="list-style-type: none"> Өмнөд хэсгээр мал бэлчээрлүүлэхийг багасгах Отрын бэлчээрийг хамгаалах
	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орчин	<ul style="list-style-type: none"> Газар ашиглалт Газар тариалан Мал сүрэг Бэлчээр ашиглалт Тэжээл үйлдвэрлэл 	<ul style="list-style-type: none"> Ихэнхдээ бэлчээрийн зориулалтаар ашиглагддаг Уламжлалт бэлчээр ашиглалтаас татгалзах Ган зудад нэрвэгдэх 	<ul style="list-style-type: none"> Бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглах Үр ашигтай бэлчээр ашиглалтыг хөгжүүлэх Нэмэгдэл тэжээл, бэлчээрт усны нөөц бий болгох
Нийгмийн нөхцөл	Нийгмийн байдал	<ul style="list-style-type: none"> Засаг захиргааны бүтэц Хөдөө аж ахуйн байгууллага Орон нутгийн зохион байгуулалт Хөдөө аж ахуйн техник үйлчилгээ Хүнсний хангамж Удирдах байгууллага Сум, багийн манлайлажийг сонгох 	<ul style="list-style-type: none"> Тариаланч, малчдын эвсэл байхгүй Орон нутгийн зохион байгуулалт тааруу 	<ul style="list-style-type: none"> Малчдын бүлэг байгуулах Захиргааны удирдлагыг хөгжүүлэх
	Хүний нөөц	<ul style="list-style-type: none"> Хүн ам зүй Боловсролын түвшин Насны ангилал Малчин өрхийн бүтэц, ажил эрхлэлт Хүнсний тэжээллэгийн байдал Эрүүл мэнд 	<ul style="list-style-type: none"> Бодит баримт мэдээлэл дутмаг Бэлчээрийн тухай мэдлэг тааруу Технологи, ур чадвар тааруу 	<ul style="list-style-type: none"> Сургалт зохион байгуулах
Материаллаг хөрөнгө	Материаллаг хөрөнгө	<ul style="list-style-type: none"> Материаллаг хөрөнгө Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн дэд бүтэц Зам, ус, цахилгаан, холбоо гэх мэт дэд бүтэц Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн материал хангамж Эмнэлгийн тоног төхөөрөмж 	<ul style="list-style-type: none"> Бэлчээрт хашаа, хайс дутмаг Бүтээгдэхүүн нөөцлөх Агуулах, хөргөгч зэрэг дутмаг Худаг засварлах Сайн үүлдрийн мал дутмаг 	<ul style="list-style-type: none"> Технологи дамжуулах Дэд бүтцийг хөгжүүлэх Малын үүлдэр угсааг сайжруулах Худаг засварлан шинэчлэх
	Санхүүгийн нөөц	<ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйн санхүүжилтийн систем Малчин өрхийн санхүүгийн хуримтлал Орлогын эх үүсвэр 	<ul style="list-style-type: none"> Хөрөнгө мөнгө дутагдалтай Банкнаас зээл авах шаардлага 	<ul style="list-style-type: none"> Орлогын эх үүсвэр бий болгох

2.3 Бие даасан үйл ажиллагаа явуулахыг дэмжих

2.3.1 Бие даасан байдлыг дэмжих шаардлага

Бэлчээр хамгаалах үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахын тулд уг үйл ажиллагааг хэрэгжүүлэгчийг бие даан ажиллахад нь дэмжлэг үзүүлэхэд чухалчлан анхаарах шаардлагатай.

Жишээ нь: Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахын ач холбогдлыг малчид болон засаг захиргааны удирдлагууд сайн ойлгоогүй байгаа тохиолдолд тэрхүү арга технологийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Хэрэгжүүлэгч байгууллагаас дээрээс доошоо босоо тогтолцоогоор малчдад дэмжлэг үзүүлэх тохиолдолдэнэхүү үйл ажиллагаа хэрэгжээд явах боломжтой ч тусламж дэмжлэг зогсвол тогтвортой үйл ажиллагаа үгүй болно.

Бие даасан байдлыг дэмжих гэдэг нь “Малчдын удирдлагыг хөгжүүлэх” гэсэн үг юм. Бие даасан бэлчээр ашиглагчдын бүлэг, малчид өөрсдөө төслийн хэрэгжилтэнд үнэлгээ өгөх бөгөөд төслийн үр дүнг тогтвортой үргэлжлүүлэхийн тулд бүлгийн гишүүд хоорондоо зөвшилцсний үндсэн дээр хэрэгжилтийн явцад нь улам боловсронгуй болгох боломжтой бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг гаргана. Малчдын бүлгийн бэлчээр ашиглалтын менежментийн чадавхийг сайжруулахад шаардлагатай бас нэг зүйл нь “Сайн дурын манлайллагч”-ийг сургах явдал юм.

Бие даасан ажиллагааг дэмжихийн тулд тусламж хүлээн авагчийн хүсэлтээр тусламжынхаа агуулгыг тогтоох ба хэрэгжүүлэгч байгууллага нь бүгдийг нь дэмжих биш харин харилцан гүйцэтгэх үүргийг тодорхой болгож малчдын саналыг харгалзан тодорхой үүрэг хүлээх нөхцөл болзолжтойгоор хэрэгжүүлнэ.

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний тулгамдаж буй бэрхшээлтэй тал

Одоогийн байдал

Бэлчээрийн ургамлыг нөхөн сэргээх үйл ажиллагаа Монгол улсын засгийн газар болон гадаадын дэмжигч байгууллагуудын дэмжлэгээр хэрэгжиж ирсэн бөгөөд үйл ажиллагаа дууссаны дараах орон нутгийн тогтвортой үйл ажиллагааны хэрэгжилт дутмаг байдалтай байна. Үйл ажиллагаа тогтвортой хэрэгжиж чадахгүй байгаагийн гол шалтгааныг дор дурьдвал:

(1) Үйлажиллагааг хэрэгжүүлэгч болох орон нутгийн захиргааны албан хаагчид болон малчдад зориулсан сургалт дутмаг, баримт мэдээллийг шинэчлэх боломжгүй байдгаас урт хугацаанд тогтвортой үргэлжилдэггүй.

(2) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулалт болон дэд бүтцийн боломжийг бүрдүүлэх төлөвлөгөөг удирдлагын дээрээс доошоо босоо тогтолцоогоор хэрэгжүүлж, хэрэгжилтийн ач холбогдол, үрдүн, ашиг тусыг малчид, захиргааны албан тушаалтан нар сайтар ойлгоогүйгээс үйл ажиллагааг бие даан тогтвортой хэрэгжүүлж чаддаггүй.

2.3.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний бие даасан байдлыг дэмжих

(1) Оролцооны хэлбэрийг хөгжүүлэх арга, үйл ажиллагаа

Бие даасан байдлыг бэхжүүлэхийн тулд төлөвлөгөө боловсруулах болон хэрэгжүүлэх арга хэмжээний бүхий л шат, түвшинд малчдын оролцоо маш их шаардлагатай. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахаа өнөөгийн бодит байдлыг сайтар судалж мэдсэн байх, одоогийн дутагдалтай талуудыг арилгаж цаашид баримтлах бодлого чиглэлийг хэлэлцэх, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг зохиох, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үнэлгээ зэрэг бүх шатанд малчдын оролцоог идэвхжүүлэх шаардлагатай нь бие даасан байдлыг бэхжүүлэхийн гол үндэс болж байна. Малчдын оролцоо нь бүх үйл ажиллагаанд чухал болохыг малчид хүлээн зөвшөөрсний үндсэн дээр тухайн ажил хэрэгжиж, удаан хугацаанд тогтвортой үргэлжлэх боломжтой болно. Малчдын оролцоог идэвхжүүлэхийн тулд бүх холбогдох хүмүүсийн санал, зөвлөгөөнд үндэслэн оролцогч талууд хоорондоо өргөн хэлэлцүүлэг хийх, энэхүү хэлэлцүүлгээрээ үйл ажиллагааны чиглэлээ тогтоож хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл оролцогчдыг сургалтад хамруулах явц, хамтрагчидтайгаа хэлэлцсэн процессыг хэрэгжүүлэхдээ удаан хугацааны тогтвортой байдлыг хангаж ажиллахад гол анхаарлаа хандуулах шаардлагатай гэсэн үг юм.

(2) Иргэдийн оролцоог хөгжүүлэхийн ач холбогдол

Иргэд төслийн үйл ажиллагаанд оролцох тохиолдолд хэн, хэзээ, ямар хэлбэрээр, оролцох вэ гэдэг нь чухал. Төсөлд иргэдийн оролцоо шаардлагатай. Гэвч ямар хэлбэрээр оролцсон бэ гэдгийг үнэлж, дүгнэх хэрэгтэй. Бүхий л түвшинд иргэд идэвхтэй оролцож, тэрхүү үйл ажиллагаа нь цаашид тогтвортой үргэлжилж чадах уу, үгүй юу гэдгээс бие даасан байдлыг дэмжихэд чиглэж явагдсан тухайн ажлын үр дүнг шийдвэрлэнэ.

Иргэдийн оролцоог дэмжихэд доорхи зүйлсийг анхаарах шаардлагатай.

- Оролцоог үр дүнтэй бөгөөд үр ашигтай байхад анхаарах
- Оролцогчдын ижил тэгш байдлыг анхаарах
- Оролцогчдын чадавхийг дээшлүүлэх
- Тогтвортой үргэлжлэх бололцоогоор хангах

2.4 Бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах

2.4.1 Бүлэг болгон зохион байгуулахын ач холбогдол

Бэлчээр ашиглалтыг сайжруулах чиглэлээр өнөөг хүртэл Дэлхийн банк зэрэг гадны олон донор байгууллагууд ажиллаж байна. Гэвч бодит байдал дээр түүний үр дүнг тогтвортой үргэлжлүүлж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй уялдуулж ажиллаж чадахгүй байна. Иймээс

үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй үргэлжлэх нөхцөлийг хангах систем шаардлагатай.

Монголд баг болж ажиллахаас илүү малчин өрх бүр дангаараа бэлчээр ашиглаж ирсэн уламжлалтай. Социалист нийгэм задран унасны дараа ХАА-н нэгдэл үгүй болж, бэлчээрийг хувь хүн бүр чөлөөтэй ашиглах болсон. Зарим малчид малынхаяа тоо толгойг улам бүр өсгөж байна. Энэ нь төрөөс малын тоо толгойг барих зохицуулалт хийх бодлого ч дутмаг байгаатай холбоотой. Хувь хүн бүр бэлчээрийг эмх замбараагүй ашиглаж, олон малтай малчид бэлчээрийн даац хэтрүүлэн, бэлчээрийн ургамлын чанар муудаж, гарц доройтохын гол шалтгаан нь болж бусад малчид хоорондын зөрчилдөөнийг бий болгож байна. Иймд өвөлжөө, хаваржааны бэлчээрийг бэлчээр ашиглагчдын бүлэг хоорондын маргаан үүсгэхгүй байхаар төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа дээрх байр сууринаас хандаж, малчид хоорондоо бүлэг байгуулан, асуудлыг дотроо хэлэлцэн шийдвэрлэх замаар явах нь маш чухал юм.

Жилийн аль нэг буюу хэд хэдэн улиралд нэг дор нутаглаж, бэлчээрийн аль нэг нөөцийг хамтран ашиглаж, хамгаалах нийтлэг ашиг сонирхол бүхий тодорхой тооны малчин өрхийн нэгдлийг бэлчээр ашиглалтын бүлэг гэнэ (Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалд тодорхойлсоноор).

Бүлэг нь эхний ээлжинд өөрсдийн бэлчээр ашиглалттай холбоотой асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, бодлогыг хэлэлцэх шаардлагатай. Үүнийг бүлэг хоорондоо зохицуулснаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа амжилттай хэрэгжинэ.

Бүлэг болгон зохион байгуулах нь дараах ач холбогдолтой:

- Бэлчээр болон байгалийн нөөцийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол цөм болно.
- Малчдын мэдлэг, чадавхи арга туршлагыг нэгтгэх нөхцөл бүрдэнэ.
- Бие даасан байдлыг дэмжснээр малчид нэгдмэл болно.
- Үйл ажиллагааг үнэлэх боломжтой нэгж болж чадна.
- Мэдээлэл дамжуулах боломжтой нэгж болж чадна.

2.4.2 Бүлгийн зохион байгуулалтын зарчим

Бүлэг зохион байгуулах явцдаа үйл ажиллагааг нь үр бүтээлтэй хэрэгжихэд нь анхаарч дараах зүйлүүдийг харгалзах нь зүйтэй:

- Зөвхөн гэр булээрээ нэгдэж бүлэг болохгүй байхад анхаарах
- Газар нутгийн хувьд зэргэлдээ байх, өөрөөр хэлбэл өвөлжөө хаваржaa, хот айлаараа нэгдэж бүлэг болох
- Ижил үйл ажиллагаа явуулдаг малчдыг нэг бүлэг болгох
- Бүлгийн гишүүд цуглахад хялбар байхыг бодолцож зэргэлдээ ойрхон нутагладаг малчдаас бүрдүүлэх

Мөн бүлэг байгуулахдаа бүлгийн үйл ажиллагааг чиглүүлэх үүрэгтэй манлайллагч малчны мэдлэг чадварыг дээшлүүлж, бэлчээр ашиглалтыг урт хугацаанд тогтвортой үргэлжлэх тал дээр анхаарч ажиллаж хүрээндээ үзүүлэх үр нөлөөллийг нь нэмэгдүүлэхэд голлон анхаарна.

2.5 Чадавхийг бэхжүүлэх (CD)

Удирдлагын дээрээс доош чиглэсэн тогтолцооны хэлбэрээр хэрэгжүүлснээр гадны дэмжлэгээр хэрэгжих төсөл дууссаны дараа үйл ажиллагаа нь тогтвортой үргэлжлэх боломж муутай байх асуудал гардаг. Тогтвортой үргэлжлэх боломжийг хангахад зайлшгүй гол хүчин зүйл болдог иргэдийн оролцооны хэлбэр, аргачлалыг нэвтрүүлэх нь дутагдалтай байгаа талаар өмнө дурдсан билээ. Иймээс төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээний бүхий л үе шатанд иргэдийн оролцооны хэлбэр, аргачлалыг нэвтрүүлэх нь зүйтэй. Үйл ажиллагааны тогтвортой үргэлжлэх нөхцөл байдлыг бий болгоход анхаарч “Үйл ажиллагаанд оролцогчдод хамтран ажиллах болон нэгдмэл үйл ажиллагааны давуу талын талаар таниулж ухамсарлуулах мөн төслийн төлөвлөлт, хэрэгжилт болон үнэлгээний чадавхийг бэхжүүлэх” явдал юм. Төсөл хэрэгжүүлснээр үр шимийг хүртэгч малчид болон төслийг хэрэгжүүлэгч засаг захирагааны удирдлагыг хэрхэн чадавхижуулах талаар доор өгүүлэх болно.

2.5.1 Малчдын чадавхийг бэхжүүлэх

(1) Чадавхи бэхжүүлэх үе шат

1) Малчдын оролцоо

Өнөөгийн бодит байдалд хийх дүн шинжилгээ зэргийг малчдын оролцоотойгоор гүйцэтгэж, байгалийн нөөцийн менежментэд санаа тавих, байгал, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах, ашиглах гол эзэн нь малчид өөрсдөө болохыг ойлгуулна.

2) Төлөвлөлт, хэрэгжилт, үнэлэмжийг малчид бие дааж хэрэгжүүлнэ.

3) Ойр орчмын бүс нутгуудад үзүүлэх үр дүн, нөлөө

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг бие даан гүйцэтгэж чадахуйц болж жигдэrsэн бүлэг нь бусад орон нутгийн бүлгүүдэд мэдлэг чадвараа түгээх шаардлагатай. Малчнаас малчинд гэсэн хэлбэрээр бусад орон нутгийн малчдад арга туршлагаасаа хуваалцах замаар экологийн нөхөн сэргэлтийг дэмжих бэлчээр ашиглалтын менежментийг хэрэгжүүлэх нь зүйтэй.

(2) Бүлгийн ахлагчыг чадавхижуулах

Бие даасан байдлыг дэмжиж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахын тулд малчдын бүлгийг удирдан, бусад бүлэгтэй харьцах чадвар бүхий ахлагчийг бэлтгэх шаардлагатай. Энэхүү ахлагч нь тухайн бүлгийг нэгтгэх чадвартай байх ёстой. Ахлагчийг төсөл хэрэгжүүлэгч болон гадаадын байгууллагын мэргэжилтнүүдийн сургалтанд хамруулна. Ахлагч нь бүлгийн гишүүдийн саналаар сонгогдох нь тохиромжтой.

(3) Үйл ажиллагааг удирдан чиглүүлэгчдэд тавигдах шаардлагууд Ахлагч нь уламжлалт “Удирдлагын дээрээс доош босоо тогтолцоо” буюу “Дарга цэрэг” гэсэн сэтгэлгээнээсээ салах шаардлагатай. Сайн чиглүүлэгч болохын нөхцөл шаардлагуудыг доор дурдьдвал:

- Хүмүүст итгэх, хүмүүсийн чадварт итгэх
- Харилцан итгэлцлийн уур амьсгалыг бий болгох
- Тэдэнд тохиолдож буй зовлон бэрхшээлийг нь сонсож ойлгож чаддаг байх
- Өөрийн чадварын түвшинг мэдэрч байх, үргэлж суралцах эрмэлзэлтэй байх
- Өөртөө итгэх нь чухал ч онгиж сагсуурах байдлаар хандахгүй байх
- Хүмүүсийн саналыг хүндэтгэн, өөрийн үзэл бодлыг бусдад тулгахгүй байх
- Бүтээлч сэтгэлгээтэй байх
- Ул суурьтай сэтгэж, бодит байдалд нийцсэн уян хатан төлөвлөгөө хийх
- Оролцогчдын санал бодол, сэтгэлийг ойлгох мэдрэмжтэй байх
- Ямар нэгэн тайлбар хийх явцад ойлгомжтой байдлаар тухайн зүйлийг зургаар болон бичгээр илэрхийлэх чадвартай байх
- Нэгтгэх, дүн шинжилгээ хийх чадвартай байх

Ахлагчийн ур чадвар

Ахлагч нь дор дурьдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх чадвартай байх.

- Аливаа асуудлыг малчдад ойлгуулахдаа зураг зурж, загвараар үзүүлнэ. Шохой, бал үзэг, модны мөчир зэргийг ашиглаж болно.
- Нэрээр илэрхийлэх аргад нэrsийн жагсаалт гаргаж, дүрсний хайчилбар хийнэ. Хэлбэр, карт, хайчилбар, хүснэгт зэргээр илэрхийлнэ.
- Улирал бүрт болсон үйл явдлуудыг өнгөөр ялгаж тэмдэглэж болно.
- Цуглуулсан баримт материалыа дэс дараалалаар нь ангилж жагсаана.
- Тоогоор харьцуулалт хийх нь ихээхэн үр дүнтэй байдаг ба үүнд чулуу, ургамлын үр, модны хэлтэрхий зэргийг хэрэглэх боломжтой.
- Уялдааг тодруулахын тулд харилцан хамаарлын бүдүүвчийг ашиглаж болно.

(4) Бусдаас туршлага судлах

Гадаадын донор байгууллагын мэргэжилтнүүд үйл ажиллагаа, аргазүй, технологи, түүний ашигтай талын тухай малчдад онолын талаас нь тайлбарлахад малчид бүрэн дүүрэн хүлээж авч чаддаггүй. Иймд бодит туршлагыг ижил түвшингийн малчдаар тайлбарлуулах, газар дээр нь зааварчилгаа өгүүлэх нь хамгийн үр дүнтэй юм. Ингэхийн тулд төслийн хамгийн шилдэг жишээг төсөлд хамрагдсан малчдад үзүүлэх, загвар болохуйц газар нутагтай танилцуулах, тухайн амжилттай үйл ажиллагаа явуулж буй нутгийн бүлгийн ахлагчийн сургалтанд хамруулах нь үр дүнтэй байдаг.

(5) Технологийн сургалтыг зохион байгуулах

Юуны өмнө танхимын сургалтаар дамжуулан технологийн үр ашгийг малчдад ойлгуулна. Гэвч зөвхөн танхимын сургалтаар практик мэдлэг хомс малчдад сайн ойлголт өгч чадахгүй тул үйл ажиллагаагаа амжилттай явуулж буй газрын жишээн дээр тайлбарлана. Улмаар төсөл хэрэгжих явцад тухайн үед шаардлагатай давтан сургалтуудыг явуулна. Эдгээр технологийн сургалтаар албан шаардлага бус малчдаас гарах санал санаачлага чухал гэдгийг ойлгуулах нь зүйтэй. Мөн сургалтын материал нь дан бичгээр бус зураг оруулан ойлгомжтой тайлбартай байвал сайн.

2.5.2 Засаг захиргааны ажилтны чадавхийг бэхжүүлэх

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад малчид, хариуцаж буй засаг захиргааны ажилтны хоорондын харилцан ойлголцол нэн чухал. Малчдад дээрээс нь байнга зааварчлах маягаар төсөл хэрэгжүүлж болох ч төсөл дуусахад үйл ажиллагааны тасралтгүй байдал нь алдагддаг.

Тухайн дэмжлэгийг хүлээн авч буй талын саналаар төслийн агуулгыг тогтох ба хэрэгжүүлэгч байгууллага нь бүх үүргийг хүлээх бус харин хэрэгжүүлэгч байгууллага болон хүлээн авагч талын үүргийг тодорхой болгон малчдыг үйл ажиллагаандaa сайтар татан оролцуулах нь зүйтэй. Мөн малчдад зааварчилгаа өгөх засаг захиргааны ажилтны ажил үүргийн хуваарийг тодорхой болгон хэвшмэл аргаас зайлсхийхийг хичээх хэрэгтэй.

Ингэхийн тулд асуудалд дүн шинжилгээ хийх, зорилгоо тодорхойлох, төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, мониторинг, үнэлгээ гэсэн төслийн бүхий л үе шатанд засаг захиргааны ажилтан, малчид хамтран ажиллаж, чадавхаа бэхжүүлэх шаардлагатай.

(1)Донор байгуулага, их дээд сургуулийн мэргэжилтнүүдийг үүрэг

Бэлчээр ашиглалтын удирдлагын асуудлаар төсөл санаачлагч нь донор байгууллага, их дээд сургууль, судалгааны байгууллага байдаг. Орон нутгийн засаг захиргааны холбогдох хүмүүс сургалтанд хамрагдах хүсэлтээ дээрх байгууллагуудад гаргаж, бэлчээр ашиглалтын зураглал боловсруулах ажлыг зохион байгуулах засаг захиргааны ажилтны үүрэг хариуцлагыг тодорхой

болгоно. Ингэхдээ технологийн талаар зөвхөн онолын мэдлэг олгох биш малчдад ойлгуулахад хялбар, хэрэгжүүлэхэд амар технологийг эзэмшсэн хүнийг багшаар сонгон ажиллуулахад анхаарах хэрэгтэй.

- (2) Иргэдийн оролцоо бүхий аргачлалын технологи дамжуулалт
Төсөл хэрэгжүүлэгч байгуулага нь төслийн менежмент, иргэдийн оролцоог чухалчлахын зэрэгцээ практик үйл ажиллагаанд ч маш сайн анхаарах хэрэгтэй нь тодорхой. Ингэхдээ засаг захиргааны ажилтны туслалцаатайгаар сургалтыг явуулах нь зүйтэй. Сургалт явуулах засаг захиргааны ажилтан нь туршлага багатай бол төслийн менежментийг үндсээс нь эхлэн төслийг хэрэгжүүлэх, хянах, зохион байгуулах, үнэлгээний аргад сургана. Аливаа сургалтанд онол практикийг хослуулна. Мөн төслийн төлөвлөгөө, хэрэгжилт, хяналт, үнэлгээний циклийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлынхаа үр дүнг сургалт семинарт илтгэж байх нь зайлшгүй чухал.

- (3) Сумын удирдлагын чадавхийг бэхжүүлэх

Монгол улсад аймаг, сум, багийн засаг дарга гэсэн шат шатны удирдлагууд ажилладаг. Гэвч төвийн түвшинд сургалт зохион байгуулагдагаас биш малчид болон алслагдмал бус нутгийн засаг захиргааны ажилтнуудыг сургах тогтолцоо хангалттай бүрдээгүй байна. Бэлчээр ашиглалтын талаар сумын түвшинд малчдад хандсан зааварчилгаа хамгийн чухал байдаг. Газрын тухай хуулинд бэлчээр ашиглалтыг багийн саналд үндэслэн сумын засаг дарга нь сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан шийддэг тогтолцоотой байна. Иймд сумын түвшинд буй засаг захиргааны ажилтнуудын бэлчээр ашиглалтын технологийн мэдлэг чадавхийг дээшлүүлэх шаардлагатай байна.

2.6 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах

2.6.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах үе шат

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг малчид хамтран боловсруулж хэрэгжүүлэх бөгөөд засаг захиргааны байгууллага нь хууль эрхзүйн болон бичиг баримт бүрдүүлэлт талаас нь дэмжлэг үзүүлнэ. Мөн их сургууль, судалгааны байгууллагуудаас ургамал судлалын сургалт явуулж, зураглал хийж технологийн дэмжлэг үзүүлнэ. Хамрагдах малчид, аймаг, сумын удирдлага, мөн технологийн туслалцаа үзүүлэх их дээд сургууль зэрэг холбогдох газрууд бүдүүвч 2-2-т үзүүлсний дагуу үйл ажиллагаа явуулна.



Зураг 2-2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах болон хэрэгжүүлэх тогтолцоо

2.6.2 Орон нутгийн захиргааны үүрэг

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн засаг даргын удирдлаган дор бэлчээр ашиглагчдын бүлгүүд боловсруулан түүнийг сум, аймгийн удирдлага, албан хаагч дэмжин зааварчилгаа өгч хэрэгжүүлэх ёстай.

Холбогдох талуудын үүргийг хүснэгт 2-7-д үзүүлэв.

Холбогдох талууд тус бүрийн анхаарвал зохих зүйлсийг доор дурьдав.

(1) Малчид

Малчдын бүлгийн ахлагчийн удирдлаган доор хэрэгжих бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг жил бүр боловсруулж багийн ИНХ-аар хэлэлцүүлэх ба “Сумын газар ашиглалтын төлөвлөгөө”-нд тусгасан байх шаардлагатай. Бүлэг эсвэл багийн хэмжээнд тогтсон журмыг баримтлахгүй малчин байгаа тохиолдолд ахлагч бүлэг дотроо ярилцан асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй. Бүлэг дотроо шийдвэрлэх боломжгүй тохиолдолд багийн засаг даргад мэдэгдэхийн хажуугаар асуудлыг шийдэхээр хичээн ажиллана.

(2) Баг (багийн засаг дарга, багийн ИНХ-ын дарга)

Малчдын бүлгийн ахлагчтай зөвшилцөн багийн түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхэд голлох үүрэгтэйгээр ажиллана. Багийн ИНХ-аар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцэнэ.

(3) Сум (сумын засаг дарга, газрын даамал)

Сум нь “Газрын тухай хууль”-ийн 52 дугаар зүйлд заасны дагуу сумын бэлчээр ашиглалтын журмыг тогтоож, жил бүр сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулна. Баг бүрээс ирэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тулгуурлан сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулна.

Бэлчээр ашиглалт нь сум дамжсан байдлаар хэрэгжих тохиолдол ч байдаг. Ийм тохиолдолд сум хоорондын тохиролцооны үндсэн дээр ашиглалтын журмыг тогтоож гэрээ байгуулна.

Хүснэгт 2.7

**Багийн түвшин дэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах,
хэрэгжүүлэх ажилд холбогдох талуудын үүрэг**

Оролцогч талууд	Үүрэг
Малчид	<ol style="list-style-type: none"> Сургалтанд хамрагдан, бэлчээрийн ургамлын муудах шалтгаан, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр дүнг ойлгосон байх Бүлгийн ахлагч бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг судалсны үндсэн дээр тус төлөвлөгөөг боловсруулах Бүлгийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр дүнг багийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд илтгэх Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад үүссэн бэрхшээлтэй асуудлуудыг сумын захиргаанд мэдэгдэх
Баг (багийн засаг дарга, багийн иргэдийн нийтийн хурлын дарга)	<ol style="list-style-type: none"> Сургалтанд хамрагдан, бэлчээрийн ургамал муудах шалтгаан, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний ач холбогдлыг ойлгосон байх Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах бус нутгийг сонгох Тухайн бус нутгийн малчдыг бүлэгт хуваах Малчдад зориулсан сургалтанд хамрагдах эсэх талаар санал асуулга явуулах Малчдын боловсруулсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг засварлах Багийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг батлах Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх дүрэм журамтай холбоотой мэдэгдэл тараах Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад үүсэх асуудлыг шийдвэрлэх Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг тусгах талаар мэдүүлэх
Засаг захиргааны ажилтан	<ol style="list-style-type: none"> Сургалтанд хамрагдан, бэлчээрийн ургамал муудах шалтгаан, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний ач холбогдлыг ойлгосон байх Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах бус нутгийг сонгох Тухайн бус нутгийн малчдыг бүлэгт хувиарлахад зааварчилгаа өгөх Малчдыг сургалтанд хамрагдахад анхаарч, сургалтанд хамрагдах хүсэлт, шаардлагыг тодорхой болгох үүднээс санал асуулга явуулах Малчдын боловсруулсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг судлах, гарах үр дүнг дээшлүүлэх талаар судалгаа хийх Сумын ИТХ-аар бэлчээрийн газар ашиглалтын төлөвлөгөөг батлах Зэрглэдээх сумдтай өөрийн сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний талаар зөвшилцэх (зэрглэдээх сумдтай тохиролцох асуудлуудыг холбогдох сумдуудтай зөвшилцэх) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх дүрэм журамтай холбоотой мэдэгдэл тараах Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд учирч буй сум хооронд үүсдэг асуудлуудыг шийдвэрлэх Сумын газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах
Аймаг (Аймгийн Газрын албаны Бэлчээрийн газрын ашиглалт хариуцсан мэргэжилтэн)	<ol style="list-style-type: none"> Сургалтанд хамрагдан, бэлчээрийн ургамал муудах шалтгаан, бэлчээрийн газар ашиглах төлөвлөгөөний ач холбогдлыг ойлгосон байх Малчдиг сургалтанд хамрагдахад анхаарч, сургалтанд хамрагдах хүсэлт, шаардлагыг тодорхой болгох үүднээс санал асуулга явуулах Малчдын боловсруулсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гарах үр дүнг дээшлүүлэх талаар судалгаа хийх Зэрглэдээ оршдог сумдын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний талаар зөвшилцэх (зэрглэдээх сумдтай тохиролцох асуудлуудыг холбогдох сумдуудтай зөвшилцэх) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд учирч буй сум хооронд үүсдэг нийтлэг асуудал, үл ойлголцлын талаар зөвшилцэх Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний уялдаа холбоог сайжруулах Аймаг болон сум дундын отрын бэлчээрийг тодорхойлох шаардлагатай үед аймаг, сум хоорондын гэрээ хийх

<p>Технологийн дэмжлэг үзүүлэгч (их, дээд сургууль гэх мэт)</p>	<ol style="list-style-type: none"> 1. Малчид, засаг захиргааны ажилтанд бэлчээрийн ургамал муудах шалтгаан, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний ач холбогдолын талаар сургалт зохион байгуулах 2. Хамрагдсан бус нутгийн бэлчээр ашиглалтын нөхцөл байдал, бэлчээрийн ургамалшилтын талаар газар дээр нь судалгаа хийх 3. 2.-т хэрэгжүүлсэн судалгааны үр дүнг нэгтгэх, дүн шинжилгээ хийх 4. 3.-т олж авсан үр дүнг үндэслэн бэлчээр ашиглалтын өнөөгийн байдлын зураглал, ургамалжийн зургийг боловсруулах 5. 4.-т боловсруулсан зураглалыг үндэслэн малчид, засаг захиргааны ажилтнуудад бэлчээрийн газар ашиглалтын өнөөгийн байдал, ургамалжилтай холбоотой сургалт зохион байгуулах 6. Малчдын боловсруулах бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд зөвлөгөө өгөх 7. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний судалгааны үр дүнг үндэслэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний ерөнхий зураглал боловсруулах 8. Бэлчээрийн ургамал муудах шалтгаан, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр ашиг, бус нутгийн газар ашиглалтын өнөөгийн байдал, бэлчээрийн ургамалжилтай холбоотой мэдээлэл өгөх
---	---

(4) Аймгийн Газрын албаны бэлчээрийн газрын асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймаг нь сум хоорондын зохицуулалт шаардлагатай тохиолдолд зохицуулалт хийж болно. Мөн аймаг дундын оторлох газар бий болгох тохиолдолд аймаг хоорондын зохицуулалт шаардлагатай. Сумын газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах талаар удирдамж өгөх, мөн аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах үүрэгтэй.

(5) Технологийн дэмжлэг үзүүлэгч

Бэлчээрийн газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах дэс дараалал, ургамалжлын судалгаа, зурагжуулалтын талаар малчид, сумын засаг захиргааны ажилтнуудад мэргэжлийн зүгээс заавар зөвлөгөө өгөх шаардлагатай тохиолдолд сургалт зохион байгуулна. Үндсэндээ суманд зааварчилгаа өгөх бөгөөд үр дүн нь олон нийтэд харагдахуйц бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.

(6) Тогтвортой байдлыг хангахын тулд үр шим хүртэгчдийн зүгээс сан байгуулах

Бэлчээр ашиглалтын тогтвортой байдлыг хангахын тулд зөв менежмент чухал. Оролцооны болон хамтын эзэмшлийн ухамсыг дээшлүүлж, мөн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний тогтвортой байдлыг хангахын тулд малчдын зүгээс хөрөнгө оруулалт хийлгэнэ. Энэхүү хөрөнгө малчдын бүлгийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүлгийн хөрөнгө байна. (Хүснэгт 2-8-д үзүүлэв)

Малчдаас оруулах хөрөнгө (Жишээ)

Агуулга	Хөрөнгөний хувь хэмжээ
Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, ногоо тариалах технологийн сургалт зэрэг малчдын чадварыг дээшлүүлэхэд шаардагдах үйл ажиллагаа Хурал зохион байгуулах	Малчдаас хөрөнгө шаардагдахгүй
Бэлчээр ашиглалтын төлөвлөлтэнд шаардлагатай материал тоног төхөөрөмж	Техники тоног төхөөрөмж авах зардлын 20%
Худаг засварлах зэрэг усны нөөцийг хамгаалах үйл ажиллагаа	Малчид хонин сан байгуулах


Сан байгуулах

Малчид хонин сан байгуулснаар дундын хөрөнгийн эх үүсвэртэй болно. Малчид хэсэг бүлгээрээ худгийн хамгаалалт, засвар үйлчилгээний хөрөнгийг бий болгох үүднээс хонин сан байгуулах нь хамгийн үр дүнтэй арга гэдгийг JIRCAS-aac тодорхойлсон. Өнөөдөр улсаас гүний худагт голчлон анхаардаг бол гар худагт зориулсан дэмжлэг бараг байхгүй байна. Гар худгийг гол төлөв хамтран ашигладаг бөгөөд засвар үйлчилгээний хариуцлагыг хэн хариуцаж байгаа нь тодорхой бус учир хөрөнгийг хэрхэн хуримтлуулах вэ гэдэг нь бэрхшээлтэй асуудал болдог. Хонин сан нь энэхүү асуудлыг шийддэх нэг арга юм.

Хонин сангийн нэг давуу тал нь зассан худагт малчин өөрийн хөрөнгийг оруулсан учраас эзэмшигч гэдгээ ухамсарлан байнгын засвар үйлчилгээ хийх болно.

2.7 Хэрэгжүүлэх дараалал

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах дараалалыг зураг 2-3-т үзүүлэв. Бүх үе шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны агуулга, аргын тухай тайлбарлав.



Зураг 2.3 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах болон хэрэгжилтийн дараалал

2.7.1 Ургамалжлын судалгаанд үндэслэн малын тоо толгойд тохицуулан бэлчээрийг хуваарилах

(1) Ургамалжлын судалгаа хийх

Байгалийн баялгийг тогтвортой ашиглахын тулд баялгийн хэмжээг зөв тооцоолох нь чухал юм. Бэлчээрийн баялаг нь бэлчээрийн ургамал бөгөөд бэлчээрийн ургамлын тэжээлийн ач холбогдолын үнэлгээг тогтоохын тулд ургамалжлын судалгааг хийх шаардлагатай байдаг.


Бэлчээрийн ургамалжлын судалгаа явуулах арга:

- 1) Тухайн багийн бэлчээрийг төлөөлж чадахуйц ургамалтай газрыг сонгох (хаваржаа, зуслан, намаржжаа, өвөлжөөний болон отрын бэлчээр)

- 2) Сонгон авсан газарт 50 метр талбай авч, 5 метр тутамд 1м х 1м хэмжээт топ /рам/-г ашиглан 10 давталттайгаар судалгааг явуулна. Нэг м2 хэмжээт тортон дотор байгаа ургамлын төрөл, зүйлийг тодорхойлон бичиглэл хийх Мөн ургацын хэмжээ, ургамлын бүрхэц, хөгжлийн үе шат, ургамлын өндөр зэргийг тодорхойлно. Ургамлын бүрхэцийг дараах аргаар тодорхойлно. Нэг м2 талбайг санамсаргүй аргаар сонгон авч тусгай бүрхэц буюу ургамлын бүх эрхтэний дээд хэсэг болон хагд өвсний газрын гадаргууг бүрхсэн талбайг эгц дээрээс харж нийт талбайг 100 хувь гэж харьцуулан гаргана.
- 3) Зүйл ургамлын бодьгалийн тоо-арвийг нүдэн баримжаагаар дараах байдлаар тооцно.

Хүснэгт 2.9

100-90	Soc (socialis)	ургамал газрын гадаргууг нэлэнхүйд нь бүрхсэн
90-70	cop3 (copiosae)	ургамал их элбэг
70-50	cop2	ургамал элбэг тоотой
50-30	cop3	ургамал хангалттай тоотой
30-10	sp (sprasae)	ургамал цөөн
10-	sol (solitaries)	ганц нэг ургамал
1-0	rr	маш ховор
0	Un	ганц зэрэг үнэлгээг ашиглана.



Зураг 2.5

Бэлчээрийн ургамалыг аж ахуйн бүлэг тус бүрээр нь тодорхойлно /үетэн, буурцагтан, улалжтан, сонгинотон, алаг өвст ургамал/.

Бэлчээрийн ургацыг тодорхойлохын тулд 12 /1м Ч 1м хэмжээт тортон доторх/талбай дахь ургамалыг газрын гадаргаас 2-3 см-ийн дээгүүр хярган авч бэлчээрийн аж ахуйн ургацыг тогтооно.

- 4) Ургацын нойтон болон хуурай жинг тус бүрд нь тодорхойлох

шаардлагатай. Хуурай жинг гаргахдаа дээжийг хатаах багажинд 60 градуст 48 цаг эсвэл наранд 3 өдөр хатаасны дараа жинлэж тооцдог.

- 5) 10 давталттай дээжний дундаж ургацыг тогтоон 1м2 талбайн хэмжээгээр үржүүлэхэд ургацын хэмжээ (гр/м2)-аар тодорхойлогдох ба үүнийг 1га талбайн ургац руу шилжүүлнэ. Жишээ нь: 1м2 талбайн ургац /10 давталтын дунджаар/ 120гр гарсан бол 1га талбайн ургац: 120гр Ч 10.000м2 = 1.200.000гр=1200кг=12цн болно.
- 6) Ургамалжлын судалгааг явуулсан газар, нутгийн мэдээллийг тэмдэглэн авах шаардлагатай.
 - a) Судалгааны цэгийн давталтын тоо
 - b) Хэмжилт явуулах газрын нэр
 - c) Засаг захиргааны нэгж (аймаг, сум, баг)
 - d) Өргөрөг, уртраг, далайн түвшнөөс дээших өндөр
- 7) Бэлчээр ашиглалтын үеүүдийг сонгож ургамалжлын судалгаа хийн өвсний гарцыг тодорхойлох
- 8) Малчдын дунд санал асуулга явуулж дүн шинжилгээ хийх

Ургамалжлын байдлыг тодорхойлохын тулд малчдаас санал асуулгаар судалгаа явуулах шаардлагатай. Малчдын бэлчээр ашиглалттай холбоотой бодит байдлыг судална.

Санал асуулгад малын бүтэц, мал маллагаа, бэлчээр ашиглалтын бодит байдал, ургамлын доройтлын түвшин, мал аж ахуйн менежмент, малчдын хүсэлт зэрэг асуудлуудыг тусгана.

2.7.2 Тухайн бэлчээрийг ашиглах малын зохистой тоо толгойг тодорхойлох

Бэлчээрийн нэг га талбайн даацыг дараах томъёог ашиглан тодорхойлно.

$$БД = \frac{У}{\Theta \times X}$$

БД - Бэлчээрийн даац

У - Бэлчээрийн ургац

Θ - Нэг малын бэлчээрээс өдөрт идэх өвс, кг

X - нэг өрх айлын бэлчээр ашиглах хугацаа

Ургамлын судалгааг үндэслэн тухайн бэлчээрийг (хаваржaa, зуслан, намаржaa, өвөлжөө, мөн отрын бэлчээр) ашиглах малын зохистой тоо толгойг тооцоолон гаргана.

Бэлчээрийн даацыг сүрэгт шаардагдах бэлчээрийн талбайгаар тодорхойлох

Үүний тулд дараах томъёог хэрэглэнэ.

$$БТ = \frac{\Theta \times X \times C}{У}$$

- БТ- Бэлчээрийн талбай, га
- Ө- Нэг малын хоногт идэх тэжээлийн норм, кг
- Х-Мал бэлчээх хоногийн тоо
- С-Малын тоо
- Ү- 1 га талбайгаас мал идэх бодит ургац

Хүснэгт 2.10

Таван хошуу малын бэлчээрээс идэх өвсний хэмжээ, кг / хоногоор/

Ангилал	Зун	Намар	Өвөл	Хавар
Адуу	7.8 (39.0)	8.1(40.5)	6.5(32.5)	5.8(29.0)
Тэмээ	14.1(70.5)	13.0(65.0)	8.4(42.0)	19.9(99.5)
Үхэр	8.7(43.5)	9.7(48.5)	8.4(42.0)	7.4(37.0)
Хонь	1.6(8.0)	1.8(9.0)	1.1(5.5)	1.1(5.5)
Ямаа	1.3(6.5)	1.4(7.0)	1.0(5.0)	1.0(5.0)

() нь өвсний жингийн тооцоо (Хатаасан жингээр 20% гэж тооцно)

Хүснэгт 2.11

Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх харьцаа

Малын төрөл	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь	Ямаа
Харьцаа	6.6	8.6	5.0	1.0	0.9

Төл малын биеийн жингийн харьцааны үзүүлэлтээр эх малын толгойд шилжүүлэн тооцно.

Жишээ нь: 20 кг төл мал нь 35 кг эх малын 0.57 тоо толгойтой дүйцнэ.

Шаардлагатай бэлчээрийн тооцоо

Малын нийт тоо толгойг тогтоон шаардлагатай бэлчээрийн талбайг тооцоолон гаргая.

(а) Малын тоо толгойг хонин толгойд шилжүүлж, нийт малын тоо толгойг тооцоолно.

Хүснэгт 2.12

Мал	Бодит тоо (толгой)	Үзүүлэлт	Хонин толгойд шилжүүлж тооцсон тоо (толгой)
Үхэр	500	5.0	2,500
Ямаа	2,000	0.9	1,800
Хонь	3,000	1.0	3,000
Нийт	5,500		7,300

- (b) Бэлчээрийн га талбайн өвсний ургацыг тооцоолбол
(c) Тухайн бэлчээрийн ургамлын судалгааны үр дүнд, зуны хугацааны өвсний ургацын хэмжээ 150 гр/м² байсан гэж үзвэл:

Ургацын хэмжээ (кг/га) = 150 гр x 10,000 м² / 1,000 гр = 1500 кг/га /15ц/га/

Малд идэгдэх бодит ургац нь аж ахуйн 50%-тай тэнцэнэ.

Иймд МИБҮ=750кг/га/1500-50%/ байна.

- (d) Нийт малд идэгдэх шаардлагатай бэлчээрийн талбайг тооцоолбол:

6-р сарын 15-наас 7-р сарын 31 (46 өдрийн турш)-ний хооронд зуны турш бэлчээрийг ашиглана.

$$BT = \frac{8 * 46 * 7300}{750} = 3582\text{га}$$

БТ- Бэлчээрийн талбай, га

Ө- Нэг малын хоногт идэх тэжээлийн норм, кг

Х-Мал бэлчээх хоногийн тоо

С-Малын тоо

(e) У- 1 га талбайгаас мал идэх бодит ургац

Бэлчээрийн даацын бодит байдлын судалгаа

JIRCAS байгууллага нь Төв аймгийн Борнуур сумын бэлчээрт 2007 оноос хойш малын төрөл болон тоо толгой нь бэлчээрийн даацаад хэрхэн нөлөөлж буйг судалж байна. 2008 он хүртэлх хоёр жилийн хугацааны судалгааны үр дүнгээс харахад тус нутгийн бэлчээрийн өвсний гарц 1.5-1.7 т/га бөгөөд үүнээс малд (хонь) идэгдэх хэмжээ нь (идэмж) 40-50%, малын (хонь) биеийн жинтэй харьцуулахад 3-4% өвс идэгддэг байна.

Байгаль цаг уурын нэхцлөөрөө ялгаатай Өвөрхангай аймгийн Тарагт сумын бэлчээрт хонинд тулгуурлан бэлчээрийн даацыг тодорхойлох судалгааны ажил 2008 оноос хойш хийгдэж байна.

2008 оны судалгаанаас үзэхэд 1га-д нас бие гүйцсэн 6 толгой хонь бэлчээрлэх боломжтой байсан байна. Цаашид бэлчээрийн даацын судалгааг үргэлжлүүлнэ.

Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө бэлчээрийн өвсний гарцыг тодорхойлбол тухайн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө оновчтой болж чадна.

2.7.3 Бэлчээр сэлгэн нүүдэллэх төлөвлөгөө гаргах

- (1) Ургамалжлын зургийг боловсруулах

Ургамалжлын судалгаанд үндэслэн бэлчээрийг зураглаж, ургамалжлын зураг боловсруулна. Энэхүү зурагт дараах мэдээллүүдийг оруулсан байна.

- a) Ашиглах улирал (хавар, зун, намар, өвөл)
b) Бэлчээрлүүлэх боломжит малын тоо толгой
c) Газрын нэр болон засаг захиргааны нэгж

Зураглалыг бэлчээр ашиглагчдын бүлэгт ашиглах бэлчээр ашиглалтын төлөвлөлт хийхдээ үндсэн материал болгож ашиглана. Сумын захиргаа ургамалжлын судалгаанаас олсон мэдээлэл болон тэмдэглэгээг газрын зурагт оруулж, хэн бүхэнд тодорхой байхаар боловсруулах хэрэгтэй.

Хүснэгт 2.13

Мөн доорхи материалуудаас ашиглаж болно.


Зургийн нэр	Зохиогч	Масштаб
Сумдын газрын зураг		1:100,000
Хөдөө аж ахуйн зориулалттай газар (1987) болон бэлчээрийн ургамлын хяналтын зураг		1:100,000
Монгол улсын ургамалжлын зураг (1979)		1:1,500,000
Бэлчээрийн ургамлын ашиглалтын зураг (1981)		1:100,000

(2) Усны нөөцийн зураг боловсруулах

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад худаг ашиглалтын нөхцөл байдал маш чухал үзүүлэлт болдог. Тухайн нутгийн усны нөөцийн байрлал, төрөл болон усны хэмжээ, усны чанар зэргийг тус нутгийн газрын зураг, ургамалжлын зураг зэрэгт тэмдэглэж, бэлчээрийн усны нөөц ашиглалтын төлөвлөлтийг хийнэ.

Ихэнхдээ худгаас усны хэрэглээгээ хангадаг ба өнөөг хүртэл эвдрээд ашиглагдах боломжгүй байсан худгийг засварласнаар бэлчээр ашиглалтын хүрээ тэлнэ. Бэлчээрийн хүрээ тэлэгдсэнээр бэлчээрийн хуваарилалт нэмэгдэн, малын төвлөрөл багасч, бэлчээр талхлагдахаас сэргийлэх боломжтой болно. Иймд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахдаа малчид хоорондоо ярилцан худгийн ашиглалтын талаархи мэдээллтэй байх шаардлагатай.

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа заавал усны нөөцийн байршил, усны хэмжээ, худгийн төрөл, хэрэглэгчийг тодорхой оруулах шаардлагатай.



<p>Зөвхөн ашиглах боломжтой худгийн эргэн тойронд малын төвлөрөл бий болно</p>	<p>Худаг ашиглалтанд орсноор бэлчээрийн хүрээ тэлнэ</p>
<p align="center">Бэлчээрийн худгийн ашиглалт хамгаалалтын өнөөгийн байдал</p> <p>Монгол улсад ус нь төрийн мэдэлд байдаг бөгөөд хүн бүхэн чөлөөтэй ашиглах боломжтой. Гэхдээ усны байгууламж нь элэгдэж эвдэрдэг зүйл бөгөөд хэн нэгэн хяналт тавьж, засварлаж байх ёстой. Хувь хүмүүс худагт хяналт тавих, засварлах нь эдийн засгийн хувьд хүндрэлтэй байдаг. Цаашид бэлчээр ашиглалтын төлөвлөгөөгөөр малчны бүлэг байгуулан худгийг байнгын хяналттай болгох шаардлагатай. Тогтвортой урт хугацааны менежментийн аргачлалын тухайд, малчид хонин сан байгуулж, түүгээрээ худаг засварын зардлыг шийдвэрлэж, малчны бүлэг дотроо худаг засварын баг бүрдүүлж ажиллах нь үр дүнтэй арга болох нь JIRCAS-аас хийсэн судалгааны үр дүнд тодорхой болсон. “Хонин сан” байгуулах, “Худаг засварын баг” бүрдүүлэх тухай технологийн зааварт дэлгэрэнгүй тайлбарлана.</p>	

(3) Бэлчээр ашиглагчдын бүлгүүд нүүдлээ төлөвлөх

Үүний тулд бэлчээр ашиглагчдын бүлгүүд гишүүдийнхээ дунд хурал зохион байгуулна. Хурлын зорилго нь ургамалшлын судалгааны дунд үндэслэн бэлчээртээ үнэлэлт өгөх нэгдсэн ойлголттой болох, улмаар бэлчээрээ ашиглах төлөвлөгөө гаргах явдал юм.

Сургалтын агуулга, зохион байгуулалт

- Ургамалжлын судалгааны үр дүнг хэвийн, дунд зэргийн, муу ургамалжилтай бэлчээрийн хэсгүүдээр тус бүрт нь танилцуулах ба ургамалшлын зураглал ашиглах шаардлагатай.
- Усны нөөцийн судалгааны үр дүнг мэдээлэх
Худаг устай эсэх, худгийн төрөл, худгийн ажиллагаа, хяналтын систем зэргийг усны нөөцийн зураг ашиглан тайлбарлана.
- Нүүдэл хийх бэлчээрийг сонгоходоо ургамалжлын зурагт

тэмдэглэгдсэн ургамалжил муутай болон мал хэт ихээр төвлөрсөн талхлагдалд орж буй бэлчээрийг чөлөөлөх зарчмыг баримтлах нь зүйтэй. Үүний тулд малчид бүлэг дотроо зөвлөлдөж аль орчны бэлчээрийг, ямар хугацаанд, хэдэн өрх ашиглах зэргийг шийдвэрлэнэ.

2.7.4 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж холбогдох засаг захиргааны удирдлагуудтай зөвшилцөх

Малчдын бүлгийн ахлагч нарын дунд сургалт, санал асуулга зохион байгуулах

Энэхүү сургалтаар ургамалжлын зурагт үндэслэн бүлэг тус бүрийн ашиглаж буй болон ашиглах бэлчээрийг тодорхой болгох (мал хэт төвлөрөхгүй байхаар); Мөн сум, багийн хил хязгаарыг нарийн тооцоолох; Түүнчлэн бүлгийн малын тоонд үндэслэн малын төвлөрлийг тооцоолох;

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулсны дараа малчдын бодит нөхцөлд хэрэгжүүлэх боломж, орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Агуулга

1. Багийн ИНХ-аар төлөвлөгөөг хэлэлцэн зөвшилцэж сумын ИТХ-аар батлах
2. Холбогдох талуудын хоорондын гэрээ, хэлцэл хийх
3. Сум хоорондын гэрээнд тусгах асуудлуудыг шийдвэрлэх

3.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбоотой тогтоол, шийдвэр

(1) Иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулна

Бэлчээр ашиглагчдын бүлгийн ахлагчид бүлгээрээ хэлэлцэж шийдвэрлэсэн бүлгийн бэлчээр ашиглах төлөвлөгөөгөө багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагатай. Үүний дараа багийн удирдлагууд багийн түвшний ерөнхий төлөвлөгөө хийж сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулах ба малыг нэг газар хэт олноор төвлөрүүлэхгүй байх талыг гол анхаарна.

(2) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний шийдвэр (баталгаажилт)

Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцсэн бүх багуудын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд оруулан сумын ИТХ-аар баталгаажуулна. Багийн ИНХ болон сумдын ИТХ-аас гаргах шийдвэрийн ерөнхий загварыг дор үзүүлэв.

Багийн ИНХ-ын шийдвэр

Бэлчээр ашиглагчдын бүлэг нь бэлчээрийг зүй зохистой сэлгэж ашиглах талаар малчдын бүлгийн ахлагчдын санал цуглуулж түүний үр дүнг багийн ИНХ дээр хэлэлцэж сумын ИТХ-аар батлана.

1. Бүх бүлгүүдийн малчин өрх өвөлжөө, хаваржаагаа чөлөөлж нүүх. Үүнийг бүлгийн бүх малчдын үүрэг болгох
2. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хамгаалах өрхийг томилох явдлыг бүлгийн ахлагчийн үүрэг болгох
3. Хамгаалсан бэлчээрт гадны малчид болон мал нэвтрүүлэхгүй байх
4. Чөлөөлсөн бэлчээрт гадны малчид болон мал нэвтрүүлэхгүй байх явдлыг бүлгийн ахлагч, баг болон сумын удирдлагууд хариуцна.
5. Сум болон багийн хурлын шийдвэр, сумын засаг даргын мэдэгдлийг зөрчин хамгаалж байгаа бэлчээрийг ашигласан малчин өрхөд хуулийн дагуу мөнгөн торгууль ногдуулах тухай сумын ИТХ-ын дарга болон сумын засаг даргаар дамжуулж шийдвэрлэх

Шийдвэрийн агуулга: Сумын ИТХ-ын шийдвэр

Сумын ИТХ-ын хурлын шийдвэр

.....багийн бэлчээрийг төлөвлөж ашиглах талаар багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрийг үндэслэн дараах зүйлийг сумын хурлаар шийдвэрлэнэ.

1. Багийн ИНХ-ын шийдвэрийг батална.
2. Багийн ИНХ-ын шийдвэрийг малчдын бүлгийн ахлагч хариуцан хэрэгжүүлнэ.
3. Үйл ажиллагаанд ямар нэгэн бэрхшээлтэй асуудал гарвал багийн дарга, багийн иргэдийн нийтийн хурлын дарга болон малчид хамтран хэлэлцсэн үндсэн дээр асуудлыг шийдвэрлэнэ.
4. Багийн иргэдийн нийтийн хурлын шийдвэрийгоны.... сарын.....өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

Сумын ИТХ-ын дарга.....

3.2 Талууд хоорондын гэрээ болон төлөвлөгөөтэй нүүх нүүдлийн хэрэгжилт

(1) Холбогдох талуудын гэрээ

1) Гурван талт гэрээ

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй болгохын тулд сум, баг, бэлчээр ашиглагчдын бүлэг гэсэн талуудын хооронд бэлчээрийг зохистой ашиглах талаар авах арга хэмжээг тусгасан гэрээ байгуулна. Гурван талт гэрээнд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд сум, багийн дарга бэлчээрийг ашиглах малчдын бүлгийн ахлагч, тэдгээр гишүүд тус бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхой тусгана.

Гэрээнд дараах зүйлүүдийг тусгасан байна.

- a) Өвөлжөө, хаваржааны бэлчээрээ чөлөөлж зун, намрын улиралд нүүдэл хийх
- b) Бэлчээр ашиглах хугацааг улирал бүрээр нарийн тогтоох
- c) Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хариуцан үлдэх өрхийг томилох
- d) Гадны сум, багаас орж ирэх нүүдлийг хэрхэн зохицуулах тухай

Гурван талт гэрээ хийх загварыг дор үзүүлэв.

ИТХ-аарбатлагдсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор сумын засаг дарга....., багийн засаг дарга....., малчдын бүлгийн ахлагч нарын хооронд хүртэлх хугацаанд дараах гэрээг байгуулав.

1. Зорилго

(1) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд сумын жил бүр боловсруулах бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг мөрдөх малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлж, бэлчээрийг хамгаалах нь тус гэрээний зорилго юм.

(2) Гэрээг өөрчлөх тохиолдолд гурван тал хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

2. Сумын засаг даргын үүрэг

- (1) Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан шийдвэрийн агуулгатай холбоотой мэдэгдэл гаргах
- (2) Малчдыг удирдаж, зааварчилгаа өгөх
- (3) Бүлэг тус бүртэй бэлчээр ашиглах гэрээ байгуулах
- (4) Сум хоорондын гэрээг бусад сумдтай байгуулж ажиллах
- (5) Бусад сумдын малчдад ноогдуулах торгуулийн хэмжээг тогтоох

3. Багийн засаг даргын үүрэг

- (1) Малчдын шаардлагад нийцүүлэн багийн хурлыг зохион байгуулах
- (2) Малчдыг тогтоосон хугацаанд нүүлгэх
- (3) Бусад сумдаас орж ирэх малчдын нүүдлийг зохицуулах
- (4) Тулгамдаж буй бэрхшээлтэй асуудлын талаар сумын удирдлагад мэдээлэл өгөх

4. Бэлчээр ашиглагчдын бүлгийн ахлагч болон малчдын үүрэг

- (1) Бүх малчдын бүлгийг байгуулж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг нийтээрээ хэлэлцэх
- (2) Төлөвлөгөөг хэрэгжүүлэх

Сумын засаг дарга

Багийн засаг дарга.....

Бүлгийн ахлагч.....

2) Сум хооронд хэлэлцээр хийх

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тухайн сумын хил заагаас гаднах бэлчээрийг ашиглахаар төлөвлөсөн тохиолдолд сум хоорондын хэлэлцээрийг хийвэл зохино. Өнөөгийн бэлчээр ашиглалтын байдал нь тухайн сумын хил зааг дотор биш, мөн цаг уурын тогтвортгуй нөхцөл байдлаас шалтгаалан өвсний гарц муу байгаа зэргээс болж бусад сумдын бэлчээрийг ашиглахаас өөр аргагүй болсон тохиолдолд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг сум хоорондын хэлэлцээрээр зохицуулах шаардлагатай.

Сум хоорондын зохицуулалт хийхдээ хоёр талын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг тодорхойлж хоёр тал хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Сум хоорондын хамтын шийдвэр хэмээн гэрээ байгуулна.

Сум хоорондын хэлэлцээрээр дараах зүйлүүдийг тодорхой болгоно:

- a) Сумын өвөлжөөний болон отрын зориулалттай бэлчээрийг тодорхой болгох
- b) Хоёр сумын малчдын хамтран ашиглах бэлчээрийг тодорхой болгох
- c) Гадны сумын малчдын бэлчээр ашиглах хугацааг тодорхой зааж өгөх
- d) Гадны сумын малчдын бэлчээр ашигласны төлбөр, хураамжийн хэмжээг тодорхой тогтоох
- e) Байгаль цаг уурын тогтвортгуй байдлаас шалтгаалан бэлчээр хомсдох үед дундаа ашиглах бэлчээр нутгийг тогтоож өгөх
- f) Хамтын шийдвэрийг зөрчсөн хүнд торгууль ногдуулах зэргээр арга хэмжээ авах

Сум хоорондын гэрээ байгуулах (Жишээ)

- Сумын бэлчээр ашиглах журмыг зөрчсөн тохиолдолд (өвөл, хаврын бэлчээрт зүн малаа оруулах гэх мэт) холбогдох хууль журмын дагуу хариуцлага хүлээлгэх
- Туяа багийн бэлчээрийг гадны малчид ирж ашиглахыг зөвшөөрөхгүй
- Зуд, ган болсон онцгой тохиолдолд ашиглах сум дундын отрын нутгийг тухай бурд нь сумдууд хоорондоо хэлэлцэж зөвшилцэх

Газрын тухай хуулийн 52.2, 63.1.8-д үндэслэн бусад сумдаас орж ирэх малчдын нүүдлийг зохицуулах, өвөлжөө хаваржааны тодорхой бэлчээрийг талхлагдалтаас хамгаалах журмыг шийдвэрлэсэн байна

Газрын тухай хуулиас:

52.2 Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сум, дүүргийн засаг дарга тогтоож, баг, хорооны засаг дарга, иргэд дагаж мөрдөнө. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бус нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн иргэдийн нийтийн хурлын саналыг үндэслэн сумын засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно.

63.1.8 Энэ хуулийн 52.2, 53.3 болон 54.3-т заасан журмыг зөрчсөн бол иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1-4 дахин, байгууллага аж ахуйн нэгжийг 10-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тортгож хохирлыг төлүүлнэ.

3.3 Төлөвлөгөөний дагуух нүүх нүүдлийн хэрэгжилт

Малчин өрхүүд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний дагуу нүүдэллэнэ. Төлөвлөгөөнд тусгагдсан бэлчээр нутагт нүүж очих ба бэлчээр ашиглах хугацааг чанд мөрдөх ёстай.

Гэвч тухайн жилийн байгаль цаг уурын байдлаас шалтгаалан төлөвлөсөн бэлчээр рүү нүүх боломжгүй болсон тохиолдолд бусад баг, бэлчээр ашиглагчдын бүлэгтэй нөхцөл байдлыг зөвлөлдөж нэг дор хэт олон мал төвлөрүүлэхгүй байхаар тооцож өөр бэлчээр нутаг рүү нүүх шаардлагатай болно.

Нүүх боломжгүй байдаг шалтгаан

Өнөөг хүртэлх судалгааны үр дүнгээс үзвэл доорхи шалтгааны улмаас төлөвлөгөө ёсоор нүүх боломжгүй болдог байна.

Бороо хур багатай байснаас бэлчээрийн өвсний гарц муудсан, худаг эвдэрсэн, усны хүрэлцээ хангамж муу, мөн өөрийг нь нүүсний дараа бусад сумдын малчдын нүүдэл орж ирэх вий гэсэн болгоомжпол зэрэг маш олон шалтгаантай.

- 1) Төлөвлөсөн бэлчээрт малчид олноор төвлөрсөн
- 2) Нүүдэл хийхээр төлөвлөсөн газарт өвс ногооны гарц муу байх
- 3) Нүүдэл хийхээр төлөвлөсөн бэлчээр худаг, усны хомсдолтой байх

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хяналт үнэлгээ

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө түүний хэрэгжилтийн явц болон үр дүнд хяналт шинжилгээ хийх нь төлөвлөлт, менежментийг цаашид сайжруулахад ач холбогдолтой. Мөн малчид, орон нутгийн албан хаагчид бие даан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх чадвар эзэмшсэн эсэх, энэ нь ургамлын нөхөн сэргэлтэнд хир үр дүнтэй нөлөөлж байгаад хяналт шинжилгээ хийж үнэлгээ өгнө.

Агуулга

Бэлчээр ашиглалтын хяналт шинжилгээний агуулга, судлах зүйл, дүн шинжилгээ хийх арга

4.1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааны үр дүнг харуулах хяналт шинжилгээ

Бэлчээр ашиглалтыг сайжруулах зорилгоор бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр дүнд мониторинг судалгаа хийнэ. Ялангуяа малчид, орон нутгийн захиргааны албан хаагчид бие даан бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай тул тэдний чадавхад хяналт шинжилгээ хийнэ.

Энэ нь дараах 2 чиглэлтэй:

- Үйл ажиллагааны үр дүн ямар байсан вэ?
- Үйл ажиллагааны үр дүн хир зэрэг дээшилсэн бэ?

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлж байгаа болон сургалтын агуулгыг ойлгож эзэмшсэн байдал зэргийг мониторинг судалгаанд тусгаж, анкет болон санал асуулгаар явуулна.

Малчдын бүлгийн ахлагч болон орон нутгийн захиргааны албан хаагчдын чадавхийг бэхжүүлэхтэй холбоотой мониторинг судалгааг хүснэгт 14-т үзүүлэв.

Хүснэгт 4.1

Чадавхийг бэхжүүлэхтэй холбоотой хяналт шинжилгээ

Зорилго	Хэрэгжилтийн явц	Гарсан үр дүн
1 Малчдын бүлгийн ахлагчийг сургах	Сургалт семинарын ирц, сургалтын агуулгыг хир эзэмшсэн эсэх, оролцогчдын илтгэл “Оролцогчдын нэрсийн жагсаалт, анкет”	Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө сайжирсан “Малчид, захиргааны албан хаагчаас ярилцлага авах, өөрөө өөрийгөө үнэлэх”
2 Орон нутгийн захиргааны албан хаагчдын менежментийн чадавхийг дээшлүүлэх	Сургалт семинарын ирц, сургалтын агуулгыг хир эзэмшсэн эсэх, оролцогчдын илтгэл “Оролцогчдын нэрсийн жагсаалт, хурлыг хөндлөнгөөс сонсох”	Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө иргэд дэмжих болсон “Малчид, захиргааны албан хаагчаас ярилцлага авах, өөрөө өөрийгөө үнэлэх”

4.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнд хийх хяналт, үнэлгээ

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлсний дараах үр ашгийг тогтоохын тулд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний бодит ач холбогдол, ургамлын нөхөн сэргэлт сайжирсан эсэхэд хяналт шинжилгээ хийнэ. Сум, багийн засаг дарга болон малчдын бүлгийн ахлагч гүйцэтгэх боловч ургамалжлын судалгаанд мэргэжлийн хүн оролцох шаардлагатай. Энэхүү хяналт шинжилгээний үр дүng дараа жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Хүснэгт 4.2

Хяналт, шинжилгээ

Зорилго	Судалгаа	Арга	Хэрэгжүүлэгч
Бодит үр ашгийг тооцох	<ul style="list-style-type: none">Бүлэг бүрийн бэлчээр сэлгэлтийн хэрэгжилтийн байдал	<ul style="list-style-type: none">Ажиглалт	<ul style="list-style-type: none">Багийн даргаБүлгийн ахлагч зэрэг
	<ul style="list-style-type: none">Өвөл, хаврын бэлчээр орчимд ирэх гадны сумдын малчдын нүүдлийн байдал	<ul style="list-style-type: none">Ажиглалт	<ul style="list-style-type: none">Багийн даргаБүлгийн гишүүд Нүүдэллэдэггүй малчид
	<ul style="list-style-type: none">Бүх бүлгүүдийн зуслан, намаржааны бэлчээр ашиглалтын байдлыг нягтлах	<ul style="list-style-type: none">Анкет	<ul style="list-style-type: none">Сум
	<ul style="list-style-type: none">Зэргэлдээх сумдын бэлчээр ашиглалтын байдал	<ul style="list-style-type: none">Зэргэлдэх сумдын Засаг дарга, багийн даргаас асуухМалчидтай ярилцах	<ul style="list-style-type: none">Сум
Ургамлын мониторинг судалгаа	<ul style="list-style-type: none">Ургамлын судалгаанд тусгах зүйл (төрөл, хэмжээ гэх мэт)	<ul style="list-style-type: none">Малчдын оролцоотойгоор ургамлын байдал дүгнэлт хийхТехнологийн талаас ХААИС, эсвэл цаг уурын алба зэрэг орон нутгийн албан хаагчид	<ul style="list-style-type: none">Технологийн талаас ХААИС, орон нутгийн албан хаагчид

Хүснэгт 4.3**Судалгаанд дүн шинжилгээ хийх**

Зорилго	Судалгаа	Дүн шинжилгээ (Жишээ)
Бодит үр ашгийг тооцох	• Бүлэг бурийн бэлчээр сэлгэлтийн хэрэгжилтийн байдал	<ul style="list-style-type: none"> Яагаад нүүгээгүй вэ? Яагаад төлөвлөгөөнд заасны дагуу нүүж чадаагүй вэ?
	• Бүлэг бурийн зуслан, намаржааны бэлчээр ашиглалтын байдлыг нягтлах	<ul style="list-style-type: none"> Бүлгүүдийн нүүдлийн онцлог, ялгаа Хувь хүмүүсийн нүүдлийн онцлог, ялгаа Мал хэрхэн тархан бэлчээрлэж байгаа вэ? Малчдын нүүдэллэх бэлчээрийн зайд
	• Өвөл, хаврын бэлчээр орчимд ирэх гадны сумдын малчдын нүүдлийн байдал	<ul style="list-style-type: none"> Яагаад өөр сумын нутагт нүүж ирсэн бэ? Нүүдэлчдийн харьцаа, ойлголцол
	• Зэргэлдээх сумдын бэлчээр ашиглалтын байдал	<ul style="list-style-type: none"> Зэргэлдэх сумдын Засаг дарга, багийн даргаас асуух Малчидтай ярилцах
Ургамлын мониторинг судалгаа	• Ургамлын судалгаанд тусгах зүйл (терөл, хэмжээ гэх мэт)	<ul style="list-style-type: none"> Ургамалжил сайжирсан эсэх үнэлэмж Өвс, ургамал сайжрах болсон шалтгаан

Судалгааны үр дүнгээс гарч ирсэн хүндрэлд хамтран дүн шинжилгээ хийж, шийдвэрлэх арга замыг тодорхой болгож дараа жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах шаардлагатай.

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний бодит хэрэгжилтийн байдлыг судлах анкет маягтын жишээг дор үзүүлэв. Сум, багийн дарга, малчдын бүлгийн ахлагч зэрэг хяналт хэрэгжүүлэгчид нь малчдаас анкет судалгаа авч үр дүнд дүн шинжилгээ хийнэ.

Хүснэгт 4.4

..... багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд хамрагдах малчин өрхийн анкет

1. Бүлгийн нэр:.....
2. Өрхийн тэргүүний нэр:.....
3. Судалгаа явуулсан газар (GPS):.....

N (хойд өргөрөг):	L (зүүн уртраг)
-------------------	-----------------

4. Малын төрөл, тоо (судалгаа авсан өдөр):

Малын төрөл	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ
Тоо толгой					

5.оны бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний тухай

5-1 Нүүдэл хийсэн байдал

	Нүүсэн	Нүүгээгүй
Өвөлжкеөнөөс - хаваржaa		
Хаваржаанаас - зуслан		
Зуслангаас - намаржaa		

5-2 Өвөлжөө, хаваржaa, зуслан, намаржааны бэлчээрийг ашиглах хугацаа

	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Газрын нэр
Хаваржaa			
Зуслан			
Намаржaa			
Өвөлжөө			

5-3 Нүүдэл хийгээгүй шалтгаан

Шалтгаан	Хаваржaa	Зуслан	Намаржaa
Нүүдлийн зардал байхгүй			
Баг, бүлэг дотор нүүдээгүй өрх олон байдаг			
Нүүхээр төлөвлөсөн бэлчээр нь өвс муттай байсан			
Нүүхээр төлөвлөсөн бэлчээрт усны хангамж муу			
Нүүхээр төлөвлөсөн газар мал ихтэй байсан			
Гадны сумдын малчид өвөлжөө, хаваржааны бэлчээрт орж ирэх учир			
Нүүдэл хийх газарт хүндрэл бэрхшээл байсан			
Мал цөөтэй учир			
Бусад			

6. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр дүн, ахиц дэвшил гарсан зүйлүүд

6-1 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн

Бэлчээрийн ургамлын байдал	Хаваржaa	Сайн байсан	Муу байсан	Сайн мэдэхгүй
	Зуслан	Сайн байсан	Муу байсан	Сайн мэдэхгүй
	Намаржaa	Сайн байсан	Муу байсан	Сайн мэдэхгүй
	Өвөлжөө	Сайн байсан	Муу байсан	Сайн мэдэхгүй
	Шалтгаан			
Бэлчээр ашиглалт	Нүүдлийн хувь	Сайн байсан	Муу байсан	Сайн мэдэхгүй
	Шалтгаан			
	Төлөвлөгөөний чанар	Сайн байсан	Муу байсан	Сайн мэдэхгүй
	Шалтгаан			
Бусад зүйл				

6-2 Засаг захиргаа, удирдлагын үйл ажиллагаа

Засаг захиргаа, удирдлага	Сайн	Дунд	Муу	Мэдэхгүй байна
Сум				
Баг				
Бүлгийн ахлагч				

4.3 Үнэлгээ хийх

Мониторинг судалгааны үр дүнд бий болсон бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй бэрхшээлтэй асуудал болон дүн шинжилгээ хийх зорилгоор малчид болон орон нутгийн захиргаа оролцсон уулзалт зохион байгуулж мэдээллээ нэгтгэн, хэрхэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг сайжруулж, тогтвортой үргэлжлэх боломжтой болгох талаар хэлэлцэнэ. Мөн холбогдох талууд харилцан санал бодлоо солилцож, төлөвлөгөөний талаарх малчдын ойлголтыг нэгтгэж, тухайн асуудлыг сайжруулах бодит алхмуудыг болон хүндрэлтэй байгаа асуудлуудыг тодруулан цаашид сайжруулах аргазам, үе шат, дарааллыг хэлэлцэнэ.

Уулзалтын үр дүнг бэлчээр ашиглалтын цаашдын төлөвлөгөөнд тусгаж ажиллана.

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгараад буй асуудлуудыг харилцан хэлэлцэн тогтох, шийдвэрлэх арга хэмжээ

(Уулзалтын үеэр хэлэлцэх асуудлын жишээ)

Хүснэгт 4.5

Асуудлыг тодруулах		Шийдвэрлэх бодлого	Шийдвэрлэх бодит алхам
Ангилал	Агуулга		
Журамд үндэслэн арга хэмжээ авах	<ul style="list-style-type: none"> Зэргэлдээх сумдтай хамтран хэлэлцэж тодруулах шаардлагатай 	<ul style="list-style-type: none"> Гэрээ байгуулах 	<ul style="list-style-type: none"> Сум хооронд хуульд үндэслэсэн гэрээ байгуулах
Захиргааны зааварчилгаа	<ul style="list-style-type: none"> Бэлчээр ашиглалттай холбоотой зааварчилгааг сумас малчдад өгөх шаардлагатай Багийн удирдлагыг чадавхжуулах 	<ul style="list-style-type: none"> Захиргааны удирдлагыг сайжруулах 	<ul style="list-style-type: none"> Бэлчээр ашиглалттай холбоотой ойлголт дутмаг малчдад захиргаанаас зааварчлах Багийн зүгээс бэлчээр ашиглагчдын бүлэгтэй уулзалт хийх үедээ зааварчилгаа өгнө
Бэлчээр ашиглагчдын бүлэг	<ul style="list-style-type: none"> Бүлгийн үйл ажиллагааг тааруу Малчдын идэвх муу Малчдын оролцоо дутмаг Мал хөрөнгө муу 	<ul style="list-style-type: none"> Бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх Бүлэг өөрөө бэлчээр ашиглалтыг хянаж чадах тогтолцоо бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> Малчид бүгд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг ойлгож, ойлголтоо нэгтгэнээр хэрэгжилтийн үзүүлэлт өснэ Бүлгийн уулзалтыг зохион байгуулах боломжийг нэмэгдүүлэх Иргэдийн төлөөлөгчийн хурлаар саналаа солилцох Сумын албан хаагчдад малчдын үйл ажиллагааг танилцуулж, зааварчилгаа авах Мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах

Бэлчээр ашиглалтын төлөөвлөгөө боловсруулах зөвлөмж

Бэлчээр	<ul style="list-style-type: none"> • Мал хэт төвлөрсөн • Бэлчээрийн ургамал доройтсон • Бэлчээрийн малын тоо толгой их • Ашиглах боломжтой бэлчээр хязгаарлагдмал 	<ul style="list-style-type: none"> • Бэлчээрийн хориотой газрыг нэмэгдүүлэх • Малын нягтралыг бууруулах • Өвөлжөөний бэлчээрээ хамгаалах 	<ul style="list-style-type: none"> • Бүлэг бүрийн бэлчээрийг хэлэлцэж тодорхойлох • Бэлчээрийн хүрээг газар дээр нь үзэж судлах • Өвөлжөөний бэлчээрийн хил хязгаарыг тодорхой болгох
Усны хангамжийн дутагдал	<ul style="list-style-type: none"> • Усны дутагдлаас үүдэн бэлчээрийг ашиглах боломжгүй 	<ul style="list-style-type: none"> • Хиймэл цөөрөм бий болгох • Гар худаг ухах 	<ul style="list-style-type: none"> • Сумын захирагаанаас дэмжлэг авах • Өөрсдөө хамтран гар худаг гаргах

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

(Өвөрхангай аймагт “Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө
боловсруулсан болон хэрэгжилт”-ийн жишээ)

1. Тарагт сумын Туяа баг
 - 1.1 Санал асуулга явуулах аргаар тухайн орон нутгийн нөхцөл, нөөц боломжийг судлан түүнд тулгуурласан ўйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
 - 1.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж шийдвэрлэх асуудал
 - 1.3 Орон нутгийг сонгох
 - 1.4 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах чиглэл
 - 1.5 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэгч бүрэлдэхүүн болон үүрэг
 - 1.6 Тарагт сумын Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ўйл явц
 - 1.7 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон мониторинг
2. Баруун Баян-Улаан сумын 2 дугаар баг
 - 2.1 Санал асуулга явуулах аргаар тухайн орон нутгийн нөхцөл, нөөц боломжийг судлан түүнд тулгуурласан ўйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
 - 2.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж шийдвэрлэх асуудал
 - 2.3 Орон нутгийг сонгох
 - 2.4 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах чиглэл
 - 2.5 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэгч бүрэлдэхүүн
 - 2.6 Баруун Баян-Улаан сумын 2 дугаар багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ўйл явц
 - 2.7 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах
 - 2.8 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг шийдвэрлэх
 - 2.9 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон мониторинг

**“Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах
болон хэрэгжилт”-ийн
Өвөрхангай аймаг дахь жишээ**

1. Тарагт сумын Туяа баг

1.1 Санал асуулга явуулах аргаар тухайн орон нутгийн нөхцөл, нөөц боломжийг судлан түүнд тулгуурласан үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

Орон нутгийн өнөөгийн нөхцөл байдлыг (байгаль, нийгэм, хүн амын, материалын, санхүүгийн гэсэн таван нөөц) судалсан нь орон нутаг дахь нөөц боломжийн талаарх ойлголтыг өгсөн. Нөөц боломж, түүнийг ашиглах болон хэрэгжүүлэх арга хэмжээг хүснэгт 1.1-т тоймлон үзүүллээ.

Хүснэгт 1.1

Тарагт сумын нөөц боломж, түүнийг ашиглах болон хэрэгжүүлэх арга хэмжээ

Гарчиг	Тарагт сум	
	Нөхцөл, нөөц боломж	Арга хэмжээ
Байгалийн нөөц		
Жилд орох хур тунадасны хэмжээ Температур	<ul style="list-style-type: none"> Дунджаар 213mm (11 жилийн туршид өөрчлөгдсөн байдал 120 mm-303 mm) Бүтэн жилийн турш нам температуртай 	<ul style="list-style-type: none"> Усжуулалтын технологийг нэвтрүүлэх Тохиромжтой тариалангийн төрлийг сонгох
Ургамал	<ul style="list-style-type: none"> Сумын өмнөд хэсгийн ургамал өөрчлөгдж эхэлсэн (Хөрс хуурайшсан) 	<ul style="list-style-type: none"> Тэжээлийн болон бэлчээрийн ургамал тариалах Бэлчээрийн менежментийг сайжруулах
Хөрс	<ul style="list-style-type: none"> Ууландаа хөрс сайтай 	<ul style="list-style-type: none"> Хүнсний ногоо болон тэжээлийн ургамал тариалах
Усны нөөц	<ul style="list-style-type: none"> Худаг эвдрэх Үерийн усанд дайрагдах 	<ul style="list-style-type: none"> Задгай усыг ашиглах Эвдэрсэн худгуудыг засварлах Ус хуримтлуулах технологийг нэвтрүүлэх
Нийгмийн нөөц		
Малчдын бүтэц	<ul style="list-style-type: none"> Нэгдэл тарснаас хойш эвлэл, хоршооны зохион байгуулалт байхгүй 	<ul style="list-style-type: none"> Бүлгээр нэгдэж ажиллах
Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төв	<ul style="list-style-type: none"> Байгаа 	<ul style="list-style-type: none"> Хамтран ажиллах
Хүний нөөц		
Тариалалт эрхлэх технологи	<ul style="list-style-type: none"> Малчдын ихэнх нь туршлагагүй 	<ul style="list-style-type: none"> Дадлагажкуулах
Хөдөлмөрлөх хүч	<ul style="list-style-type: none"> Өмнөд хэсгийн нутгийн нүүдэллэх газар нь хол 	<ul style="list-style-type: none"> Бүлэг болон нэгдэж хөдөлмөрийн хуваарътай ажиллах

Материалын нөөц		
Сүргийн бүтэц, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Хонины эзлэх хувь өндөр (хонь 58%, ямаа 32%, үхэр, адтуу, тэмээнийт 10%) 	<ul style="list-style-type: none"> Малын чанарыг сайжруулах
Газар тариалангийн нөөц	<ul style="list-style-type: none"> Суулгац, үр, жижиг тариалангийн багаж зэрэг дутмаг 	<ul style="list-style-type: none"> Бүлэгтээ бий болгох.
Бүтээгдэхүүний борлуулалт	<ul style="list-style-type: none"> Бүх өрхүүд тус тусдаа худалдан борлуулдаг 	<ul style="list-style-type: none"> Бүлгээрээ нэгдэж борлуулах
Санхүүгийн нөөц		
Санхүү	<ul style="list-style-type: none"> Банк, санхүүгийн байгууллагатай харьцахад хэцүү (Өндөр хүүтэй барьцаа шаардлагатай) 	<ul style="list-style-type: none"> Жижиг зээл Малын банк

1.2 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж шийдвэрлэх асуудал

“Шар шороон шуурганы эх үүсвэрийг судлах” судалгааны объект болох Тарагт сумын бэлчээр ашиглалтын байдлыг доор танилцуулав.


Тарагт сумын нутагт аймгийн төв болох Арвайхээр сум багтдаг. Тарагт сум нь өмнө зүгийн сумдуудтай харьцуулахад бэлчээрийн ургамлаар баялаг. Аймгийн төвтэй ойрхон байдгаас аймгийн зах зээл дээр сүү, цагаан идээгээ борлуулах зорилгоор Тарагт сумын урд талын ойролцоо сумдаас орж ирэх малчин өрхийн тоо сүүлийн жилд эрс нэмэгдсэн.

Мөн хүүхдүүдээ аймгийн төвийн сургуульд явуулахын тулд бусад сумдаас Тарагт сумд суурьших малчин өрхийн тоо ч нэмэгдсээр байна. Тарагт сумын бэлчээр ашиглалттай холбоотой асуудлыг хүснэгт 1-2-т үзүүлэв.

Хүснэгт 1.2

Тарагт сумын бэлчээр ашиглалтын байдалтай холбоотой асуудал

Сумын нэр	Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал	Бэлчээр ашиглалтын асуудал
Тарагт сум	Тарагт сумын малчид ерөнхийдөө өөрийн сумын доторх бэлчээрийг ашигладаг.	Бэлчээрийн ачаалал ихтэй учир ургамлын доройтол бий болох гол шалтгаан болж байна.
	Бусад сумдаас орж ирэх малчдын нүүдэл ихтэй.	Бусад сумдаас орж ирэх малчдад хандсан дүрэм, журам байхгүй нь бэлчээрийн маргааны гол шалтгаан болж байна.



Зураг 1.1 Тарагт сумын Туяа багийн байрлал

1.3 Орон нутгийг сонгох

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахад хүснэгт 1-2-т нэгтгэсэн бэлчээр ашиглалттай холбоотой асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж, багийн түвшин дэх захиргааны нэгжийг сонгосон. Түүнчлэн ургамалжилтын дортойтлын түвшин, бусад багаас орж ирэх малчдын нүүдэл зэрэг бэлчээр ашиглалтыг тойрсон асуудал илэрхий ихтэй тул Туяа багийг сонгосон.

1.4 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах чиглэл

Бодит байдлыг сайтар ойлгож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорилго болгон бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулахад доорхи үндсэн чиглэлийг баримтлах шаардлагатай.

(1) Тарагт сумын Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний агуулга

Орон нутгийн хэмжээнд бэлчээр талхлалтыг зогсоож, ургамлын нөхөн сэргэх чадварыг сайжруулахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулна.

(2) Бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах

Сум хоорондын бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө малчин өрх тус бүрээр биш харин өвөлжөө, хаваржааны байршлыг үндэслэн бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулж тэд өөрсдөө бэлчээрийнхээ асуудлыг зохицуулж мөн хянаж ажиллах нь чухал байна.

1.5 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэгч бүрэлдэхүүн болон үүрэг

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Өвөрхангай аймгийн Тарагт сум, болон Туяа багийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, сонгогдсон нутгийн бэлчээр ашиглагчдын бүлэг, малчид хамтран ажилласан. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр дүнтэй хэрэгжилтийг хангахад малчдад зориулсан сургалт, бэлчээр ашиглалтын байдал болон ургамалжилтын судалгаа тэдгээрт хийх дүн шинжилгээ зэрэг мэргэжлийн үүднээс ХААИСургууль хамтран ажиллаж судалгааг хэрэгжүүлсэн.



Зураг 1-2 Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх бүрэлдэхүүн

Мөн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж үр бүтээлтэй хэрэгжүүлэхийн тулд холбогдох хүмүүсийн үүргийг хүснэгт 1-3-т нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 1.3

Багийн түвшинд бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах болон хэрэгжүүлэхэд холбогдох хүмүүсийн гүйцэтгэх үүрэг

Ангилал	Үүрэг
Малчин	<ul style="list-style-type: none"> Сургалтанд оролцож, ургамлын доройтлын шалтгаан, бэлчээр ашиглах төлөвлөгөөний үр ашгийг ойлгох Бүлгийн ахлагч удирдан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцэх Бүлгийн хэлэлцсэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн иргэдийн нийтийн хурлаар боловсруулах Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбоотой асуудлыг тухай бүрд нь сумд дамжуулах
Захиргааны ажилтан	<p>Аймаг (Бэлчээр ашиглалттай холбоотой асуудал хариуцсан ажилтан)</p> <ul style="list-style-type: none"> Сургалтанд оролцож, ургамлын доройтлын шалтгаан, бэлчээр ашиглах төлөвлөгөөний үр ашгийг ойлгох Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бус нутгийг сонгох Тухайн сонгосон нутагт бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах Малчдад зориулсан сургалтад оролцох болон малчдын саналыг сонсох Малчдын хэлэлцсэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр бүтээлийг дээшлүүлэхэд захиргааны зүгээс анхаарал тавих Зэргэлдээх сумдтай бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцэх тохиорох Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад бий болсон сум хоорондын бэлчээр ашиглалтын маргааныг шийдвэрлэх

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

Захиргааны ажилтан	Сум (Сумын засаг дарга болон бусад бэлчээр ашиглалттай холбоотой ажилтан)	<ul style="list-style-type: none"> • Сургалтанд оролцож, ургамлын доройтлын шалтгаан, бэлчээр ашиглах төлөвлөгөөний үр ашгийг ойлгох • Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бус нутгийг сонгох • Тухайн сонгосон нутагт бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах • Малчдад зориулсан сургалтад оролцох болон малчдын саналыг сонсох • Малчдын хэлэлцсэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр бүтээлийг дээшлүүлэхэд захиргааны зүгээс анхаарал тавих • Сумын иргэдийн нийтийн хурлаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг батлах • Зэргэлдэх сумдтай бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулж бэлчээр ашиглалтын дүрэм журамыг нийтэд мэдээлэх • Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад бий болсон сум хоорондын бэлчээр ашиглалтын маргааныг шийдвэрлэх
Баг (Багийн дарга, багийн иргэдийн нийтийн хурлын дарга)		<ul style="list-style-type: none"> • Сургалтанд оролцож, ургамлын доройтлын шалтгаан, бэлчээр ашиглах төлөвлөгөөний үр ашгийг ойлгох • Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх бус нутгийг сонгох • Тухайн сонгосон нутагт бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах • Малчдад зориулсан сургалтад оролцох болон малчдын саналыг сонсох • Малчдын хэлэлцсэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр бүтээлийг дээшлүүлэхэд захиргааны зүгээс анхаарал тавих • Сумын иргэдийн нийтийн хурлаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг батлах • Зэргэлдэх сумдтай бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулж бэлчээр ашиглалтын дүрэм журамыг нийтэд мэдээлэх • Төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад бий болсон сум хоорондын бэлчээр ашиглалтын маргааныг шийдвэрлэх
ХААИС		<ul style="list-style-type: none"> • Малчид, захиргааны албан хаагчдад зориулж ургамлын доройтолын шалтгаан, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр ашгийг таниулах сургалт зохион байгуулах • Тухайн сонгосон нутгийн бэлчээр ашиглалтын байдал, бэлчээрийн ургамлын судалгаа • Дээрх судалгааны үр дүнг нэгтгэж дүн шинжилгээ хийх • Дун шинжилгээ хийсний эцэст өнөөгийн бэлчээр ашиглалтын байдлын болон бэлчээрийн ургамалжын зургийг гаргах • Тус боловсруулсан зурагт үндэслэн малчид, захиргааны албан хаагчдад бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал, бэлчээрийн ургамлын талаар сургалт зохион байгуулах • Малчдын хэлэлцсэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбоотой санал, зөвлөгөөг өгөх • Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцсэн үр дүнд үндэслэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зургийг гаргах • Зэргэлдэх сумдуудад ургамлын доройтолын шалтгаан, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр ашиг, тухайн сонгосон нутгийн бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал, бэлчээрийн ургамлын талаар тайлбарлах

1.6 Тарагт сумын Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх үйл явц

(1) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх явц болон үйл ажиллагааны товч агуулга. Тарагт сумын Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хүснэгт 1-4-т үзүүлсэн явцын дагуу боловсруулсан.

Хүснэгт 1.4

Тарагт сумын Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулсан дараалал

Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны агуулга
1. Аймаг, сумын холбогдох албан хаагчидтай хамтран бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах орон нутгийг сонгох (Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хийгдэх объект болох орон нутгийг сонгоно)
2. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд аймаг, сумын захиргааны албан хаагчдыг сургалтанд хамруулж, тэдний чадавхийг дээшлүүлэх
3. Аймаг, сумын захиргааны албан хаагчдад бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах арга барилд дадлагажуулах (Тарагт сумын Туяа багийн малчин өрхүүдийг бүлэг болгон зохион байгуулах)
4. Туяа багийн малчдын бүлгүүдийг бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах арга барилд дадлагажуулах
5. Багийн хэмжээний бэлчээр ашиглалтын байдал болон бэлчээрийн ургамалжлыг тодорхой бэлчээрүүд дээр судлах
6. Багийн хэмжээний бэлчээр ашиглалтын байдал болон ургамалжлын судалгааны үр дүнг нэгтгэж, дүгнэлт хийх
7. Багийн хэмжээний бэлчээр ашиглалтын байдлын схем зургийг боловсруулах
8. Туяа багийн малчдын бүлгийн ахлагч нарыг хамруулж бэлчээрийг хяналттай ашиглахтай холбоотой сургалт зохион байгуулах (Аймаг, сумдын захиргааны албан хаагчдын оролцоотойгоор)
9. Туяа багийн малчдын бүлгүүдэд бэлчээр ашиглалтын зураг ашиглаж бэлчээр ашиглалтын тухай сургалт, санал асуулга зохион байгуулах (Аймаг, сумын захиргааны албан хаагчдын оролцоотойгоор)
10. Туяа багийн малчидтай хамтран бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх
11. Аймаг, сумын захиргааны албан хаагчид, малчдын бүлгүүд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцэн зөвшилцэх мөн засаг захиргааны удирдлагын зүгээс холбогдох шаардлагатай албан бичиг, мэдэгдэх хуудас зэргийг бэлтгэн боловсруулах
12. Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зураг боловсруулах
13. Туяа багийн иргэдийн нийтийн хурал, Тарагт сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулах
14. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбогдсон асуудлуудаар зэргэлдээх сумдтай гэрээ, хэлэлцээр хийх

(2) Бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах

Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа багийн нийт малчин өрхийг бүлэг болгон зохион байгуулж, энэхүү бүлгүүдэд тулгуурлан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

Туяа багийн нутаг дэвсгэр дэх бэлчээрийг зэргэлдээх Баянгол, Төгрөг зэрэг сумдын нэлээд хэдэн малчин өрхүүд байнга ашигладаг уламжлалтай бөгөөд тэдгээр малчдыг ч мөн оролцуулан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулсан. Туяа багийн нийт малчин өрхүүдийг өвөлжөөний байршил дээр тулгуурлан нийт 10 бүлэгт хуваасан юм. Мөн бүх бүлгүүд дотроо хэлэлцэж бүлгийн ахлагч болон дэд ахлагчаа сонгосон. Мөн бүлэг тус бүрт сургалт, санал асуулга зохион байгуулсан.


Хүснэгт 1.5

**Тарагт сумын Туяа багийн малчдын бүлгүүдийн малын тоо,
толгой**

№	Бүлгийн нэр	Өрхийн тоо	Малын төрөл, тоо толгой						
			Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	Нийт	Хонин толгойд шилжүүлсэн тоо
1	Хилэнгийн хадат	35	6,650	4,811	189	570		12,220	16,103.9
2	Сөрт	32	7,261	4,754	120	194	8	12,337	13,657.6
3	Олон худаг	22	3,647	3,207	32	114		7,000	7,523.3
4	Туяа	22	5,170	3,311	229	463	5	9,178	12,789.9
5	Даравгай	30	4,889	2,376	33	75	1	7,374	7,755.4
6	Жирмийн олон худаг	11	1,413	1,405	13	66	5	2,902	3,242.5
7	Жирэм	14	4,496	2,519	194	326	2	7,537	10,219.1
8	Шовхийн хоолой	21	5,641	3,497	271	547		9,956	14,243.3
9	Үндай	24	4,063	3,125	59	200		7,447	8,629.5
10	Хадан ус	19	3,242	1,941	76	177		5,436	6,683.9
	Нийт	230	46,472	30,946	1,216	2,732	21	81,387	100,848.4

*Хонин толгойд шилжүүлсэн индекс (Ямаа:0.9 Хонь:6.0 Адуу:7.0 Тэмээ:5.0)

(3) Төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай суурь мэдээллүүдийг цуглуулж дүн шинжилгээ хийх



Зураг 1.3 Туяа багийн
малчдын бүлгүүдийн
байрлал

Судалгаа хийх

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн бэлчээр ашиглаж байгаа малчин өрхүүдийн бэлчээр ашиглалт болон бэлчээрийн ургамалжлын байдал зэрэгт доорхи агуулгаар урьдчилан судалгаа хийсэн.

[Судалгааны агуулга]

- 1) Бэлчээрийн ангилал
- 2) Бэлчээрийн шинж
- 3) Сум, багийн хил зааг
- 4) Зуны хугацаанд ургамлын хамгийн их арвтай үе
- 5) Бэлчээрийн ургамлын төрөл, бүтэц
- 6) Өрх айлын тоо болон өрх тус бүрийн малын төрөл, тоо толгой
- 7) Бэлчээрийн ачаалалтыг улирал бүрээр тогтоох
- 8) Улирал бүрээр бэлчээрийн ургамлын тэжээллэг байдлыг тогтоох (Бэлчээрлэх боломжтой малын тоог тогтоох)
- 9) Бэлчээрийн усан хангамж, худаг усны байдал (байрлал, шинж байдал)
- 10) Улирал бүрийн бүлгээрээ ашиглах бэлчээр
- 11) Улирал бүрийн ашиглах бэлчээрийн хил заагийг тогтоох
- 12) Улирал бүрийн бэлчээрийг ашиглах хугацаа (бэлчээр ашиглалтын зургандаа оруулах)

(4) Туяа багийн бэлчээр ашиглалтын байдал болон бэлчээрийн ургамлын доройтол

- 1) Бэлчээр ашиглалтын байдал

Бэлчээр ашиглалтын байдлыг судалсан судалгааны үр дүнг зураг 1-4-т үзүүлэв.

Бэлчээр ашиглалтын хувьд Туяа багийн бэлчээрийн ойролцоогоор 76.2 хувь нь жилийн турш ашиглагдаж байгаа нь бэлчээрийн

ургамлын нөхөн сэргэлтэд муу нөлөө учруулж байна.

Бусад бэлчээрийн хувьд зун 12.3%, өвөл, хавар 5.9%, зун, намар 3.7%, зөвхөн намар 1.9%-ийг ашигладаг байжээ.

2) Бэлчээрийн ургамлын доройтлын байдал

Бэлчээрийн ургамлын доройтолд дүн шинжилгээ хийсний үр дүнг зураг 1-5-д үзүүлэв. Ургамлын доройтлын бүхий л шатлалыг доор стандартилж үзүүлье.

Хүснэгт 1.6


Бэлчээрийн ургамлын доройтлын түвшин	Шинж, байдал
Бага зэргийн доройтол	Бэлчээрт голлон ургадаг ургамлын төрөл өөрчлөгдөөгүй, ургамлын бүрхэцэд ямар ч өөрчлөлт ажиглагдахгүй боловч идэмж сайтай ургамлуудын ургац багасах
Дунд зэргийн доройтол	Бэлчээрт голлон ургадаг ургамал нь өөрчлөгдөөгүй боловч идэмж сайтай ургамлууд нь багасч, бусад ургамлууд давамгайлан ургах
Хүчтэй доройтол	Бэлчээрт голлон ургадаг ургамалууд нь өөрчлөгдөж, нэг наст ургамалууд болон түүнээс гадна мал иддэггүй хог ургамалууд давамгайлан ургах

Нийт бүлгүүдийн бэлчээрийн ургамалжлын судалгааны дүнгээс харахад 46.3% нь хүчтэй, 37.4% нь дунд зэрэг, 16.3% нь бага зэрэг доройтсон байна. Жилийн турш ашиглагддаг бэлчээрүүд хүчтэй доройтдог байна. Мөн усны нөөц муутай бэлчээр бага доройтдог болох нь ажиглагдаж байна

Хүснэгт 1.7

Туяа багийн бэлчээрийн ургамлын байдал


№	Бүлгийн нэр	Талбай (га)	Доройтлын түвшний харьцаа (%)		
			Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1	Хилэнгийн хадат	15,252.2	74.7	25.3	0
2	Серт	8,973.9	69.5	30.5	0
3	Олон худаг	8,350.6	0.1	78.7	21.2
4	Туяа	14,385.3	22.8	41.9	35.3
5	Даравгай	8,691.0	33.9	47.6	18.5
6	Жирмийн олон худаг	2,920.1	100		
7	Жирэм	14,242.8	21.6	47.4	31.0
8	Шовхийн хоолой	17,012.9	64.6	14.5	20.9
9	Ундай	14,798.9	73.6	25.6	0.8
10	Хадан ус	9,197.5	14.2	57.9	27.9
	Нийт	113,825.2	46.3	37.4	16.3



Зураг 1.4 Туяа багийн бэлчээр ашиглалтын өмнөх байдал

Анхаар:


Улаан (жилийн турш ашиглагдаж байгаа бэлчээр),
Улбар шар (өвөлжөө, хаваржаа),
Цайвар ногоон (зуслан, намаржваа),
ногоон (зуслан),
шар (намар ашиглаж байгаа бэлчээр)




Зураг 1.5 Туяа багийн бэлчээрийн ургамлын доройтлын байдал

Анхаар:


Хүчтэй доройтсон



Дунд зэргийн доройтсон



Бага зэрэг доройтсон




(5) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг шүүн хэлэлцэх

Туяа багийн 10 бэлчээр ашиглагчдын бүлэгт 8 дугаар сард явуулсан судалгааны үндсэндээр бий болсон бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний болон бэлчээрийн ургамалшилтын зургийг үндэслэж бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний хэлэлцүүлгийг 11-дүгээр сарын дунд үеэс 12-дугаар сарын эхний хагас хүртэл бүлгүүдэд хэрэгжүүлсэн.

- 1) Бүх бүлгүүд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг шүүн хэлэлцэнэ.

Туяа багийн бэлчээр ашиглалтын зургаас харахад жилийн турш ашиглагдаж байгаа бэлчээрт ургамлын хүчтэй доройтол явагдаж байгаа учир бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгахдаа бүлэг тус бүр өвөлжөө хаваржааны бэлчээрээ зүн, намрын улиралд бүрэн чөлөөлж нүүхээр хэлэлцэн тохирсон.

Мөн бүх бүлгүүд зуслан, намаржаандаа нүүхдээ бэлчээрт нэг доор малын төвлөрөл их болгохгүйн үүднээс заавал бүлгээрээ нэг доор нүүж очих биш хот айлаараа бэлчээрээ сонгож нүүх боломжийг шийдвэрлэж чадсан. Өвөлжөө, хаваржааны бэлчээрээс зуслан, намаржааны бэлчээрт нүүсний дараа өвөлжөө хаваржааны бэлчээрт гадны сумдын малчид орж ирэхээс хамгаалахын тулд бүлэг дотроосоо бэлчээр хариуцагч өрх сонгосон ба ийм өрхөөр ихэвчлэн нүүх боломж муутай, мал цөйтэй өрхүүд сонгогдсон байна. Бэлчээр ашиглагчдын бүлэг тус бүрийн нүүх бэлчээрийг зураг 1-6-д нэгтгэв.



Зураг 1.6 Бүлэг тус бүрийн нүүх бэлчээрийн төлөвлөгөө

(6) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр бүтээлтэй хэрэгжих нөхцлийг бурдүүлэх

1) Боловсруулсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг зэргэлдээх сүмдтайгаа хэллэлцэж тохирох

Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний талаар зэргэлдээх сумдад ойлголт, мэдээлэл өгөх болон хамтарч ажиллах зорилгоор Арвайхээр, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Хайрхандулаан, Богд зэрэг сумдын удирдлагатай Өвөрхангай аймаг, Тарагт сумын Туяа багийн бэлчээрийн менежмент төлөвлөгөөг хэлэлцэх уулзалт хурлыг зохион байгуулсан.

Мөн хурлын үеэр Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн зүгээс Туяа багийн бэлчээр ашиглалтын байдал болон бэлчээрийн ургамлын нөхцөл байдлын (доройтлын) тухай судалгааны дүнг танилцуулав. Тарагт сумын удирдлагын зүгээс Туяа багийн бэлчээрийн менежмент төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт болон газрын тухай хуульд үндэслэн тус багийн бэлчээр ашиглалтанд мөрдөх журмыг тайлбарлав.

2) Зэргэлдээх сумдтай хэлэлцэн шийдвэрлэх зүйлс

Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр ашигтай хэрэгжүүлж, бэлчээр сэлгэлтийн нөхцлийг хангахын тулд бэлчээр ашиглагчдын бүлэг өвөлжөө хаваржааны бэлчээрээс зуслан, намаржaa руу нүүсний дараа зэргэлдээх сумдын малчид тухайн өвөлжөө хамаржааг зун, намар ашиглахгүй байх шаардлагатай. (Зурагт дэлгэрэнгүй үзүүлэв) Энэ талаар захиргааны удирдлага, захиргааны албан хаагчид хэлэлцэн ярилцсаны үр дүнд газар ашиглалтын тухай хуулийн 52.2-т үндэслэн өвөлжөө хаваржааны бэлчээр ашиглалтын журам гаргаж, зөрчсөн хүнд торгууль хүлээлгэж байхаар шийдвэрлэсэн. (Доор газар ашиглалтын хуулийн заалтыг оруулав) Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбогдсон асуудлаар зэргэлдээх сумд болон Өвөрхангай аймагтай хэлэлцсэний үр дүнд Тарагт болон зэргэлдээх сумдын хооронд бичгээр гэрээ хийгдсэн.

Зэргэлдээх сумдуудтай хэлэлцэн шийдвэрлэх асуудлууд

- Бэлчээрийг сэлгээтэй ашиглах, чөлөөлсөн бэлчээрийг (Өвөлжөө, хаваржааг зуны турш өнжүүлэх) бусад сумын малчид ашиглахгүй байх, зөрчсөн этгээдэд газрын тухай хуулийг үндэслэн торгууль оногдуулах
- Туяа багийн бэлчээрт гадны сумдын малчид орохыг хориглох
- Ган, зудтай хэцүү үед сум хоорондын отрын бэлчээрийг тогтоож ашиглах талаар тухай бүрд нь сум хооронд хэлэлцэж шийдвэрлэж байх

Тарагт сүм



Зураг 1.7 Туяа багийн бэлчээрт зэргээлдээх сумдаас орж ирдэг
малчдын нүүдэл

Газрын тухай хуулийн заалтаас

52.2. Зуслан, намаржaa болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Зуслан, намаржaa болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана. Тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг сүм, дүүргийн Засаг дарга тогтоож, баг, хорооны Засаг дарга, иргэд мөрдөж хэрэгжүүлнэ. Өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн бүс нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан, багийн ИНХ-ын саналыг үндэслэн сумын Засаг дарга малчдад болзол, гэрээний дагуу хэсэг бүлгээр ашиглуулж болно.

63.1.8. энэ хуулийн 52.2, 53.3, 54.3-т заасан журмыг зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс дөрөв дахин, байгууллага, аж ахуйн нэгжийг арваас хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хохирлыг нөхөн төлүүлнэ.

Дараах байдлаар сум хоорондын гэрээг байгуулав.

Тарагт сумын зэргэлдээх сумдтай хийсэн гэрээ

Өвөрхангай аймгийн Тарагт сум болон зэргэлдээхсумын засаг даргын тамгийн газар хооронд бэлчээр ашиглалтын хяналт болон төлөвлөгөөтэй холбогдуулж дараах гэрээг байгуулав.

2008 оны 1-р сарын 18

(1) Гэрээний үндэслэл

Тус гэрээг Монгол улсын захирагааны хариуцлагын тухай хуулийн 48.1, газрын тухай хуулийн 52.2 болон 63.1.8-д үндэслэн Туяа багийн өвөлжөө, хаваржааны тодорхой нутаг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор Туяа багийн ИНХ болон Тарагт сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн гэрээ байгуулагч 2 сумын хоорондын харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

(2) Тарагт сумын үүрэг

- 1) Туяа багийн малчдын өвөлжөө, хаваржааны бэлчээр ашиглалтыг хязгаарлах
- 2) Туяа багийн чөлөөлсөн өвөлжөө, хаваржааны бэлчээрт зэргэлдээх сумдын малчдын нүүдлийг оруулахгүй тулд Туяа баг нь зэргэлдээх сумдын малчдын ахлагчтай уулзаж, харилцан ойлголцох
- 3) Туяа багийн чөлөөлсөн хамгаалж байгаа өвөлжөө, хаваржааны бэлчээрт нүүж ирсэн бусад сумын малчдыг “Газрын тухай хуулийн 63.1.8-д заасны дагуу хөдөлмөрийн хөлсний хамгийн доод хэмжээг нэгээс дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 4) Чөлөөлсөн бэлчээрийн хил хязгаарыг мэдэгдэхүйц газарт орохыг хориглосон самбар босгох

(3)(бусад) сумын үүрэг

- 1) Туяа багийн чөлөөлсөн бэлчээрт сумын малчдыг оруулахгүй байх талаар үүрэг өгөх
- 2) Туяа багийн нутагт нутаглаж байгаа (бусад) сумын малчидтай ярилцаж, (бусад) сум руу нь нүүлгэх үү, эсвэл Тарагт сумын харьяанд бүртгэх үү гэдгийг Тарагт сумтай хэлэлцэж шийдвэрлэх
- 3) Тарагт сумын нутагт өвөлжөө, хаваржaa эзэмшдэг малчид газрын татвараа Тарагт сумд төлөх

(4) Хоёр талын үүрэг

- 1) Гэрээг хоёр тал харилцан биелүүлэхэд анхаарна.
- 2) Гэрээний биелэлтийг хангахын тулд сум тус бүрийн малчдад сайтар тайлбарлан таниулах
- 3) Гэрээний агуулгыг өөрчлөх шаардлагатай болсон тохиолдолд сумын засаг дарга нар хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

(5) Гэрээний хугацаа

- 1) Уг гэрээ нь гэрээнд гарын үсэг зурсан мөчөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

(6) Бусад

- 1) Уг гэрээгээр шийдвэрлэгдэх боломжгүй зүйл гарвал хоёр сум хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2) Хэрвээ хамтран хэлэлцэж, шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тарагт сумын засаг дарга..... сумын засаг дарга.....

3) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр бүтээлтэй хэрэгжүүлэх иргэдийн нийтийн хурлын тогтоол

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг шийдвэрлэж, хэрэгжилтийг хангахаар баг болон сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэж тушаал гаргав.

(а) Багийн ИНХ-ын шийдвэр

Туяа багийн ИНХ-аар төлөвлөгөөнд доорхи агуулгыг тусгаж хэлэлцэн шийдвэрлэсэн.

- 10 бүлгийн бүх малчид 6-р сарын 15~10-р сарын 15 хооронд бэлчээр сэлгэж нүүнэ.
- Бүлэг дотроос 1~2 өрхийг сонгож хаваржаа, өвөлжөөний бэлчээрийг хамгаалуулна.
- Чөлөөлсөн, хамгаалж буй бэлчээрт гадны сумдын малчдыг оруулахгүй байх
- Бусад сумдын хаваржаа, өвөлжөөг ашиглавал татвар төлөх
- Бэлчээр ашиглалтын журмыг мөрдөөгүй тохиолдолд торгууль ноогдуулах.

Тарагт сумын Туяа багийн ИНХ-ын тогтоол

2008 оны 1-р сарын 4

Дугаар:01

Хүрэмт

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний тухай

Туяа багийн малчдын бүлгийн өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зохистой ашиглахтай холбогдуулж, бэлчээр ашиглагчдын бүлгийн ахлагчдын саналыг цуглуулан, түүний үр дүнг ИНХ-аар зөвлөлдөж доорхи тогтоолыг гаргалаа.

1. Цөлжилтийг бууруулах болон бэлчээрийг хамгаалах зорилгоор 10 бүлгийн бүх малчин өрх жил бүрийн 6-р сарын 15-аас 10-р сарын 15 хүртэл өвөлжөө болон хаваржааны бэлчээрээс нүүнэ. Үүнийг Туяа багийн бүх бүлэг болон бүлгийн малчдын үүрэг болгосугай.
2. Бүлгийн малчин өрхөөс 1-2 өрх сонгон өвөлжөө болон хаваржааны бэлчээрийг хамгаалуулах явдлыг нийт 10 бүлгийн үүрэг болгосугай.
3. Чөлөөлсөн бэлчээрт гадны сумдын малчид, малыг оруулахгүй байхыг нийт бүлгийн гишүүд, бүлгийн ахлагч, багийн дарга, багийн ИНХ-ын дарга нарын үүрэг болгосугай.
4. Хамгаалж буй чөлөөлсөн бэлчээрт нүүж ирсэн гадны сумдын малчид нүүх шаардлагыг хүлээж авахгүй байгаа тохиолдолд багийн дарга болон ИНХ-ын даргад мэдэгдэхийг бүлгийн ахлагчийн үүрэг болгосугай.

5. Багийн ИНХ-ын дарга болон багийн засаг дарга шийдвэрлэж чадахгүй тохиолдолд сумын засаг даргад мэдэгдэхийг багийн засаг дарга Бямбасүрэнд үүрэг болгосугай.
6. Чөлөөлсөн бэлчээрийн хил дээр орохыг хориглосон самбар босгохыг бүлгийн ахлагчид даалгасугай.
7. Авхайрхан уулын эргэн тойронд нутаглаж байгаа бусад сумын малчин өрхийг нутаг руу нь нүүлгэх эсвэл Тарагт сумын харьяанд бүртгэх эсэхийг тухайн сумдтай зөвлөлдэж шийдвэрлэхийг Тарагт сумын ИТХ-ын дарга болон сумын засаг даргад мэдэгдэх
8. Бусад сумдын мал болон малчин өрхийг чөлөөлсөн бэлчээрт оруулахгүй байх, бэлчээрийг хамгаалахын тулд нүүхийг шаардах, Тарагт сумын бэлчээрт нутаглаж байгаа бусад сумдын малчдад өвөлжөө, хаваржааны бэлчээрийг ашигласны татвар оногдуулах тухай сумын засаг даргад хүсэлт гаргах
9. Сум болон багийн ИНХ-ын тогтоол, сумын засаг даргын зааврыг үл тоомсорлон чөлөөлсөн бэлчээрт орсон малчин өрхөд хуульд үндэслэсэн журмын дагуу мөнгөн торгууль оногдуулан бэлчээрээс нүүлгэхийг сумын ИТХ-ын дарга болон сумын засаг даргад дамжуулах

(b) Сумын ИТХ-ын тогтоол

Сумын ИТХ-аар багийн ИНХ-ын тогтоолыг дэмжиж, төлөвлөгөөний агуулгыг шийдвэрлэсэн.

Өвөрхангай аймгийн Тарагт сумын ИТХ-ын тогтоол

2008 оны 1-р сарын 7

Дугаар 01

Хүрэмт

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний тухай

Сумын ИТХ-аар Туяа багийн бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглах тухай Туяа багийн 2008 оны 1-р сарын 4-ний 1-р тогтоолыг үндэслэж дараах шийдвэрийг гаргав.

1. Туяа багийн ИНХ-ын шийдвэрийг батлах
2. Багийн ИНХ-ын тогтоолыг Туяа багийн малчдын бүлгийн ахлагч хариуцан хэрэгжүүлэх.
3. Багийн малчдын бүлгийн ямарваа нэгэн асуудлыг багийн дарга, багийн ИНХ-ын дарга болон малчид харилцан зөвлөлдэж, асуудлыг шийдвэрлэнэ.
4. Багийн ИНХ-ын тогтоолыг 2008 оны 1-р сарын 4-нөөс эхлэн хэрэгжүүлэх.

.....сумын иргэдийн төлөөлөгчийн хурлын дарга

(с) Сумын болон багийн засаг дарга, бүлгийн ахлагч хоорондын гурвалсан гэрээ

Сумын болон багийн засаг дарга, бүлгийн ахлагч хооронд гурвалсан гэрээ байгуулж, бэлчээр ашиглахтай уялдуулж тус бүрийн үүргийг тодорхойлсон.

Тарагт сумын болон багийн засаг дарга, бүлгийн ахлагч хоорондын гурвалсан гэрээ

Тарагт сумын ИТХ-аар шийдвэрлэсэн 2008 оны бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулж Тарагт сумын засаг дарга, Туяа багийн засаг дарга....., бүлгийн ахлагч.....хооронд 2009 оны 1-р сарын 28-нийг хүртэл дараах гэрээг байгуулав.

1. Зорилго

- a) Иргэдийн оролцоотойгоор боловсруулсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд малчид болон малчдын бүлгийн үйл ажиллагааг тусган, бэлчээрийн ургамалыг хамгаалж, нөхөн сэргээхийг гэрээний гол зорилго болгоно.
- b) Гэрээний зүйлийг өөрчлөх тохиолдолд гурван тал харилцан зөвшилцэж шийдвэрлэнэ.

2. Сумын засаг даргын үүрэг

- a) Сумын ИТХ-аар шийдвэрлэсэн өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөх журамтай холбогдуулж тушаал гаргах
- b) Бүлгийн малчид бэлчээрийг хамгаалж хянах.
- c) Бүлгийн малчинд ашиглаж байгаа бэлчээрийг нь эзэмшүүлэх.
- d) Чөлөөлсөн бэлчээрт гадны сумдын малчид орж ирэх явдлыг журамлах гэрээг зэргэлдээх сумын удирдлагатай хэлэлцэж шийдвэрлэнэ.
- e) Зэргэлдээх сумдын малчдыг журам зөрчсөн тохиолдолд оногдуулах мэнгэн торгуулийн хэмжээг тогтоох

3. Багийн даргын үүрэг

- a) Малчдын хүсэлтийг харгалзан бүлэг байгуулж, бүлгийн бэлчээрийн хил хязгаарыг тогтоох
- b) Малчдын хүсэлтийн дагуу багийн ИНХ-ыг зохион байгуулах
- c) Бүлгийн малчдыг тогтоосон хугацаанд нүүлгэх
- d) Бүлгийн чөлөөлсөн бэлчээртэй холбогдуулан бэлчээр ашиглалтын талаар зэргэлдээх сумдын багийн даргатай асуудлыг хэлэлцэж гэрээ байгуулах
- e) Багийн даргын хувьд асуудлыг шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд сумын удирдлагад дамжуулах
- f) Чөлөөлсөн бэлчээрт гадны сумдаас орж ирсэн малчдыг тогтоосон хугацаанд нүүлгэх арга хэмжээ авах
- g) Шаардлагыг хүлээж аваагүй тохиолдолд сумын удирдлагад мэдэгдэх

4. Бэлчээрийг ашиглагч бүлгийн ахлагч болон гишүүн малчдын үүрэг

- a) Малчдын хүсэлтээр бүлэг байгуулж, хил хязгаарыг тогтоон багийн ИНХ-аар батлана. Бүлгийн ахлагчийг сонгоно.
- b) Бүлгийн малчид 6-р сарын 15-аас 10-р сарын 15 хүртэл бэлчээрийг чөлөөлж ашиглахгүй байхад анхаарах
- c) Чөлөөлсөн бэлчээрт орж ирсэн тохиолдолд нүүлгэх арга хэмжээ авах
- d) Бүлгийн ахлагч малчитдай зөвлөлдөж бэлчээрийг чөлөөлж, хамгаалах
- e) Чөлөөлсөн бэлчээрийг бүлгийн гишүүн малчдаас 1-2 өрх сонгон чөлөөлсөн бэлчээрийг хамгаалуулах
- f) Бүлгийн ашиглаж байгаа бэлчээрт бусад сумдын бүлэг болон баг сумын малчин өрх өвөлжөө, хаваржаагаа барин нутаглахыг бүлгээрээ зөвлөлдөж шийдвэрлэх
- g) Бүлгээрээ шийдвэрлэж чадахгүй тохиолдолд баг, сумын удирдлагад дамжуулах
- h) Чөлөөлсөн бэлчээрийн хил хязгаарыг мэдэгдэхүйц орохыг хориглосон самбар босгох

Тарагт сумын засаг дарга.....

Туяа багийн засаг дарга.....

Бүлгийн ахлагч.....

1.7 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон мониторинг

(1) Мониторинг

Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр дүнтэй хэрэгжих нөхцлийг хангахын тулд тулгарч буй бэрхшээлтэй асуудал болон сайжруулах бодлогыг тодорхойлж, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Иймд мониторинг судалгаа болон төлөвлөгөө хэрэгжилтийн үнэлгээг хийсэн.

Хүснэгт 1.8

Мониторинг судалгаа

Зорилго	Мониторинг судалгааны агуулга	Арга барил	Хэрэгжүүлэгч
Үр дүнг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • Бүлгүүдийн бэлчээрээ чөлөөлж. амрааж ашигласан байдал 	• Ажиглалт	<ul style="list-style-type: none"> • Багийн дарга • Бүлгийн ахлагч
	<ul style="list-style-type: none"> • Өвөлжөө, хаваржааны бэлчээрт зэргэлдээх сумдаас орж ирэх нүүдлийг хянах 	• Ажиглалт	<ul style="list-style-type: none"> • Бүлгийн ахлагч • Бүлгийн гишүүд (Бэлчээр хариуцагч)
	<ul style="list-style-type: none"> • Бүлгүүдийн зуслан, намаржааны бэлчээр ашиглалтын байдлыг хянах 	• Анкет судалгаа	<ul style="list-style-type: none"> • Сум (JIRCAS)
	<ul style="list-style-type: none"> • Зэргэлдээх сумын малчдын бэлчээр ашиглалтын байдал 	<ul style="list-style-type: none"> • Зэргэлдээх сум, багийн удирдлагаас асуух • Малчидтай ярилцах 	<ul style="list-style-type: none"> • Сум (JIRCAS)
Ургамлын мониторинг	<ul style="list-style-type: none"> • Ургамлын судалгаа хийх (Ургамлын төрөл, арви) 	• ХААИС-аас зохион байгуулах	• ХААИС

(2) 2008 онд хэрэгжүүлсэн мониторинг судалгаа

Төлөвлөгөөг боловсруулсны дараа хэрэгжүүлсэн эхний жил болох 2008 оны хэрэгжилтийн байдлыг дор нэгтгэв.

1) Бүлэг тус бүрийн нүүдлийн байдал

Бүх бүлгүүдийн нүүдлийн байдлыг дор дурьдав.

(a) Зуны нүүдэл

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулсны дараах хэрэгжилтийн эхний жил болох 2008 онд малчдын бүлгийн нүүдлийн бодит байдлыг 6-р сарын дунд үеэр судалсан.

Малчид 6-р сараас эхлэн зуны бэлчээрт нүүдэг ба нийт малчдын 63% нь нүүсэн байна. Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс өмнө тухайн сонгосон нутгийн малчдаас авсан судалгаанаас үзэхэд зун нүүдэг малчин 36.7%, намар нүүдэг малчин 45.6%, болон хавар нүүдэг малчин 20% байсан ба үлдсэн хувь нь огт нүүдэггүй байсан үзүүлэлттэй харьцуулбал уг төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээр малчдын бэлчээр сэлгэлттэй холбоотой ухамсар дээшилсэн гэж хэлж болно. Нөгөө талаар төлөвлөгөө ёсоор нүүсэн үзүүлэлт 18.5% -д хүрсэн байна. Төлөвлөгөөний дагуу нүүж чадаагүй шалтгааныгасууж судлахад а) Төлөвлөгөөт бэлчээрт малчдын төвлөрөл хэт их байсан б) Төлөвлөсөн бэлчээрийн өвсний гарц муу байсан с) Төлөвлөсөн бэлчээрийн усан хангамж муу

- d) Төлөвлөсөн бэлчээрээс илүү тохиромжтой бэлчээрт нүүсэн
 f) өвөлжөөний бэлчээрийг хамгаалахаар сонгогдсон зэрэг шалтгааны улмаас төлөвлөгөөний дагуух бэлчээрт нүүлгүй урьдын адил өвс сайтай бэлчээр хөөн, хувь хүн бүр өөрийн нүүх бэлчээрээ шийддэгээс бэлчээрийн төвлөрөл бий болж дац хэтрдэг байна. Иймд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр бүтээлтэй хэрэгжүүлэхийн тулд өвсний гарц болон малын бэлчээрт дүйцэх тоо толгойн тэнцвэртэй байдлыг хадгалж, малчдын бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглахын үр ашгийн тухай ойлголтыг дээшлүүлэх шаардлагатай байна. Мөн уг үр дүн болон судалгааны явцаас дүгнэхэд малчид бэлчээрийг төлөвлөгөөтэйгээр ашигласнаар ургамлын нөхөн сэргэлт сайжирна гэдгийг бүрэн ойлгож, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөхцөл, орчин бурдвэл биелэх боломжтой зүйл гэдэг нь харагдаж байна. Түүнчлэн төлөвлөгөөг боловсруулахтай холбогдуулж, бүлгийн дотроос мал цөтэй малчин өрхийг өвөлжөө, хаваржааны чөлөөлсөн бэлчээрийг зун, намрын турш нүүлгүй хамгаалуулахаар сонгоно. Энэхүү нүүхгүй өрхийг эс тооцвол нүүсэн өрх нь 68.4%, үүнээс 20.1% нь төлөвлөгөөт бэлчээрт нүүсэн байна.
- (b) Намаржaa руу нүүж эхлэх үеийн байдал
 Малчид 8-р сараас намрын бэлчээр рүү нүүж эхлэх ба бүх малчин өрхийн нүүдлийн байдлыг хүснэгт 1-8-д үзүүлэв. Ялангуяа 3 бүлгийн бэлчээрийн нүүдэл харьцангуй хэрэгжсэн байна.

Хүснэгт 1.9

Намрын бэлчээрт нүүсэн байдал

Бүлгийн нэр	Үнэлгээ	Тайлбар
Хилэнгийн хадат	C	З өрх нүүгээгүй (Төлөвлөгөөний дагуу нүүхийн ач холбогдолыг сайтар ойлгоогүй 4 өрх бусад сумдаас орж ирсэн. З өрхөөс бусад өрх 80км нүүсэн.
Серт	A	Сайн нүүсэн
Туяа	C	Багийн дарга сайн ажиллаж чадсан боловч бэлчээрээс эрт бүцаж ирсэн
Олон худаг	B	Асуудал бараг байхгүй.
Даравгай	D	Зэргэлдээх Төгрөг сумын малчид нутагладаг.
Жирмийн олон худаг	C	Өөр багийн малчид байдаг. Сургалтанд хамрагдаагүй.
Жирэм	A	Төлөвлөгөөний дагуу нүүсэн боловч урд талын зэргэлдээх сумаас малчид нүүж орж ирсэн нь гол асуудал байсан.
Шовхийн хоолой	A	Ерөнхийдөө төлөвлөгөөний дагуу нүүсэн. Гэвч ахлагч нь нүүгээгүй. Ирэх жил нүүнэ гэсэн.
Үндай	D	Газарзүйн хувьд зуны бэлчээрт бусад сумдаас орж ирэх нүүдэл ихтэй газар. Төлөвлөгөөний дагуу бараг нүүгээгүй.
Хадан ус	D	Бусад сумдаас нүүдэл ихтэй. Төлөвлөгөөний дагуу бараг нүүгээгүй

A:80%-иас зээш нүүсэн, B:60-80% нь нүүсэн, C:40-60%нь нүүсэн, D:40%-иас доош

Түүнчлэн намаржаа руу нүүх үе 8-р сард өвөлжөө, хаваржааны бэлчээрт эргэж ирэх малчид байгаа нь ажиглагдсан. Үүний шалтгаан нь а) намрын бэлчээрийн өвс тааруу байсан б) өвөлжөө, хаваржааны бэлчээрт бусад сумдын малчид нүүж ирнэ гэсэн санаа зовнилоос намрын бэлчээрт нүүлгүй өвөлжөө, хаваржааны бэлчээр рүү эрт нүүж ирэх шалтгаан болдог байна. Гэвч ийм жишээ олон биш, ихэнх нь төлөвлөгөөний дагуу нүүсэн (хүснэгт 1-10).

Хүснэгт 1.10


Тарагт сумын Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний дагуу нүүсэн байдал

(Зуслангаас нүүсний дараа 8-дугаар сарын байдлаар)

№	Бүлгийн нэр	Өрхийн тоо	Зусландац нүүсэн	Нүүгээ--гүй	Чөлөөлсөн бэлчээрийг хамгаалж улдсэн өрх (Зүүн гар талд орсон)	Тодорхой бус	Зусландац нүүсэн(%)	Нүүсэн байдал
1	Хилэнгийн хадат	26	14	12	5	0	54	<ul style="list-style-type: none"> 7-р сарын сүүлийн арав хоногт өвөлжөөнд нүүж ирсэн (5өрх) Төлөвлөгөөт бэлчээр рүү нүүхийг эсэргүүцсэн (4өрх)
2	Сөрт	25	22	3	2	0	88	
3	Туяа	42	19	23	0		45	<ul style="list-style-type: none"> 8-р сарын эхний арав хоногт өвөлжөөний бэлчээрт буцаж ирсэн (5 өрх)
4	Олон худаг	17	12	4	2	1	71	
5	Даравгай	27	4	22	0	1	15	
6	Жирмийн олон худаг	18	10	8	2		56	
7	Жирэм	14	13	1	1	0	93	<ul style="list-style-type: none"> Эртлэн нүүсэн тул төлөвлөгөөт бэлчээрийг ашиглаж чадсан
8	Шовхийн хоолой	32	21	11	2		66	
9	Үндай	22	6	15	1	1	27	<ul style="list-style-type: none"> 8-р сарын эхний арав хоногт өвөлжөөний бэлчээрт буцаж ирсэн (2 өрх)
10	Хадан ус	16	3	12	0	1	19	
Нийт өрх		239	124	111	15	4	51.9	

Жич: Сөрт булгийн нүүдлийн дунгийн жишээг зураг 1.8-д үзүүлэв.

Энэхүү баг нь зун болон намар төлөвлөгөөний дагуу нүүсэн өрхийн тоо олон байсан.



Малчдын бүлгийн нүүдлийн бодит дүн (Сөрт бүлэг)

	Төлөвлөгөө	Бодит дүн
Зуны (6-р сарын дунд үе)		
Намрын (8-р сарын эхний арав хоног)		

Зураг 1.8 Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (Бэлчээр ашиглагчдын Сөрт бүлгийн нүүдлийн бодит байдлын жишээ)

2) Өвөлжөө, хаваржааны бэлчээр рүү орж ирэх бусад сумдын малчдын нүүдэл

Зун, намрын бэлчээрт нүүсний дараа өвөлжөө, хаваржааны бэлчээрт орж ирэх бусад сумдын малчдын нүүдлийн байдлыг хүснэгт 1-11-т үзүүлэв. Нутаг бүрт урьдын адил гадны сумын малчдын нүүдэл орж ирсэн. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хамгаалж, арга хэмжээ авах шаардлагатай байна.

Хүснэгт 1.11

Өвөлжөө, хаваржааны бэлчээрт орж ирэх бусад сумдын малчин өрхийн тоо

№	Бүлгийн нэр	Өвөлжөө-Хаваржааны бэлчээрт нүүж ирсэн өрх	Хаанаас нүүж ирсэн
1	Хилэнгийн хадат	2	Баянгол
2	Сөрт	13	Олон газраас, өөр аймгаас 3
3	Туяа	2	Баянгол 1, Алтантал 1
4	Олон худаг	0	
5	Даравгай	20	Олон газраас, өөр аймгаас 1
6	Жирмийн олон худаг	0	
7	Жирэм	0	
8	Шовхийн хоолой	3	Алтантал
9	Үндай	0	
10	Хадан ус	0	
Нийт		40	

3) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг хянах

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг хянахтай холбогдуулж малчдын дунд доорхи графикт үзүүлсэнд дагуу судалгаа явуулсан. Тус судалгааны үр дүнгээс харахад 52% нь төлөвлөсөн бэлчээрт нүүгээгүй байна. Шалтгааныг тодруулахад төлөвлөгөөт бэлчээрийг өөр малчид ашиглаж, малчид хэт төвлөрсөн байснаас нүүгээгүй. Энэ нь төлөвлөгөө хэрэгжих явцад ч өвс сайтай бэлчээрт малчид хэт төвлөрдөг гэдгийг харуулж байна. Мөн гол шалтгааны нэг нь бусад баг болон сумаас ирэх нүүдэлд санаа зовсноос төлөвлөгөө дагуу нүүж чадаагүй байна. Энэ нь төлөвлөгөө хэрэгжилтийн явцад өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хангалттай сайн хамгаалагүй гэж дүгнэж болох ба төлөвлөгөөнд өвөлжөө хаваржааны бэлчээрийг сайтар хамгаалах бодлогыг тусгах шаардлагатай байна.


Мөн өвөлжөө, хаваржааны бэлчээрээс нүүгээгүй шалтгааны нэг нь мал цөтэй учраас нүүх шаардлагагүй, хүн хуч дутмаг байгаа зэрэг нь хамгийн том шалтгаан болж байна. Үүний талаар бүлгээрээ эсвэл багаараа нэгдсэн төлөвлөгөө хэрэгжүүлэхдээ нүүж чадахгүй байгаа өрхийн нүүхгүй байж болох шалтгааныг тусгайлан зааж өгөх шаардлагатай нь ажиглагдсан.

Түүнчлэн бэлчээрийг хяналт, төлөвлөгөөтэй ашиглах нь үр ашигтай юм гэдгийг малчдын 89% нь ойлгосон. Энэ нь бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглахын ач холбогдолыг малчид хангалттай ухамсарлаж байна гэдгийг харуулж байна.

Мөн цаашид хамтран ажиллахад шаардлагатай зүйлийн нэг нь бүлгээрээ хэлэлцэж шийдвэрлэх, бүгдийн шийдсэн шийдвэрийг нийтээрээ хэрэгжүүлэх, зохион байгуулалттайгаар бэлчээрийг ашиглах шаардлагатай гэдгийг малчид ухамсарласан.


Эдгээр судалгааны үр дүнд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн ач холбогдол, төлөвлөгөө боловсруулах дараалал, аргыг малчид сайтар ойлгож, тухайн сумын захиргааны гүйцэтгэх үүрэг болон аймгийн заавар, удирдлагыг тодорхойлсноор тус төлөвлөгөөний биелэлт, үр бүтээлтэй хэрэгжилтийг хангана гэдэг нь тодорхой.

1. Зуслан, намаржааны бэлчээр рүү нүүсэн үү?
(Нийт 44 малчин өрхөөс)




Зураг 1.9

2. Нүүсэн боловч төлөвлөгөөнд заасан бэлчээр рүү нүүгээгүй шалтгаан




Зураг 1.10

3. Өвөлжөө, хаваржааны бэлчээрээс нүүгээгүй шалтгаан




Зураг 1.11




Зураг 1.12

5. Бэлчээрийг төлөвлөгөөтэй ашигласнаар бэлчээрийн ургамал сайжирсан уу?
(өвөлжөө • хаваржaa) (44хүнээс)



Зураг 1.13

6. Бэлчээрийг төлөвлөгөөтэй ашигласнаар сайжирсан гэж
0 бодож байгaa зүйл 10 15 20



Зураг 1.14

7. Бэлчээрийн төлөвлөгөөтэй ашиглалт, хяналтыг цаашд ч үргэлжлүүлэх нь ашигтай ву?
(44 малчнаас)
2%




Зураг 1.15

Үйл ажиллагаанд хамгийн үр дүн үзүүлсэн хүчин зүйл



Зураг 1.16

Цаашид үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд сайжруулах шаардлагатай зүйлс



Зураг 1.17

Тарагт сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлын малчдаас авсан судалгааны үр дүн

4) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох хүмүүсийн үүрэг

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд малчид болон захиргааны албан хаагчид тус бүрийн гүйцэтгэх үргийг тодорхойлж, түүний дагуу ажиллаж төлөвлөгөөний үр бүтээлтэй хэрэгжих нөхцлийг хангах шаардлагатай. Ялангуяа малчид бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглахын ач холбогдолыг сайтар ойлгож, захиргаанаас түүнийг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг хангаж өгснөөр урт хугацаанд тогтвортой хэрэгжих төлөвлөгөө болж чадна.

Холбогдох хүмүүсийн гүйцэтгэх үүргийг гурван талт гэрээ байгуулан тодорхойлсон.

(а) Холбогдох хүмүүсийн ажлын үр дүн

Боловсруулсан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэжүүлэхэд холбогдох хүмүүсийн гүйцэтгэсэн үүрэг, цаашид сайжруулах шаардлагатай зүйлийн талаарх судалгааны үр дүнг дор үзүүлэв.

a) Малчин

(Үйл ажиллагааны ерөнхий тойм)

- I. Бэлчээрийг төлөвлөгөөний дагуу ашиглахын ач холбогдолыг ихэнх малчин ухамсарлаж, хэрэгжүүлэхэд оролцсон.
- II. Мөн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой бэрхшээлтэй асуудал болон, сайжруулах арга хэмжээг бүлэг бүрт санал асуулга, хэлэлцээр зохион байгуулж, дараа жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгахаар болсон.
- III. Бүлэг тус бүрийн өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зуны турш ашиглахгүй, чөлөөлсөн бэлчээрт орохыг хориглосон самбар босгох

(Сайжруулах зүйл)

- I. Төлөвлөгөөний биелэлтийг дээшлүүлж, төлөвлөсөн бэлчээрт нүүх. Түүний хэрэгжилтийг үнэлж, үр дүнг хянах
- II. Бүх малчид төлөвлөгөө хэрэгжүүлэхэд нийтээрээ идэвхтэй оролцох

b) Баг

(Үйл ажиллагааны агуулга)

- I. Багийн хурлаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг шийдвэрлэж, хэрэгжүүлэх болон хэрэгжүүлэх агуулгыг тодорхой шийдвэрлэсэн.
- II. Бүх бүлгүүдийн өвөлжөө, хаваржааг хамгаалах өрхийг сонгож, тус бэлчээрт орж ирсэн малчдад чөлөөлсөн бэлчээрийг зуны туршид ашиглахгүй байхыг мэдэгдсэн.
- III. Багийн дарга сард 2 удаа бүлгүүдийн бэлчээр ашиглалтын байдлыг шалгаж, зааварчилгаа өгсөн.

(Сайжруулах зүйл)

- I. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хэрэгжүүлэхийн ач холбогдолыг малчдад ухуулан тайлбарлаж, зөв удирдаж зааварчлах
- II. Бэлчээр ашиглалтын журмыг бусад багийн малчдад мэдэгдэх
- III. Бусад газраас орж ирэх нүүдлийг шийдвэрлэж, сум хоорондын асуудлыг сайжруулах арга хэмжээ авах

c) Сум

(Үйл ажиллагааны агуулга)

I. Сумын засаг дарга нь сумын ИТХ-ын тогтоол, сум хоорондын хэлэлцээр, сум болон баг, бүлгийн ахлагч хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй хамtran ажилласан.

II. Сумын газрын албаны даамал, сум хоорондын хэлэлцээрт идэвхтэй оролцож, гэрээ байгуулахад хамtran ажилласан.

(Сайжруулах зүйл)

I. Бусад сумдын малчдад мэдээлэл хийснээр (урьд нь чөлөөлсөн өвөлжөө, хаваржааны бэлчээрт өөр багийн малчид нүүж орсон удаатай) сум хоорондын хэлэлцээрийн биелэлт сайжирна.

II. Өвөлжөө, хаваржааны бэлчээрт орж ирсэн малчдад мөнгөн торгууль оноох журам хэрэгжээгүй, үүнийг чангатгах шаардлагатай.

III. Эдгээрийг ч мөн зэргэлдээх сумдын малчдад мэдэгдэх

d) Аймаг

(Үйл ажиллагааны агуулга)

I. Зэргэлдээх сумдтай бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцэж тохирох асуудлыг хэрэгжүүлсэн.

(Сайжруулах зүйл)

I. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн сум хоорондын хэлэлцээрт бүх сумдыг оролцуулах

II. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ургамлын нөхөн сэргэлт сайжирсэн зэрэг үндсэн мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж малчдад мэдэгдэн, үр дүнг нийтэд мэдээлэх

5) Малчдын дунд сургалт зохион байгуулж, шийдвэрлэх зүйл

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлсний дараа бүх бэлчээр ашиглагчдын бүлэгт сургалт зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгамдсан бэрхшээлтэй асуудал болон сайжруулах арга хэмжээг тодруулж хэлэлцсэн. Хүснэгт 1-12-т үзүүлсний дагуу нэгтгэсэн ба дараа жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусган сайжруулахаар болсон.

Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөн дэх тулгамдсан асуудал болон сайжруулах зүйл

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал	Сайжруулах бодлого
(1) Хур тунадас болон хавар өвсний гарцаас шалтгаалан төлөвлөсөн зуслан, намаржааны бэлчээрт нүүх боломжгүй болсон. • Малчид урьдын адил өвс сайтай бэлчээрт төвлөрсөн. • Нүүхээр төлөвлөсөн бэлчээр малчдын төвлөрөл ихтэй байсан	Тухайн жилийн ургамлын гарцыг хавар нь шалгаж, зуны бэлчээрийг эхицуулна. Малын тоо толгойн харьцааг зохицуулах
(2) Нүүсний дараа өвөлжөө, хаваржааны бэлчээрт гадны сумын малчид орж ирсэн • Өвөлжөө-Хаваржааны бэлчээрийг сайтар хамгаалж чадаагүй. • Нүүсэн ч ургамлын нөхөн сэргэлт сайжрахгүй	Бусад сумд мэдэгдэж, сум хоорондын гэрээг чангатгах хүсэлтийг сумд гаргах
(3) Шалтгаангүйгээр нүүгээгүй	Шалтгаангүйгээр нүүгээгүй малчинд мөнгөн торгууль оногдуулах • Малчид зохион байгуулалттай хамтран ажиллах

6) Тулгамдсан асуудал болон түүнийг сайжруулах бодлогыг тодорхойлохоор санал асуулга зохион байгуулах

Өнөөг хүртэл хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд тулгуурлаж, бэрхшээлтэй асуудал болон цаашид түүнийг шийдвэрлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор бэлчээр ашиглагчдын бүлэг, баг, сум болон аймгийн мэргэжилтнүүд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг сайжруулах санал асуулгыг хэрэгжүүлсэн. Тус санал асуулгаас бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр бүтээлтэй хэрэгжүүлэх зорилгоор бэрхшээлтэй асуудлыг тодруулж, түүнийг сайжруулах арга хэмжээг шүүн хэлэлцсэн.

Тулгамдаж буй асуудлыг (1) Худаг усны хангамж, (2) Бүлгийн үйл ажиллагааны хэрэгжилт (3) Бэлчээрийг хянаж хамгаалах арга (4) Мал зүй (мал аж ахуйг сайжруулах) гэсэн 4 зүйлд ангилиж, аймаг, сум, баг болон малчид тус бүрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж хүснэгт 1-13-т үзүүлэв.

Худгын хувьд отрын бэлчээрт гүний худаг шаардлагатай ба аймгийн худаг гаргах төлөвлөгөөнд хүсэлт гаргах шаардлагатай. Гар худгыг малчид өөрснөө гаргаж чадна. Бүлгийн үйл ажиллагаагаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбогдуулж малчдын бүлгийн ойлголт, мэдээлэлийг нэгтгэх, нүүдлийн зардалд дэмжлэгүүлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг дээшлүүлэх шаардлагатай. Бэлчээрийн хяналтыг сум хоорондын хэлэлцээр болон багийн ИНХ-аар шийдвэрлэсэн. Мал зүй нь малын эрүүл ахуйд чиглэсэн асуудлыг хангах шаардлагатай ба аймагт хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ. Эдгээр нь бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр бүтээлтэй хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болно.

Хүснэгт 1.13

Тарагт сумын Туяа Багийн Бэлчээр ашиглалтын төлөөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгамдсан бэрхшээлтэй асуудал болон түнд авах арга хэмжээ

Ангилал	Худаг	Бүлгийн үйл ажиллагаа	Бэлчээрийг хамгаалах	Мал зүй
Аймаг	Бэрхшээлтэй асуудал	Гучин худаг шаардлагатай, Гучин худаг гаргуулах тухай хүснэгт тавих шаардлагатай	1. Бусад сүмдүн малчид Тарагт сумын бэлчээрийг доройтуулж байна. 2. Аймгаас бэлчээр ашиглажтай холбоотой хуульд үндэслэн журам гаргах	1. Малын Уулдэр угсааг сайжруулах шаардлагатай. 2. Мал угаах газар шаардлагатай 3. Чанар сайгай малын эм тарни шаардлагатай.
	Арга хэмжээ	Хүсэлт гаргасны дараа аймгийн ХХДАХэлтэс худаг шинээр барих газрыг сонгоно.	1. Аймтийн ЗДТГ-ын дарга шийдвэр гаргана.	Сумас СХДАХэлтэст хүснэгт тавина.
Сүм	Бэрхшээлтэй асуудал	Чанартай ёвс сайтай бэлчээр отор нүүдэл хийхэд гучин худаг гаргах шаардлагатай.	1. Хол нүүхэд зардал их орох учраас эдийн застийн хувьд дэмжлэг үзүүлэх 2. Малчин өрх бүртэй гэрээ хийх шаардлагатай 3. Зуслан, намаржааны бэлчээрийг зохицуулах шаардлагатай	1. Сум болон баг хамтран шийдсэн гэрээний датуу нүүгээтгүй. 2. Заргэлдээх сум болон аймаг хоорондын гарээг билеуулдэгүй 3. Торгох журмыг чангатгах 4. Бүх малчдад мэдээлээгүй
	Арга хэмжээ	Малчин Багийн ИТХ Сүм ХХДАХэлтэс гэсэн шатлалаар хүэслт гаргах	1.Шаардлагатай зардлын тухай сумаас аймант хүснэгт гаргах 2. Сумын тал гэрээ боловсруулж өрх бүртэй байгуулах	1. Аймтийн ЗДТГ-ийн дарга тушаал гаргах 2. Сум хооронд гэрээ байгуулах 3. Сумын дарга тушаал гаргах 4. Тушаалыг бичгээр үйлдэж байх ИТХ-олон нийтэд мэдээдэх

Баг	Бэрхшээлтэй асуудал	<p>1. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг малчид хувь хүн тус бурт даатгаснаар ур дун муу 2. Бэлчээрийг хамгаалах хүн шаардлагатай</p>	<p>1. Цэцэнгийн хөв хар адугийн бэлчээрт гадны малчид орж ирэхээс сэргийлэх 2. Зуслан намаржаанд нүүсний дараа гадны сумын малчин ороохос сэргийлэх 3. 1000-аас дээш толгой мал эзэмшисанээр бэлчээрийн доройтыг бий болгоно 4. Намаржaa руу нүүхтэй холбогдуулж сум болон JIRCAS-ийн заавар шаардлагатай</p>	
	Арга хэмжээ	<p>1. Бэлчээр ашиглажчдын булаг бүд санаа нэгтэй батчээрийг чөлөөлнэ. Багийн ИТХ-аар нийтэд мэдээлнэ. 2. Бэлчээрийг хамгаалах ерхийн сонгоно.</p>	<p>1. Отрин бэлчээрийг багийн ИНХ-аар шийдвэрлэнэ. 2. Отрин бэлчээр гаргана</p>	<p>1. Нуух хүн хүч хүрэлцээ муутай 2. Сум болон багийн засаг дарын зохицтой зааварчилгаа шаардлагатай.</p>
Малчин	Бэрхшээлтэй асуудал	Гар худаг гарахад дэмжлэг шаардлагатай	<p>1. Бусад малчад бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг сайтар ойлтуулаатай</p>	<p>1. Нуух хүн хүч хүрэлцээ муутай 2. Сум болон багийн засаг дарын зохицтой зааварчилгаа шаардлагатай.</p>

7) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр дүн болон нэгдсэн дүгнэлт, цаашид сайжруулах бодлого

Тарагт сумын Туяа багт бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн анхны жилийн үр дүнг тодорхойлоход:

(a) Төлөвлөгөөний хувьд

- Малчид бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглахын ач холбогдолыг сайтар ойлгосон.
- Зуны (6-р сар) нүүдлийг ихэнх малчид хэрэгжүүлсэн.
- Гагцхүү төлөвлөгөөнд тусгасан зуслан намаржааны бэлчээрийн нүүдэл нь урьдын адил өвс сайтай газарт төвлөрснөөр бэлчээр ашиглалт харилцан адилгүй байсан.

(b) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд малчдын идэвхийг дээшлүүлэх

- Хэсэг малчид нүүлгүй, өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хэт их ашигласан. Энэ нь малчдын бүлгээрээ бэлчээрийг төлөвлөгөөний дагуу ашиглах хэрэгжилтэнд сөрөг нөлөө үзүүлсэн.
- Бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглаж, ургамлын нөхөн сэргэлт сайжрана гэдгийг сайтар ойлгосноор үр бүтээлтэй хэрэгжих нөхцлийг бүрдүүлнэ.

(c) Малчдад мэдэгдэх

- Сум хооронд гэрээ байгуулж, өвөлжөө хаваржааны бэлчээр хамгаалалтыг хэрэгжүүлсэн.
- Мөн өвөлжөө, хаваржааны бэлчээрийг хамгаалах өрхийг сонгож гадны сумдаас орж ирэх нүүдлийг зогсоож өвөлжөө хаваржааны бэлчээрийг хамгаалах ухамсарыг нийтэд түгээсэн.
- Гэвч урьдын адил гадны сумдын малчид өвөлжөө хаваржaa руу орж ирсэн ба энэ нь бусад сумдын малчдад үйл ажиллагааны тухай хангалттай мэдэгдэл хийгээгүйтэй холбоотой.
- Иймд өвөлжөө, хаваржааны бэлчээр хамгаалалт хангалттай хэрэгжээгүй.

Эдгээрийг үндэслэн цаашид бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр бүтээлтэй хэрэгжилтийг сайжруулахын тулд доорхи арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

(a) Зуслан намаржааны бэлчээрийн өвсний гарцыг тодорхойлж, малын тоо толгойд тохирсон бэлчээрт нүүхээр төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Иймд малчид өөрснөө өвсний гарцыг тодорхойлох боломжтой стандарт, аргачлалыг боловсруулна.

(b) Төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой сум хоорондын гэрээ, хэлэлцээрийн үр дүнг дээшлүүлэхэд бусад сумдын малчдад чөлөөлсөн бэлчээрийн тухай мэдээлэх шаардлагатай.

(c) Бүлэгтус бүрийн малчдын төлөвлөгөөтэйгээр бэлчээр ашиглахын ач холбогдолын тухай ойлголтыг дээшлүүлэх

(d) Хэрэгжилтийн дараа бэлчээрийн ургамлын үнэлгээг малчид өөрснөө хийж, үр дүнг дараа жилийн төлөвлөгөөнд тусгах

(3) 2009 оны мониторинг судалгааны үр дүн

1) Энэ жилийн төлөвлөгөөг сайжруулах

(a) Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөн дэх дутагдалтай тал болон сайжруулах зүйл Тарагт сумын Туяа багт 2007 онд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсний хоёрдох жил нь юм. Туяа багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг сайжруулахаар өвөлжөө, хаваржааны бэлчээрийн өвсийг хамгаалах зорилгоор зун, намар нүүх үзүүлэлтийг өнгөрсөн жилийнхээс өсгөхийг зорьж ажилласан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ноднин жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон энэ жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар багийн малчид хоорондоо зөвлөлдөж, доорхи зүйлүүдийг нэгтгэн гаргалаа.

- a) Ноднин жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө зохих ёсоор хэрэгжсэн газарт энэ жил өвсний гарц сайн байсан.
- b) Бэлчээр ашиглалтыг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэхэд сум, багийн захиргаа болон малчид хоорондын гэрээ байгуулж, гэрээний зүйлийг зөрчсөн тохиолдолд оногдуулах торгуулийг чангатгах шаардлагатай.
- c) Бүлгийн ахлагчийн удирдах чадвар зарим үед хангалтгүй байсан учир малчид тус бүртэй гэрээ хийх хэрэгтэй.
- d) Зуны хугацаанд өвөлжөөний бэлчээрийг ашиглаж огт нүүхгүй байгаа өрх нь өвөлжөөний нэг хэсгийг бүрмөсөн өнжөөж мал оруулахгүй байх.

(b) Бүлгийн ахлагчдын хурлын шийдвэр

Сумаас бүлгийн ахлагчдын хурлыг зохион байгуулж, өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр ашиг, болон нүүх төлөвлөгөөг хэлэлцсэний үр дүнд доорхи саналыг гаргасан. Урьд жилийн туршлагыг үндэслэн энэ жил ч гэсэн бүлэг тутмын нутаглах бэлчээрийг тогтоож, бэлчээр дэх нүүдлийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

Ноднин төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад тулгамдсан доорхи асуудлыг энэ жил сайжруулах.

- a) Зуслан болон намаржааны бэлчээрт нүүсэн үед өвөлжөө, хаваржааны бэлчээр рүү бусад сумын малчдын нүүдэл орж ирэн чөлөөлсөн бэлчээрийн ургамалыг доройтуулж байсан. Иймд өвөлжөө, хаваржааны чөлөөлсөн бэлчээрт орж ирэх малчдад авах арга хэмжээг тодорхой шийдэж, бэлчээр чөлөөлэлтийг үр дүнг сайжруулах шаардлагатай байна. Үүний тулд сумын захиргааны зүгээс доорхи агуулга бүхий сумын засаг даргын мэдэгдэл гаргаж бусад сумдаас орж ирсэн малчдад өгнө.

Тарагт сумын засаг даргын мэдэгдэлийн агуулга:

- Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний дагуу чөлөөлсөн өвөлжөөны бэлчээрийг зун.хавар ашиглахгүй байх
- Нүүж ирсэн тохиолдолд 50.000хүртлэх төгрөгөөр торгоно.
- Энэ эь сум хоорондын гэрээнд тусгагдсан учраас заавал биелүүлэх шаардлагатай.

b) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд малчдын гүйцэтгэх үүргийг тодорхойлж, нийт малчид нэгэн санаагаар хамтран ажиллах шаардлагатай. Үүний тулд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гурвалсан гэрээ (сум, багийн засаг дарга болон бэлчээр ашиглагчдын бүлгийн ахлагч тус бүрийн үүргийг тодорхой заасан гэрээ) –нд бүх малчдын үүргийг дор дурьдсаны дагуу оруулав. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулж, энэхүү үүргийг заавал биелүүлнэ.

Нийт малчдын гүйцэтгэх үүрэг:

- 6-р сарын 15-10-р сарын 15 хүртэл өвөлжөө, хаваржааны бэлчээрээс нүүнэ.
- Өвөлжөөний чөлөөлсөн бэлчээрт орж ирсэн малчдад тус бэлчээрийг чөлөөлж, нүүхийг шаардана.
- Бүлгийн дотроос 2 хүртлэх малчин өрхийг сонгож чөлөөлсөн бэлчээрийг хамгаалуулна.
- Өвөлжөө, хаваржааны чөлөөлсөн бэлчээрт гадны сумдын малчид орж ирсэн тохиолдолд бүлгээрээ зөвлөлдөж арга хэмжээ авна. Шийдвэрлэж чадахгүй тохиолдолд багийн болон сумын засаг даргад мэдэгдэнэ.

Бүлгийн хурлын дараа түүнээс гарсан шийдвэрийг үндэслэн сумын зүгээс үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

2) 2009 оны хэрэгжилтийн байдалд хийсэн мониторинг

(a) Мониторингийн арга

2009 оны бэлчээр ашиглалтын байдалд хийсэн мониторинг судалгааг доорхи агуулгын дагуу хэрэгжүүлсэн.

- Асуулт хариултын анкет бөглүүлэх аргаар судалгааг явуулсан ба Туяа багийн бүх малчид оролцсон.
- Зуслан руу нүүсний дараа 7-р сард судалгааг хэрэгжүүлсэн
- Судалгаанд нийт 235 өрх хамрагдсан ба үүнээс бүрэн хариулсан өрх 140 байна.

Судалгааны агуулгыг доор дурьдахад

Хүснэгт 1.14

Үндсэн мэдээлэл	1) Өрхийн тэргүүлэгчийн нэр 2) Бүлгийн нэр 3) Нутгийн байрлал(GPS)
Малын тоо толгой	Малын төрөл тутмын тоо толгой
Зуслан-Намаржааны бэлчээр ашиглалтын байдал	1) Зуслан ашиглах хугацаа (Нүүж очсон өдөр-нүүсэн өдөр) 2) Намаржааны бэлчээр ашиглах хугацаа (Нүүж очсон өдөр-нүүсэн өдөр) 3) Тухайн газрын нэр болон худгийн нэр 4) Зуны бэлчээрийг төлөвлөгөөний дагуу ашигласан уу? 5) Төлөвлөгөөний дагуу ашиглаж чадаагүй шалтгаан
Өвөлжөө-Хаваржааны бэлчээр ашиглалтын байдал	1) Тухайн газрын нэр болон худгийн нэр 2) Өвөлжөөны бэлчээрийн ургамал сайжирсан уу? 3) Сайжирсан шалтгаан 4) Сайжраагүй шалтгаан
Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний талаар	1) Бусад сум, багийн малчид чөлөөлсөн бэлчээрт орсон эсэх 2) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн 3) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай зүйлс 4) Одоогийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөн дэх сайжруулах шаардлагатай зүйл 5) Малчдын оролцоо, урам зоригийг дээшлүүлэх арга
Захиргааны удирдлагын зааварчилгаа	Аймаг, сум, баг, малчдын бүлгийн зааварчилгаа


(b) Мониторинг судалгааны үр дүн

a) Малын тоо толгой

Хүснэгт 1-15-д судалгаанд хамрагдсан 140 өрхийн нийт малын тоо толгойг үзүүлэв. Малын төрөл тус бүрийн тоо толгойг авч үзвэл хонь 24,777, ямаа 17,8705, үхэр 869, адuu 2,067, тэмээ 10толгой нийт 45,428 толгой байсан. Эдгээрээс 140 өрх нь бүгд хонь малладаг ба ямаа 137 өрх, үхэр малладаг 79 өрх, адuu малладаг 113 өрх, тэмээ малладаг 4 өрх байлаа. Нэг өрхөд оногдох маллах малын дундаж үзүүлэлт нь хонь 177толгой, ямаа 129толгой, үхэр 11толгой, адuu 18толгой, тэмээ 3 толгой ноогдож байна. Хонин толгойд шилжүүлсэн тооцоогоор нийт малын тоо толгой 60,445.


Судалгаанд хамрагдсан малчин өрхийн малын тоо толгой

	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	Нийт
Нийт тоо толгой	24,777	17,705	869	2,067	10	45,428
Тухайн малыг маллаж буй малчин өрхийн тоо	140	137	79	113	4	140
1 өрхөд ноогдох малын дундаж үзүүлэлт	177	129	11	18	3	324
Нийт тоо толгой (Хонин толгойд шилжүүлснээр)	24,777	15,935	5,214	14,469	50	60,445
*Хонин толгойд шилжүүлснээр: хонь-1.0, ямаа-0.9, үхэр-6.0, адуу 7.0, тэмээ-5.0						



Судалгаанд хамрагдсан өрхийн нэг өрхөд ноогдох малын тоо толгой (хонин толгойд шилжүүлснээр) –г графикт үзүүлэв. Нэг өрхөд 201-300 толгой мал ноогдох байгаа үзүүлэлт олон байгаа ба 101-400 толгой малтай өрх нийт малчин өрхийн тал хувийг эзэлж байна. Түүнчлэн 1000 толгой малаас илүү малтай малчин өрх 9 байна.

Нэг өрхөд ноогдох малын тоо толгойн үзүүлэлт харьцангуй цөөхөн байгаа нь 24 толгой малтай, хамгийн олон малтай байсан нь 1,637 толгой малтай байна.

**b) Бэлчээрийг ашиглах хугацаа**

Зун, намрын бэлчээрийг ашиглах хоногоор ялгаатай өрхийн тоог графикт үзүүлэв. Зун болон намрын бэлчээрийг 61-90 хоног ашигладаг өрх хамгийн олон байна. Зуны бэлчээрийг хамгийн богино ашигладаг өрх гэхэд л 34 хоног, хамгийн олон хоног ашигладаг малчин өрх 185 хоног ашигладаг байна.


Намрын бэлчээрийг хамгийн богино 17 хоног, хамгийн урт хугацаагаар 239 хоног ашигладаг байна. График 1-19-д бэлчээр ашиглах хугацаа (сар) болон малчин өрхийн тоо тус бүрийн харьцааг үзүүлэв.

Тарагт сумын бэлчээр ашиглах журамд 6-р сарын 15~10-р сарын 15 хүртэл зун, намрын бэлчээрийг ашиглана гэж заасан.


Зуны бэлчээр ашиглаж байгаа өрхийн тоо 6~8-р сард хамгийн олон байсан ба 21 өрх, 6~10-р сард 16 өрх, 5~7-р сар хүртэл 15 өрх байсан байна. Малчдаас хамгийн эрт зуны бэлчээрт нүүж ирсэн нь 3-р сарын 1 ба хамгийн орой нүүсэн нь 11-р сарын 20 байсан. 2009 оны зуны бэлчээр ашиглах хугацаа дунджаар 6-р сарын 2 байсан. Намрын бэлчээрийг хамгийн олон малчин өрх ашигласан ўе нь 8~10-р сарын хооронд 19өрх байсан бөгөөд 7~11-р сард 13 өрх, 8~11-р сарын хооронд 10 өрх байна. Хамгийн эрт намрын бэлчээр рүү нүүсэн нь 7-р сарын 6 бөгөөд хамгийн орой намаржаанаас нүүсэн нь дараа жилийнх нь 5-р сарын 27 байсан байна.

Хүснэгт 1.16

Зуслан, намаржааны бэлчээр ашиглах хугацаа болон малчин өрхийн тоо



c) Зуны бэлчээр ашиглалтын байдал



Зуны бэлчээрт нүүсэн малчин өрхийн харьцааг графикт үзүүлэв.

Зуны бэлчээрт төлөвлөгөөний дагуу нүүсэн малчин өрх нийт 62%-тай байна Төлөвлөгөөний дагуу нүүгээгүй малчин өрх 38%, түүний гол шалтгаан нь “Бэлчээрийн өвсний гарц муу байсан” гэсэн хариулт хамгийн олон байсан ба бусад шалтгааныг тоочвол “Бусад сумдын малчид нүүж ирэх вий гэж санаа зовсон”, “Нүүдлийн зардал шаардлагатай”, “Төлөвлөсөн бэлчээр малчдын төвлөрөл ихтэй байсан” зэрэг байна.


2008 оны судалгаагаар “Төлөвлөсөн бэлчээрт малчдын төвлөрөл ихтэй байсан”, “Бусад сумдын малчид нүүж ирэх вий гэж санаа зовсон” зэрэг шалтгаанаар бэлчээрийн төлөвлөгөөний дагуу нүүгээгүй гэж хариулсан малчид олон байсан бөгөөд 2009 оны судалгаанаас ажиглахад малчид хоорондын асуудлаас илүү бэлчээр дэх өвсний гарцын асуудал гол шалтгаан болсон гэж дүгнэхээр байна.




Зураг 1.21

d) Өвөл, хаврын бэлчээрийн байдал

Өвөлжөө, хаваржааны бэлчээрийн байдал сайжирсан эсэх асуултын үр дүнг графикаар үзүүлэв. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийн өвс “сайжирсан” гэж нийт малчдын 56% нь хариулсан ба 44% нь сайжраагүй гэж хариулсан байна. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийн өвс “сайжирсан” шалтгаан нь “төлөвлөгөөний дагуу нүүсэн”, “бусад сумын малчдын нүүдэл орж ирээгүй” зэрэг байлаа.




Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хэрэгжсэнээр өвөлжөө, хаваржааны бэлчээрийн өвс сайжирсан гэж үзэж байгаа малчид олон байгаа нь ажиглагдсан. Нөгөө талаар сайжраагүй шалтгаан нь “бороо багатай байсан”-аас гэсэн хариулт олон байгаа нь цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулж бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь чухал гэдгийг илтгэж байна.



Зураг 1.23



Зураг 1.24




е) Бусад баг, сүмдаас орж ирэх нүүдэл

Бусад баг, сүмдаас орж ирэх нүүдлийн бодит байдлыг графикт үзүүлэв. Бусад баг, сүмдаас орж ирэх нүүдэл байгаагүй гэж нийт малчдын 81% нь хариулсан.


Бусад баг, сүмдүүн малчдын нүүдэл орж ирсэн гэж хариулсан малчдын 69% нь түүний эсрэг ямар нэгэн арга хэмжээ аваагүй гэж хариулсан. Гэхдээ малчдын 22% нь “учрыг тайлбарласан” хэмээн хариулж, “сум болон

аймгийн захиргаанд мэдэгдсэн” нь 9%. Үүнээс харахад малчид хамтран асуудлыг шийдвэрлэхийг хичээж байгаа нь ажиглагдаж байна. Бусад баг, сумдын нүүдэл орж ирээгүй гэж хариулсан малчдаас бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хэрэгжсэнээр гадны сумдын малчдын нүүдлээс сэргийлж чадсан эсэхийг асуухад дийлэнх 67% нь “мэдэхгүй” гэж, 23% нь “үр дүнгээ өгсөн” хэмээн хариулсан бол 10% нь “үр дүнгээ өгөөгүй” гэж хариулжээ.


Төлөвлөгөөний дагуу нүүж чадаагүй шалтгааныг тодруулахад “Бусад сумдын малчид нүүж ирэх вий гэж санаа зовсон”-оос гэж хариулсан үзүүлэлт 2008, 2009 онд ч мөн адил их байгаа бөгөөд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр бүтээлтэй хэрэгжилтийг хангахын тулд, төлөвлөгөөг хэрэгжүүлж буй сум, багийн төдийгүй эргэн тойрны малчид, захиргааны удирдлагуудтай харилцан холбоотой ажиллах нь чухал гэдгийг харуулж байна.



Зураг 1.26



Зураг 1.27



f) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүн

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг дараах графикт үзүүлэв. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн талаар малчдын 79% нь “бага зэрэг үр дүн гарсан”, 21% нь “үр дүн гаралгүй” хэмээн хариулжээ. Бага зэрэг


үр дүн гарсан тухай шалтгааныг тодруулахад “чөлөөлсөн бэлчээрт орохыг хориглосон самбар босгосон”, “оролцооны бүхий л хэлбэрээр хамтран ажилласан” гэсэн хариулт харьцангуй олон байв. Энэ нь оролцооны бүхий л хэлбэрээр хамтран ажилласанаар холбогдох хүмүүс бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн ач холбогдолыг сайтар ойлгож, орохыг хориглосон самбар босгосноор төлөвлөгөөг хэрэгжүүлэгчээс гадна бусад малчдад ч үйл ажиллагааг таниулсан төдийгүй ялангуяа “сумын хурлаар шийдвэрлэх” болон “бүлгээрээ зөвлөлдөж шийдэх” зэргээр малчид хоорондын мэдээлэлийг нэгтгэх нь чухал гэдгийг илэрхийлж байна.



Зураг 1 29


g) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр бүтээлтэй хэрэгжүүлэх нөхцөл Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр бүтээлтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай зүйлсийг доорхи графикт үзүүлэв. Ялангуяа “бүлгээрээ хэлэлцэх”, “бүлгийн ахлагчийн удирдах чадвар”, “сум хоорондын хэлэлцээр” хэмээн хариулсан үзүүлэлт олон байна. Энэ нь бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох хүмүүс хоорондоо хэлэлцэн шийдвэрлэж, төлөвлөгөөг тасралтгүй хэрэгжүүлэх нь чухал гэдгийг малчид ойлгож байгааг илэрхийлж байгаа бөгөөд малчид өөрсдөө төлөвлөгөөг төвортой хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэлээ.

Гэвч “сумын захиргааны зааварчилгаа” чухал байгаа тухай хариулт ч байгаа нь малчид өөрсдөө шийдвэрлэж чадахгүй байгаа асуудал олон байна гэдгийг ч харуулж байна. Нөгөө талаар “хууль, эрхзүйн тогтолцоо” болон “донор байгууллагын дэмжлэг” зэрэг шаардлагатай байгаа тухай хариулт ч цөөнгүй байгаа нь гадны дэмжлэг авах талаар ч бодолцож үзэх шаардлагатай гэдгийг харуулж байна.



Зураг 1.30


h) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний сайжруулах зүйл
Одоогийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд сайжруулах шаардлагатай байгаа зүйлийг графикт үзүүлэв. Сайжруулах зүйлээс хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа “багийн даргын эрх мэдлийн хүрээг нэмэгдүүлэх” ба “нүүх бэлчээрийг дахин хэлэлцэх”, “торгууль ноогдуулах журмыг чангатгах”, “нүүх хугацааны өөрчлөлт” зэргээс харахад төлөвлөгөөний агуулгаас илүү хэрэгжилттэй холбоотой асуудлыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна..



Зураг 1.31

i) Малчдын урам зоригийг нэмэх арга

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд малчдын оролцоо хамгийн чухал ба малчдын урам зоригийг нэмж, урамшуулах аргын тухай саналыг графикт үзүүлэв. “Сургалт зохион байгуулах” тухай санал хамгийн олон байгаа нь “урамшуулах”, “үр дүнг илтгэх” зэргээс илүүтэйгээр сургалтаар дамжуулж шинэ мэдлэг, мэдээлэлийг олгох нь малчдад хамгийн чухал байна гэдгийг харуулж байна.




Зураг 1.32

j) Засаг захиргаа, удирдлагын зааварчилгаа

Засаг захиргаа, удирдлагын зааварчилгааны талаарх үнэлгээний судалгааг дараах графикт үзүүлэв.

Засаг захиргаа, удирдлагын зааварчилгааны талаар “хангалттай” гэсэн хариултыг хамгийн их авсан нь “баг” бөгөөд дараа нь “бүлгийн ахлагч”, “сум” байлаа. “Аймаг”-ийн удирдлагын талаар 64% нь “хэлж мэдэхгүй байна”, 29% нь “хангалтгүй”, 7% нь “хангалттай” гэж хариулсан.

Баг болон бүлгийн ахлагчийн үнэлгээ өндөр байгаа нь малчидтай хамгийн ойрхон ажилладаг учраас тэр болов уу. Аймгийн удирдлагын үнэлгээний үзүүлэлт бага байсан нь аймгийн захиргааны дэмжлэг, үйл ажиллагаа шаардлагатай байгааг харуулж байна. Мөн “хэлж мэдэхгүй байна” гэсэн хариултын хувьд аймгийн зааварчилгаа малчдын амьдралд томоохон нөлөө үзүүлдэггүй гэдгийг илэрхийлж байна.



Зураг 1.33

3) 2009 оны хэрэгжилтийн байдалд хийсэн мониторингийг дүгнэхэд

Тарагт сумын Туяа баг нь 2-дох жилдээ бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа ба төлөвлөгөөний дагуу нүүсэн малчид төлөвлөгөө хэрэгжүүлэхийн өмнө 31%-тай байснаас 74% болж өссөн. Нүүдлийн үзүүлэлт өссөн учир нь нүүгээгүй шалтгааны нэг “өвс муутай байсан” гэдгээс бодож үзэхэд бэлчээрийг төлөлөгөөний дагуу нүүж ашигласнаар бэлчээрийн ургамал сайжрах юм байна гэдгийг малчид сайтар ойлгосон, мөн оролцооны бүхий л хэлбэрээр хамтран ажиллаж үйл ажиллагааг нийтэд мэдэгдсэнээр “бусад сумдын малчдын нүүдэл орж ирнэ” гэдэгт санаа зовох асуудал багассанаас үүдэлтэй гэж үзэж байна. Төлөвлөгөө хэрэгжилтийн үр дүнгээс “орохыг хориглосон самбар босгосон” тухай онцолж байгаа нь тухайн бэлчээр чөлөөлсөн зэрэг үйл ажиллагааг бусдад мэдэгдэх нь чухал ач холбогдолтой гэдгийг илэрхийлж байна. Сум хоорондын хэлэлцээр ч чухал боловч юуны түрүүнд бүлэг дотроо хэлэлцэн, малчид хоорондын мэдээлэлийг нэгтгэх нь хамгийн чухал гэж дүгнэж байна.

2. Баруун Баян-Улаан сумын 2 дугаар баг

2.1 Санал асуулга явуулах аргаар тухайн орон нутгийн нөхцөл, нөөц боломжийг судлан түүнд тулгуурласан үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

Орон нутгийн өнөөгийн нөхцөл байдлыг (байгаль, нийгэм, хүн ам, материал, санхүүгийн гэсэн таван нөөц) судалсан нь орон нутаг дахь нөөц боломжийн талаарх ойлголтыг өгсөн.

Нөөц боломж, түүнийг ашиглах болон хэрэгжүүлэх арга хэмжээг хүснэгт 2-1-т тоймлон үзүүллээ.

Хүснэгт 2.1

Баруун Баян-Улаан сумын нөөц боломж, түүнийг ашиглах болон хэрэгжүүлэх арга хэмжээ

Гарчиг	Баруун Баян-Улаан сум	
	Нөхцөл, нөөц боломж	Арга хэмжээ
Байгалийн нөөц		
Бүтэн жилд орох хур тунадасны хэмжээ	<ul style="list-style-type: none">Дунджаар 57 мм(11 жилийн хэлбэлзэл 25 мм-119 мм)	Усжуулалтын технологийг нэвтрүүлэх
Температур	<ul style="list-style-type: none">Хавар эрт агаарын температур эрс өсдөг (шороо их шуурдгаас)Үүршилтын хэмжээ их	Усжуулалтын технологийг нэвтрүүлэх

Ургамал	<ul style="list-style-type: none"> Ургамлын доройтол мэдэгдэхүйц илт Ой модыг түлшинд хэрэглэх нь улам ихэссэн 	<ul style="list-style-type: none"> Бэлчээрийн менежментийг сайжруулах Шахмал тэжээл үйлдвэрлэх Өвлийн тэжээлийн нөөц бүрдүүлэх Зуны бэлчээрийг сум хоорондоо хэлэлцэн сэлгээтэй ашиглах Мод тарих
Хөрс	<ul style="list-style-type: none"> Салхины улмаас газрын өнгөн хөрс хуулагддаг Хөрс шим тэжээл багатай (ургамлын ялзмаг багатай) Нарийн ширхэгтэй (Элс хийсэх нь амархан) 	<ul style="list-style-type: none"> Мод тарьж элснээс сэргийлэх арга хэмжээ авах Тухайн нутгийн модлог ургамлаас суулгац бэлдэх
Үсны нөөц	<ul style="list-style-type: none"> Задгай ус нэлээд ширгэсэн Усжуулалтын систем элсэнд бөглөрсөн Үерийн усанд дайрагдсан 	<ul style="list-style-type: none"> Гүний усыг ашиглах Усжуулалтын технологийг нэвтрүүлэх Ус хуримтлалын технологийг нэвтрүүлэх
Нийгмийн нөөц		
Малчдын зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Нэгдэл тарснаас хойш эвлэл, хоршооны зохион байгуулалт байхгүй 	<ul style="list-style-type: none"> Бүлгээр нэгдэх
Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх төв	<ul style="list-style-type: none"> Байхгүй 	<ul style="list-style-type: none"> Гаднаас лекц семинар, зохион байгуулж судалгаа хийх
Хүний нөөц		
Тариалалт эрхлэх технологи	<ul style="list-style-type: none"> Малчдын ихэнх нь туршлагагүй 	<ul style="list-style-type: none"> Дадлагажуулах
Хөдөлмөрлөх хүч	<ul style="list-style-type: none"> Нүүдэллэх газар нь хол, ажиллах хүчинийг нэг газарт төвлөрүүлэхэд бэрхшээлтэй 	<ul style="list-style-type: none"> Бүлэг болон нэгдэж хөдөлмөрийн хуваарьтай ажиллах
Материалын нөөц		
Сүргийн бүтэц, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> Ямааны эзлэх хувь өндөр Том мал цөөн (хонь 28%, ямаа 66%, үхэр, адuu, тэмээнийт 6%) 	<ul style="list-style-type: none"> Сүргийн бүтцийг сайжруулах Дахин боловсруулах аргаар түлшний нөөц бэлтгэх
Газар тариалангийн нөөц	<ul style="list-style-type: none"> Суулгац, үр, тариалангийн жижиг багаж хэрэгсэл дутмаг 	<ul style="list-style-type: none"> Бүлэгтээ бий болгох
Бүтээгдэхүүний борлуулалт	<ul style="list-style-type: none"> Борлуулалтын талаархи мэдээлэл дутмаг Зам тээврийн харилцаа муу Зах зээлээс хол 	<ul style="list-style-type: none"> Мэдээллийн систем бий болгох Бүлгээрээ хамтарч борлуулах
Санхүүгийн нөөц		
Санхүү	<ul style="list-style-type: none"> Банк, санхүүгийн байгуулалтагатай харьцахад хэцүү Өндөр хүүтэй, барьцаа шаардлагатай 	<ul style="list-style-type: none"> Жижиг зээл Малаар фонд байгуулах

2.2 Бэлчэр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж шийдвэрлэх асуудал

“Шар шороон шуурганы эх үүсвэрийг судлах” судалгааны объект болох Баруун Баян–Улаан сумын бэлчээр ашиглалтын байдлыг доор танилцуулав.

Баруун Баян–Улаан сум нь аймгийн төвөөс өмнө зүтг 175 км-т байрладаг учраас Тарагт суманд ажиглагдаад байгаа гадны малчдын нүүдэл байхгүй боловч өөр сумын сэргүүн нутаг рүү нүүдэллэж, өвөл нь сумандаа буцаж ирэх байдлаар бэлчээрийг ашиглаж байна.

Баруун Баян –Улаан сумын бэлчээр ашиглалттай холбоотой асуудлыг Хүснэгт 2-2-т үзүүлэв.

Хүснэгт 2.2


Баруун Баян –Улаан сумын бэлчээр ашиглалттай холбоотой асуудал

Сумын нэр	Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал	Бэлчээр ашиглалт
Баруун Баян –Улаан сум	Баруун Баян –Улаан сум зүн нь өөр сумын бэлчээрийг ашиглаж, өвөл нь өөрийн сумын бэлчээрийг ашигладаг.	Бусад сумдын бэлчээрийн даацыг хэтрүүлснээр, ургамлын доройтол бий болгох гол шалтгаан болж байна.
	Бусад сумдаас орж ирэх малчдын нүүдэл байхгүй.	Зүн, намрын бэлчээрийг нүүдэлд сум болон аймгийн оролцоотой сум хоорондын зохицуулалт шаардлагатай.

2.3 Орон нутгийг сонгох

Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулахад бэлчээр ашиглалттай холбоотой асуудлуудыг хүснэгт 2-2-т үзүүлсэний дагуу шийдвэрлэх аргыг тогтоож, улмаар монгол улсын бэлчээр ашиглалтанд нөлөөлөхүйц бэлчээр ашиглалтын загвар төлөвлөгөөг багийн түвшинд бий болгохыг зорьж энэ орон нутгийг сонгосон.

Хоёрдугаар баг нь бэлчээр ашиглалтын асуудал илэрхий ихтэй юм.



Баруун Баян-Улаан сумын
2-р багийн байршил

Зураг 2.1

2.4 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах чиглэл

Бодит байдлыг сайтар ойлгож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийг зорилго болгосон бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахын тулд доорхи чиглэлийг баримтлах шаардлагатай юм.

- 1) Баруун Баян-Улаан сумын 2 дугаар багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний агуулга

Орон нутгийн хэмжээнд бэлчээр талхлалтыг зогсоож, ургамлын нөхөн сэргэлтийг сайжруулахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулна. Мөн Баруун Баян-Улаан сум болон тус сумын нутагт нүүдэллэн ирэх малчдын сум хоорондын бэлчээр ашиглалтын зохицуулалтыг шийдвэрлэнэ.

- 2) Малчид бүлэг байгуулан ажиллах

Сум хоорондын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд малчин өрх тус бүрээр биш харин өвөлжөө, хаваржааны байршлыг үндэслэн бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулж тэд өөрсдөө бэлчээрийнхээ асуудлыг зохицуулж мөн хянаж ажиллах нь чухал байна.

2.5 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэгч бүрэлдэхүүн

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбоотой үйл ажиллагаа нь Өвөрхангай аймгийн Баруун Баян-Улаан сумын 2 дугаар багийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, сонгогдсон нутгийн бэлчээр ашиглагчдын бүлэг, малчид хамтран ажилласан. Мөн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд малчдад зориулсан сургалт, бэлчээр ашиглалтын байдалд зүн шинжилгээ хийх, ургамалжилтын судалгаа болон түүнд дүн шинжилгээ хийх зэрэг мэргэжлийн салбарын хувьд ХААИСургууль судалгааг хэрэгжүүлсэн болно.

2.6 Баруун Баян-Улаан сумын 2 дугаар багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх үйл явц

- (1) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх явц болон үйл ажиллагааны товч агуулга

Баруун Баян-Улаан сумын 2 дугаар багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хүснэгт 2-3-т үзүүлсний дагуу хэрэгжүүлсэн.

Баруун Баян-Улаан сумын 2 дугаар багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулсан дараалал

Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны агуулга
1. Аймаг, сумын холбогдох албан хаагчидтай хамтран бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хийгдэх орон нутгийг сонгох (Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хийгдэх объект болох орон нутгийг сонгоно)
2. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд аймаг, сумын захирагааны албан хаагчдыг сургалтанд хамруулж, тэдний чадавхийг дээшлүүлэх
3. Аймаг, сумын захирагааны албан хаагчдад бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах арга барилд дадлагажуулах (Хоёрдугаар багийн малчин өрхүүдийг бүлэг болгон зохион байгуулах)
4. Хоёрдугаар багийн малчдын бүлгүүдийг бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах арга барилд дадлагажуулах
5. Багийн хэмжээний бэлчээр ашиглалтын байдал болон бэлчээрийн ургамалжлыг тодорхой бэлчээрүүд дээр судлах
6. Багийн хэмжээний бэлчээр ашиглалтын байдал болон ургамалжлын судалгааны үр дүнг нэгтгэж, дүгнэлт хийх
7. Багийн хэмжээний бэлчээр ашиглалтын байдлын схем зургийг боловсруулах
8. Багийн малчдын бүлгийн ахлагч нар Хужирт сумын тэргүүний малчдын бүлгийн үйл ажиллагаанаас туршлага судлах (Аймаг, сумдын захирагааны албан хаагчдын оролцоотойгоор)
9. Хоёрдугаар багийн малчдын бүлгүүдэд бэлчээр ашиглалтын зураг ашиглаж бэлчээр ашиглалтын тухай сургалт, санал асуулга зохион байгуулах (Аймаг, сумын захирагааны албан хаагчдын оролцоотойгоор)
10. Багийн малчитай хамтран бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх
11. Аймаг, сумын захирагааны албан хаагчид, малчдын бүлгүүд бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэлэлцэн зөвшилцөх мөн засаг захирагааны удирдлагын зүгээс холбогдох шаардлагатай албан бичиг, мэдэгдэх хуудас зэргийг бэлтгэн боловсруулах
12. Хоёрдугаар багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний зураг боловсруулах
13. Хоёрдугаар багийн иргэдийн нийтийн хурал, Баруун Баян-Улаан сумын иргэдийн төлөвлөгчдийн хурлаар бэлчээрийн ашиглалтын төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулах
14. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй холбогдсон асуудлуудаар зэргэлдээх сумдтай гэрээ, хэлэлцээр хийх

(2) Бэлчээр ашиглагчдын бүлэг байгуулах

Хоёрдугаар багийн нийт малчин өрхийг бүлэг болгон зохион байгуулж, энэхүү бүлгүүдэд тулгуурлан бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

Хоёрдугаар багийн нийт малчин өрхүүдийг өвөлжөөний байршил дээр тулгуурлан нийт 4 бүлэгт хуваасан. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулах асуудалтай холбогдуулан бүлэг тус

бүрт сургалт, санал асуулга зохион байгуулсан.

- (3) Төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай суурь мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийх

Судалгаа хийх

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн бэлчээр ашиглаж байгаа малчин өрхүүдийн бэлчээр ашиглалт болон бэлчээрийн ургамалжлын байдал зэрэгт доорхи агуулгаар урьдчилан судалгаа хийсэн.

[Судалгааны агуулга]

- 1) Бэлчээрийн ангилал
- 2) Бэлчээрийн хэлбэр, шинж
- 3) Сум, багийн хил зааг
- 4) Зуны хугацаанд ургамлын хамгийн их арвтай үе
- 5) Бэлчээрийн ургамлын төрөл, бүтэц
- 6) Өрх айлын тоо болон өрх тус бүрийн малын төрөл, тоо толгой
- 7) Бэлчээрийн ачаалалыг улирал бүрээр тогтоох
- 8) Улирал бүрээр бэлчээрийн ургамлын тэжээллэг байдлыг тогтоох (Бэлчээрлэх боломжтой малын тоог тогтоох)
- 9) Бэлчээрийн усан хангамж, худаг усны байдал (байрлал, шинж байдал)
- 10) Улирал бүрийн бүлгээрээ ашиглах бэлчээр
- 11) Улирал бүрийн ашиглах бэлчээрийн хил заагийг тогтоох
- 12) Улирал бүрийн бэлчээрийг ашиглах хугацаа (бэлчээр ашиглалтын зурганд оруулах)

- (4) Хоёрдугаар багын бэлчээр ашиглалтын байдал болон ургамлын дорийтол

- 1) Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал


Судалгааны явцад 2 дугаар багийн малчидтай хамтран бэлчээрийн хилийг улирлаар нь тогтоосон. Мөн худаг устай холбоотой мэдээллийг ч цуглуулсан.

Судалгааны үр дүнд тус багийн нийт бэлчээрийн талбай 975.55км² бөгөөд тус талбайг хавар, зун, намар, өвөл, жил тойронгийн, нөөц бэлчээр гэсэн 6 төрөлд хуваарилан ашигладгийг тодруулав.

Тус бүрийн хуваарилалт нь хавар 71.3%, зун, намар 3.7%, өвөл 23.6%, жил тойрон 1%, нөөц бэлчээрт 0.4% байна. Энэ ашиглах зарчмыг зураг 2-3-т үзүүлэв.

Мөн дээр нь нэмж, зун хөрш зэргэлдээх Хайрхандулаан сумын нуур болон шаврын эргэн тойрон дох баялаг ургамалтай газар луу бэлчээрлэхээс өөр аргагүй гэдэг нь илэрхий байна.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН УЛААН СУМЫН
2-Р БАГИЙН УЛИРЛЫН БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ЗУРАГ**



Зураг 2.3 Ашиглах зарчмын зураг

2) Бэлчээрийн даацыг тодорхойлох

Бэлчээрийн даацыг хэмжих судалгааг 8 дугаар сард явуулсан (Бэлчээр бүрт 5 удаа давтана). Үр дүнг Хүснэгт 2-4-т үзүүлэв. Бэлчээрийн гарцын мэдээлэлд үндэслэн намрын бэлчээрийг бэлчээр ашиглалтын хугацааг 150 хоног, өвөлжөөний бэлчээр ашиглалтын хугацааг 85 хоног, хаваржааг дунжаар 25 хоног гэж тооцсон. Мөн тус багийн 2007 оны тооллогоор нийт малын too 27000 толгой байсан бөгөөд үүнийг хонин толгойд шилжүүлбэл 40585 болох ба үүнтэй уялдуулж бэлчээрийн даацыг тооцоолсон. Үүнээс үзвэл жилийн турш ашиглагдаж байгаа бэлчээрт ургамлын хүчтэй доройтол явагдаж байгаа

бөгөөд ялангуяа зун, намрын бэлчээр үнэхээр хүрэлцэхгүй, багийн дотоод хэрэгцээг ч хангаж чадахгүй нь илэрхий байна. Жич: бүтэн жилийн туршид ашиглаж байгаа бэлчээрээ зун, намрын улиралд бүрэн чөлөөлөхөөр хэлэлцэн тохирсон.

Хоёрдугаар багийн малчид бэлчээрийг төлөвлөгөөтэйгээр ашиглахын хамтаар зун, намрын бэлчээрийг бэлчээрийг хамгаалах явдал шаардлагатай байна. Мөн усны хангамжийг сайжруулах нь чухал гэдэг нь тодорхой харагдаж байна.

Хүснэгт 2.4

2-р багийн бэлчээрийн даацыгн судалгаа

Бэлчээрийн ангилал	Талбай	Нэгж	Гарц	Ашиглах хоног	Бэлчээрлэх мал	Тогтоосон хэмжээ	Даац
	(га)	(кг/га)	(кг)	(өдөр)	(толгой)	(толгой)	(дахин)
Зуслан, намаржаа	3,593	23	82,637	150	110	16,679	151
Жилийн турш ашиглах бэлчээр	962	16	15,396	5	616	556	1
Өвөлжөө	23,027	27	621,734	85	1,463	9,451	6
Хаваржаа	69,565	62	4,313,036	125	6,901	13,899	2
Нөөц бэлчээр	408	0	0	0	0	0	
Нийт	97,555		5,032,803	365	9,090	40,585	

2.7 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах

(1) Бэлчээр ашиглах төлөвлөгөөний чиглэл

Тус багийн бэлчээрийн төлөвлөгөөг боловсруулахдаа бэлчээрт нүүжочихоосөмнөтухайн бэлчээрийн ургамлын байдлыг шалгаж, бэлчээрийн хуваарийг харгалзан, доорхи зүйлүүдийг 2009 онд хэрэгжүүлэх бэлчээрийн төлөвлөгөөнд тусгасан.

Ялангуяа зун өвс ургамал муутай бэлчээрийг хамгаалахын тулд хөрш зэргэлдээх Хайрхандулаан сумын бэлчээрийг ашиглах аргыг санал болгосноор засаг захиргааны зүгээс зохион байгуулалттайгаар хамтран ажиллах болсон. (3-р зүйл)

- (а) Зун болон намар ашиглах төвийн бэлчээр, Хярын бумбат, Хүйтэн зэрэг газрын бэлчээрийг 2009 онд өнжүүлнэ.
- (б) Бүтэн жилийн турш ашиглагддаг Андай орчмын бэлчээрийг 2008 оны намраас бүтэн жил өнжүүлнэ.
- (с) Тус багийн зун ашиглагдаж байгаа Хайрхандулаан сумын Хөхбүрдийн эргэн тойрны бэлчээрийг ээлжээр ашиглахын тулд Хайрхандулаан сумын захиргаа, тус сумын Гүн нарийн 5 дугаар багийн малчидтай зөвлөлдөх шаардлагатай.

- (d) 2009 оны зуны эхний хагаст буюу өөрөөр хэлбэл 6 дугаар сарын 15 хүртэл нуурын өмнө хэсгийн бэлчээрийг, зуны хоёрдугаар хагаст буюу өөрөөр хэлбэл 6 дугаар сарын 15-наас нуурын хойд талын бэлчээрийг, мөн 2010 оны зуны эхний хагаст нуурын хойд талын бэлчээрийг, зуны хоёрдугаар хагаст нуурын өмнөх хэсгийн бэлчээрийг тус тус ашиглах саналыг сумдууд хэлэлцэж шийдвэрлэнэ.
- (e) Усны хангамж муу, хараахан ашиглагдаагүй байгаа нутгийн бэлчээрт усжуулалтын систем нэвтрүүлэн баг дотроо болон багууд дундаа ашиглах боломжтой отрын бэлчээрийг бэлдэнэ.
- (f) Усны хангамж муу, хараахан ашиглагдаагүй байгаа Янзан, Нүхт хотгор, Талын хүрэн зэрэг газрыг Баруун Баян-Улаан, Гучин ус, Богд зэрэг сумдын отрын бэлчээр болгохоор Өвөрхангай аймгийн газар зохион байгуулалтын алба болон хүнс хөдөө аж ахуйн газартай зөвшилцсэн.
- (g) Доройтсон дэрс (үндсэн ургамал) бүхий бэлчээрийг хамгаалах бөгөөд Цэхлэг орчимд эргэн тойрны багуудтай хамtran эзэмших худаг ухна. Мөн зэргэлдээх сумдуудтай хамtran Нүхт, Янзан, Талын хүрэнд усны хангамжийг сайжруулах арга хэмжээ авна.
- (2) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хянах
- 2-р багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний дагуу хүрэлцээ муутай зуны (6-р сарын эхнээс 8-р сарын дунд үе хүртэл) өвсийг хамгаалахын тулд тус багийн хөрш сумын (Хайрхандулаан болон Нарийнтээл сумын хэсэг нутаг) бэлчээрийг ашиглахаар тусгасан ба тэрхүү хугацаанд 6-р сарын дунд үеийн эхэн болон түүнээс хойших хугацаанд зуны бэлчээрийг хуваарьтай ашиглаж, ургамалыг хамгаалж бэлчээрийг ашиглах төлөвлөгөөг гаргасан. Өөрөөр хэлбэл 2-р баг угаасаа тэрхүү зуны бэлчээрийг ашигладаг ба төлөвлөгөөний дагуу хувиартай ашиглах нь хамгийн чухал байсан бөгөөд энэхүү төлөвлөгөөг боловсруулахаас өмнө дээрх хөрш сумдуудтай зөвшилцэж байсан удаагүй нь бодит байдал юм. Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд эдгээр 3 сүм хамtran тус сум хоорондын бэлчээр ашиглалтын тухай хэлэлцсэн.
- Хурлыг бүх сумдын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөтэй уялдуулж, зохицуулах зорилгоор аймгийн хүнс хөдөө аж ахуйн хэлтсээс зохион байгуулсан.
- Тус хуралд аймгийн хүнс хөдөө аж ахуйн хэлтсийн дарга, газрын албаны мэргэжилтэн, тус 3 сумын сумын болон багийн засаг дарга, малчдын төлөөлөл оролцож, 2-р багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний агуулга болон түүний хэрэгжилтийг хангахын тулд сум хоорондын гэрээ байгуулах тухай хэлэлцсэн. Хэлэлцээрийн үр дүнд хуралд оролцогсод тус төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхээр доорхи зүйлүүдийг шийдвэрлэсэн.

- (a) Зуны бэлчээрт харьялгадаг Хайрхандулаан сумын 5-р багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж, Хайрхандулаан сумын газар ашиглалтын төлөвлөгөөтэй энэхүү бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг уялдуулах
- (b) Хайрхандулаан болон Баруун Баян-Улаансумд нь сум хоорондын гэрээ байгуулах

Үүний тулд 6-р сарын 25-нд Хайрхандулаан сумын 5-р багийн ИНХ-г зохион байгуулсан ба Баруун Баян-Улаан сумын засаг дарга, 2-р багийн дарга болон иргэдийн төлөөлөл оролцож, сум хоорондын хэлэлцээрт доорхи зүйлийг хэлэлцэж тохирсон болно.

- (a) Баруун Баян-Улаан сумын 2-р багийн үргэлж ашиглаж байгаа Хайрхандулаан сумын зуны бэлчээрийг 2 сум цаашид мөн хамтран ашиглана.
- (b) Хайрхандулаан сумын нутагт байгаа Баруун Баян-Улаан сумын малчдын өвөлжөөг цаашид ч гэсэн ашиглуулах. Гагцхүү газар ашиглалтын татварыг Хайрхандулаан сумд төлдөг байх.
- (c) Үүний оронд хэрвээ Хайрхандулаан сумд намаржаа, өвөлжилт хүндэрсэн үед Баруун Баян-Улаан сумын нутагт бэлчээр сонгон ашиглуулах.

Жич, өнөөг хүртэл сумдын (ялангуяа Баруун Баян-Улаан, Хайрхандулаан сумдын хооронд) хооронд бэлчээр ашиглалтын тухай хэлэлцээр хийж байсан удаагүй, улмаар бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглаж байгаагүй боловч энэ удаагийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хэрэгжих шатанд 2 сумын хооронд хэлэлцээр хийсэн нь тухайн сумдын хувьд маш өндөр ач холбогдолтой зүйл болсон. Эдгээрийг үндэслэн 2-р багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг тодорхой болгов. (Зураг 2-4)

Баруун Баян-Улаан сумын 2-р багийн 2009 оны бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгагдсан гол асуудал

- a) Баруун Баян-Улаан сумын 2-р багийн малчдын жил бүр ашиглаж байгаа Хайрхандулаан сумын зуны бэлчээрийн хувьд уулын хойд тал болон урд талын малчидтай хамтран хавар бсарын 15 хүртэл нуурын өмнөд хэсгийг, 6-р сарын 15-наас 8-р сарын 15 хүртэл нуурын хойд хэсгийг ашиглах
- b) Гагцхүү нуурын зүүн талд нутаглаж байгаа Хайрхандулаан сумын малчдын өвөлжөөний бэлчээрийг 7-р сарын 20-оос хойш ашиглахгүй байх
- c) Нуурын зүүн талд хавраас хойш тасралтгүй нутаглаж байгаа нүүдэлгүй өрхүүдийг нүүлгэх
- d) Нуурийн эргэн тойронд Зкм-ээс дотогш мал бэлчээрлүүлэхгүй байх. Гагцхүү мал усалж болно.

<p>Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал</p>	
<p>Төлөвлөгөө</p>	

Зураг 2.4 Баруун Баян-Улаан сумын 2-р багийн 2009 оны бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал болон төлөвлөгөө

2.8 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг шийдвэрлэх

(1) Сум хоорондын гэрээ байгуулах

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг Баруун Баян-Улаан болон Хайрхандулаан сумдын хоёр тал зөвшөөрч, хэрэгжүүлэхийн тулд төлөвлөгөөний агуулгыг харилцан тохиролцож гэрээ байгуулснаар бэлчээр ашиглалтын төлөвлөгөө бодит үйл ажиллагаа болох нөхцлийг хангасан.

Сум хоорондын гэрээний агуулга

- Баруун Баян-Улаан сумын малчид Хайрхандулаан сумын өвөлжөөний бэлчээрийг 7-р сарын 20-оос хойш ашиглахгүй байх
- Хайрхандулаан сумын нутагт суурьшсан (өвөлжөө) огт нүүдэггүй Баруун Баян-Улаан сумын малчин өрхүүдийг нүүлгэж бэлчээр сэлгүүлэх
- Баруун Баян-Улаан сумын малчид Хайрхандулаан сумын бэлчээрийг ашиглах тохиолдолд худгийг лайдаж, цэвэрлэх

2.9 Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон мониторинг

(1) Мониторинг

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр дүнтэй хэрэгжих нөхцлийг хангахын тулд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжих нөхцөл болон хэрэгжилтийн байдлын талаар хийх мониторинг судалгаанд тусгах зүйлүүдийг хүснэгт 2-5-д үзүүлэв.

Хүснэгт 2.5

Мониторинг судалгаанд тусгах зүйл

Зорилго	Мониторинг судалгааны агуулга	Арга барил	Хэрэгжүүлэгч
Үр дүнг тодорхойлох	<ul style="list-style-type: none">Бүлгүүдийн бэлчээрээ чөлөөлж. амрааж ашигласан байдалӨвөлжөө, хаваржааны бэлчээрт зэргэлдээх сумдаас орж ирэх малчдын нүүдлийн байдалБүлгүүдийн зүн, намрын бэлчээрийг бэлчээр ашиглалтын байдлыг хянахЗэргэлдээх сумын малчдын бэлчээр ашиглалтын байдал	<ul style="list-style-type: none">АжиглалтАжиглалтАнкетЗэргэлдээх сум, багийн удирдлагаас асуух • Малчидтай ярилцах	<ul style="list-style-type: none">Багийн дарга • Бүлгийн ахлагчБүлгийн гишүүд (Бэлчээр хариуцагч)СумСум
Ургамлын мониторинг	<ul style="list-style-type: none">Ургамалшлын судалгаа хийх (Ургамлын төрөл, гарц зэрэг)	<ul style="list-style-type: none">ХААИС-аас зохион байгуулах	<ul style="list-style-type: none">ХААИС

- (2) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн мониторинг Баруун Баян-Улаан сумын 2-р баг нь 2009 онд анх бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

2009 оны бэлчээр ашиглалтын байдлын талаарх судалгааг малчдаас авав. Судалгаанд 2-р багийн бүх малчид оролцсон. Судалгааг малчид зуны бэлчээр рүү нүүх үед, 7-р сард хийсэн. Судалгаанд хамрагдаж зохистой хариултыг нийт 137өрх айл өгсөн байна.

Хүснэгт 2.6

Судалгааны асуултыг нэгтгэв

Үндсэн мэдээлэл	<ul style="list-style-type: none">Өрхийн толгойлогчийн нэрБүлгийн нэрСудалгаанд хамрагдаж буй үеийн нутаглаж байгаа газар
Малын тоо толгой	<ul style="list-style-type: none">Малын төрөл тус бүрийн тоо толгой
Зун, намрын бэлчээрийг бэлчээр ашиглах байдал	<ul style="list-style-type: none">Зун ашиглах хугацааНамаржаа ашиглах байдалБэлчээрийн нутгийн нэр болон худгийн нэрНүүгээгүй шалтгаан
Хаваржааны бэлчээр ашиглалтын байдал	<ul style="list-style-type: none">Бэлчээрийн нутгийн нэр болон худгийн нэрНүүгээгүй шалтгаан
Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний тухайд	<ul style="list-style-type: none">Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлснээр үр дүн гарсан уу?
ББУ-ХХДулаан сумдын сум хоорондын гэрээний хэрэгжилтийн байдал	<ul style="list-style-type: none">Өшиг уулын ар болон өврийн бэлчээрийг малчид хаврын эхэн сараас 6-р сарын 15 хүртэл ашигланаАндай, Янзангийн бэлчээрийг 7-р сарын 20-оос хойш ашиглахгүйЦагаандэл, Хөхдээрсийн бэлчээрийг үргэлж ашигладаг малчин өрх бэлчээрийг чөлөөлж өнжөөхНуурын эргэн тойрон Зкм-аас дотогш мал бэлчээхгүй байх
Засаг захиргаа ахлагчийн зааварчилгаа	<ul style="list-style-type: none">Аймаг, сум, баг, бүлгийн ахлагчийн зааварчлагаар

(3) Мониторинг судалгааны үр дүн

1) Малын тоо толгой


Хүснэгт 2-7-д судалгаанд хамрагдсан 137 өрхийн нийт малын тоо толгойг үзүүлэв. Малын төрөл тус бүрийн тоо толгойг авч үзвэл хонь 13,802, ямаа 27,849, үхэр 375, адуу 1,028 , тэмээ 153толгой нийт 43,207 толгой байсан. Судалгаанд хамрагдсан 137 өрхөөс мал аж ахуй өрхэлдэг өрх 132 ба үүнээс хонь малладаг нь 127 өрх, ямаа малладаг 131 өрх, Үхэр малладаг 31 өрх, адуу малладаг 101 өрх, тэмээ малладаг 22 өрх байлаа. Нэг өрхөд оногдох маллах малын дундаж үзүүлэлт нь хонь 109 толгой, ямаа 213 толгой, үхэр 12 толгой, адуу 101 толгой, тэмээ 7 толгой ноогдож байна. Хонин толгойд шилжүүлсэн тооцоогоор нийт малын тоо толгой 49,077 байна.

Хүснэгт 2.7

Малчин өрхийн маллаж байгаа малын тоо толгой

	Хонь	Ямаа	Үхэр	Адуу	Тэмээ	Нийт
Нийт тоо толгой	13,802	27,849	375	1,028	153	43,207
Тухайн малыг маллаж буй малчин өрх	127	131	31	101	22	132
1 өрхөд ноогдох малын тоо толгойн дундаж үзүүлэлт	109	213	12	10	7	327
Нийт тоо толгой (Хонин толгойд шилжүүлснээр)	13,802	25,064	2,250	7,196	765	49,077

*Хонин толгойд шилжүүлснээр: хонь-1.0, ямаа-0.9, үхэр-6.0, адuu-7.0, тэмээ-5.0




Судалгаанд хамрагдсан өрхийн нэг өрхөд ноогдох малын тоо толгой (хонин толгойд шилжүүлснээр) –г дээрх хүснэгтэд үзүүлэв. Нэг өрхөд 101-200 толгой мал ноогдож байгаа үзүүлэлт олон байна.

Мөн 101-400 толгой малтай өрх нийт малчин өрхийн 56%-ийг эзэлж байна. Түүнчлэн 1000 толгой малаас илүү малтай малчин өрх 6 байна.

Нэг өрхөд ноогдох малын тоо толгойн үзүүлэлтээс харьцангуй цөөхөн малтай нь

20 толгой, хамгийн олон малтай нь 1,758 толгой малтай байна.




2) Бэлчээрийг ашиглах хугацаа

Зүн, намрын бэлчээрийг бэлчээрийг ашиглах хоногоор ялгаатай өрхийн тоог хүснэгтэд үзүүлэв. Зуны бэлчээрийг 91-120 хоног, намрын бэлчээрийг бэлчээрийг 61-90 хоног ашигладаг өрх олон байна. Зуны бэлчээрийг хамгийн богино хугацаагаар ашигладаг өрх гэхэд л 10 хоног, хамгийн олон хоног ашигладаг малчин

өрх 185 хоног байна. Намрын бэлчээрийг хамгийн богино 28 хоног, хамгийн урт хугацаагаар ашигладаг нь 124 хоног байна. Хүснэгт 2.7-д бэлчээр ашиглах хугацаа (сар) болон малчин өрхийн тоо тус бүрийг үзүүлэв. Зуны бэлчээр ашиглаж байгаа өрхийн тоо 5~8-р сард хамгийн олон байсан ба 25 өрх, 6~8-р сард 23 өрх, 5~9-р сард 18 өрх байсан байна. Малчдаас хамгийн эрт зуны бэлчээрт нүүж ирсэн нь 3-р сарын 7 ба хамгийн орой зуны бэлчээрээс нүүсэн нь 11-р сарын 20 байсан. 2009 оны зуны бэлчээр ашиглах хугацаа дунджаар 5-р сарын 21 байсан. Намрын бэлчээрийг хамгийн олон малчин өрх ашигласан ўе нь 8~11-р сарын хооронд 41 өрх байсан бөгөөд 9~1-р сард 30 өрх, 8~10-р сарын хооронд 13 өрх байна. Хамгийн эрт намрын бэлчээр рүү нүүсэн нь 7-р сарын 30 бөгөөд хамгийн орой намаржаанаас нүүсэн нь 12-р сарын 1 байв.

Хүснэгт 2.8

Зун, намрын бэлчээрийг бэлчээр ашиглах хугацаа болон малчин өрхийн тоо




3) Зун болон намрын бэлчээр ашиглалтын байдал

Зун болон намрын бэлчээрт нүүсэн малчин өрхийн харьцааг доорхи графикт үзүүлэв.

Хавар, намрын бэлчээрт хариулаагүй нэг малчин өрхийг эс тооцвол бүх өрх нүүсэн байна. Зун, намрын бэлчээр рүү нүүсэн малчин өрх 106 ба нийт 77%-тай байна. Нүүгээгүй гэж хариулсан малчин өрх 31.

Зураг 2.7




Зураг 2.6

4) Урьдчилж төлөвлөсөн бэлчээрт нүүж чадаагүй шалтгаан

Урьдчилж төлөвлөсөн бэлчээр рүү нүүж чадаагүй шалтгааны талаарх судалгааг дараах графикт үзүүллээ.

Зуны бэлчээр “Өвс муутай байсан”тэх шалтгаан хамгийн их байсан ба дараа нь “Нүүхээр төлөвлөсөн бэлчээрт хэт олон малчид нүүж очсон байсан”, “Нүүдлийн зардал гарна” гэсэн хариулт олон байна. Намрын бэлчээрийг хувьд “Нүүдлийн зардал зарцуулна”, “Нүүдэггүй малчид байдаг” гэсэн хариулт олон байна. Зуны бэлчээрт нүүгээгүй шалтгааны ихэнх нь өвсний гарцаас шалтгаалж байсан бол намрын бэлчээрийг нүүдлийн хувьд малчид өөрсдийн үзэмжээр нүүх эсэхээ шийддэг нь харагдаж байна.




Зураг 2.7

5) Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хэрэгжилтийн үр дүн

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө хэрэгжилтийн үр дүнг дараах графикт үзүүллэв.

Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд “Хаврын бэлчээрийн өвс сайжирна”, “Баруун Баян-Улаан сумын нутаг дах зуны бэлчээр сайжирна” гэж хариулсан малчин олон байна. “Хайрхандулаан сумын зуны бэлчээр сайжирна”, “Намрын бэлчээр сайжирна” хэмээн

хариулсан малчид ч байгаа боловч бусад зүйлүүдэд малчид хариулаагүй байна. Энэ нь Баруун Баян-Улаан сумын 2-р багийн малчдын хувьд бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг анх удаа хэрэгжүүлж байгаажил боловч ихэнх малчид төлөвлөгөөний дагуу нүүгээгүй нь бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний үр ашгийг бараг мэдрээгүйгээс гэж хэлж болно.




Зураг 2.8

6) Баруун Баян-Улаан болон Хайрхандулаан сумдын сум хоорондын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Баруун Баян-Улаан сумын малчид Хайрхандулаан сумын бэлчээрийг зуны хугацаанд ашиглаж байгаа ба түүнтэй холбогдуулан хоёр сумын хооронд 4 зүйл бүхий гэрээ байгуулсан. Түүний хэрэгжилтийн байдлыг дараах графикт зүйл тус бүр дээр үзүүлэв. Гэрээнд тусгагдсан 4 зүйлийн дотроос “хэрэгжсэн” гэж хариулсан нь нийт малчдын 30%-д ч хүрэхгүй байна.

4-дэх зүйлд “хэрэгжээгүй” гэж хариулсан малчин 47%-67% байгаа нь тус жилийн бэлчээр ашиглалтын тохиролцсон зүйлийн хэрэгжилтийн үзүүлэлт бага байна. Энэ нь эдгээр 2 сум нь сум хоорондын гэрээг харьцангуй орой байгуулсан, мөн гэрээний агуулгыг нийт малчдад сайтар мэдээлж, ойлгуулаагүй зэрэг хүчин зүйл нөлөөлсөн гэж хэлж болно.




Зураг 2.9

7) Засаг захиргаа, удирдлагын зааварчилгаа

Засаг захиргаа, удирдлагын зааварчилгааны талаарх үнэлгээний судалгааг дараах графикт үзүүлэв.

Засаг захиргаа, удирдлагын зааварчилгааны талаар “Багийн удирдлага”-ийг “сайн” гэсэн хариултын үзүүлэлт хамгийн өндөр байна. “Му” гэсэн хариулт хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан нь “Бүлгийн ахлагч”. Багийн удирдлагын сайн гэсэн үнэлгээ хамгийн өндөр байгаа нь малчдад хамгийн ойрхон захиргааны ажилтан гэдэгтэй холбоотой. Түүнчлэн бүлгийн ахлагчийн үнэлгээ хамгийн бага байгаа нь Баруун Баян-Улаан сумын 2-р багийн малчдын нүүдэл бүлэгт хамааралгүй байснаас болов уу гэж үзэж байна.



Зураг 2.11

(4) Хэрэгжилтийн байдалд хийсэн мониторингийг дүгнэхэд

Баруун Баян-Улаан сум бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг энэ жилээс хэрэгжүүлж эхэлж байгаа ба холбогдох сум хоорондын бэлчээр ашиглалтын талаар хамтран хэлэлцээр хийсэн явдал нь өмнө нь бараг хийгдэж байгаагүй зүйл учраас маш том ололт гэж хэлж болно. Ялангуяа малчдын дунд явуулсан судалгаанаас харахад сумын зааварчилгаа, удирдлагыг цаашид сайжруулах шаардлагатай байна.

Гэхдээ хэрэгжилт төлөвлөгөө ёсоор байсангүй. Энэ нь сум хоорондын гэрээ байгуулах зэрэг асуудал оройтоож, түүнийг малчдад сайтар таниулж, мэдээлэх цаг хугацаа маш бага байсантай холбоотой болов уу.

Тарагт сумын мониторинг судалгааны үр дүнгээс харахад ч гэсэн холбогдох хүмүүс бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн ач холбогдолыг ойлгож, мэдэх нь хамгийн чухал гэсэн дүгнэлт гарсан бөгөөд Баруун Баян-Улаан сумын хувьд ч бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг холбогдох хүмүүст сайтар ойлгуулснаар түүний хэрэгжилтийн ач холбогдол дээшлэнэ хэмээн дүгнэж байна.

ТЭМДЭЭГЛЭЛ



Authors

Takeshi MATSUMOTO

Japan International Research Center for Agricultural Sciences (JIRCAS)

Aritsune UEHARA

JIRCAS

Hirofumi IGA

JIRCAS

Yasuo KAMIYA

JIRCAS

Kenichiro KIMURA

JIRCAS

Isamu YAMANAKA

JIRCAS